



**Төгс Гэгээрсэн Их Багш
Чин Хай**



Бүхий л Гай Зовлон Бидний Муу Санаанаас Үүдэлтэй

Энэ орчлонд маш олон адилгүй дэлхий ертөнц байдаг. Манай дэлхийг харагддаг, баригддаг, хүрч авч болдог биет ертөнц гэж нэрлэдэг. Мөн оюун санаагаар бүтээгдсэн өөр бусад ертөнц байдаг ба хамгийн ойр оршихыг нь Астрал ертөнц гэнэ. Ихэнхдээ бидний бодол доод түвшнийх буюу догшин, эсвэл нөгөө л нэг бидний ойлголтын хүрээнд "сайн" гэж юуг хэлэх вэ түүнд харьяалагдаж байдаг. Эдгээр бодлууд маань бидний үл үзэгдэгч орчин гэж нэрлэдэг Астрал хэмээх холгүй орших ертөнцөөр аялан зугаалж байдаг байна.

Заримдаа бид өвчин, халдвар, гай зовлон, дайн дажин, эсвэл гамшигт өртөж байдаг. Эдгээр нь бүхэлдээ газар дэлхий дээрх хүмүүсийн хэрцгий бодол санаанаас үүсч бий болдог юм. Бид "Би хүүхэд байхаасаа л сайн хүн байж сайн үйлс хийсээр ирсэн. Гэтэл яахлаараа ийм эдгэршгүй өвчин тусдаг байна аа", эсвэл "Миний эх орон их сайхан. Хүмүүс их бага хэмжээгээр Бурханд итгэж залбирал үйлддэг. Гэтэл яагаад энэ их гай зовлон биднийг нэрвэж байгаа юм бэ?" гэх зэргээр гомдоллож болохгүй.

Бүх зүйлийн цаана шалтгаан бий. Бид өөрсдөө ч юм уу, эсвэл нутаг нэгтнүүд маань урьд нь, эсвэл яг энэ цаг мөчид муухай бодол сэтгэлдээ тээсэн байж таараа. Муухай бодлууд сэтгэлд үүсэн хэдий биеллээ олохгүй байлаа ч сөрөг энерги нь байсаар байдаг. Тэрхүү сөрөг энерги нь өөрийн гэсэн мэдлэг, оюуны чадамжтай байдаг бололтой, бид тэдгээрийг элемент гэж нэрлэдэг. Гэвч бодол санаанд сүнс байдаггүй тул Бурхны хүчийг агуулдаггүй юм. Тиймээс эрдэм мэдлэгийг, логик тооцоо хийхээс өөр чадваргүй болох сэтгэлгүй компьютертэй харьцуулж болох юм.

Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай
Тайнан, Формоса, 1988 оны 10-р сарын 13
(Хятад хэл дээр)

Гэсэн хэдий ч муу муухай, догшин бодлууд компьютерээс ч илүү хүчтэй. Бид компьютерийг устгаж чадах боловч аюултай бодлыг арилгахад хэцүү юм. Хичнээн хугацаа өнгөрлөө ч тэдгээр бодлууд сэтгэлийн мухарт оршсоор байдаг бөгөөд адилавар соронзон талбайд буй бодлуудтай нэгдсэнээр эрт орой хэзээ боловч тэсрэх аятайхан боломжийг хүлээж энергээ гаргахыг эрмэлзэж байдаг.

Хэрэв бид компьютер хэрэглэхээ боливол, эсвэл маш удаан хугацаагаар хэрэглэвэл өөрөө эвдрэх, эсвэл нэг товчлуур дарангуут шатчихдаг шүү дээ. Бүх хадгалсан материалууд агшин зуур устаж алга болно. Гэвч хэрцгий бодлуудыг арилгах арга байхгүй. Тэд өөрсдөө устаж алга болдоггүй юм. Муу бодол үүссэн цагаасаа баг бөх оршин тогтнож, биднийг болон газар дэлхий, нутаг орон, хот тосгодыг маань бүхэлд нь хүрээлэх үл үзэгдэгч орчин болж хөгждөг. Дараа нь тэд өвчин эмгэг, гай зовлон эсвэл дайн дажин болж хувирдаг.

Өвчин эмгэг гэж юу вэ? Энэ нь муу муухай бодлыг эрж хайн өөрсдийн соронзон талбай руу нэвтрэн орж ирдэг үл үзэгдэгч хүчин юм. Үүнийг бид “яг л таталцах шиг” гэж нэрлэдэг. Энэхүү үл үзэгдэгч хүчин нь чамайг онцгүй зүйл бодохыг цаг үргэлж хүлээн, эсвэл иймэрхүү онцгүй бодол тээх хэн нэгний соронзон талбай руу нэвтэрч байдаг ба учир нь, муу муухай бодол бол тэдний нэвтэрч чадах ганц үүд хаалга нь юм. Ижил төрлийн 2 бодол хоорондоо уусч нэгдэх туйлын хялбар байдгаас гадна бидний соронзон талбай, уураг тархи болон мэдрэлийн систем рүү амархан гэгч нь нэвтрэн орж биеийн эсэргүүцлийг устгадаг. Үүнээс үүдэн бид хорт хавдар тусч, мэдрэлийн ядаргаанд орж, эсвэл урьд хожид дуулдаагүй өвчнөөр өвдөж байдаг юм шүү дээ. Өнгөрсөн амьдралаас үүсэлтэй муу муухай бодлууд бидний гэрлэн бүрхэвчийг гэмтээдэг байж болох агаад урьд өмнө бий болгосон сөрөг үл үзэгдэгч хүчинг өөртөө шингээхээр эргэж буцаж байдаг ажээ.

Тиймээс бид хэнийг ч буруушаах ёсгүй. Бид бүх зүйлсийг бүтээсэн, гэсэн хэдий ч бид муу муухайгаас зайлж чадна. Жишээлбэл, бид бие сэтгэл, бодол үйлдлээ 24 цагийн турш цэвэр ариун байлгаж чадвал муу энерги бидний гэрлэн бүрхэвчинд нэвтрэхгүй болно. Тэс өөр шинж чанартай зүйлс бие биендээ уусч чаддаггүй. Ямар нэгэн тэс өөр зүйл орж ирэх үед ус, тос хоорондоо холилдоггүйтэй адил шууд биеэс хөөн гаргадаг.

Бясаллагчид бид маш их үйлийн үрийг үгүй хийж чаддаг. Хэдийгээр бид өмнөх амьдралууддаа муу муухай бодлыг оюун санаандаа тээсэн байж болох авч одоо бол үгүй юм. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн амьдралууддаа хуримтлуулсан үйлийн үрийн хэмжээг энэ амьдралдаа багасгаж байна гэсэн үг юм. Бидний энд тэнд хааяа нэг загатнах юм уу, өвдөх, эсвэл ганц хоёр хоногоор халуурах зэрэг бага сага өвчний шинж тэмдэг илэрч болох авч хэзээ ч хорт хавдар болж биднийг зовоохгүй. Эсвэл бид жижигхэн осолд орж болно. Магадгүй бидний машин хэмхрэх байх л даа, харин бид үхэхгүй ээ, жаахан гэмтэх ч юм уу, эсвэл энд тэнд бяцхан шалбарах байх.

Тиймээс бид бие биенээ хамгаалья гэвэл энэ дэлхий дээр амьдарч байх үедээ бие сэтгэл, бодол болон үг хэлээ ариусгах ёстой юм шүү дээ. Бид гурван ертөнцөөс салж чадвал ямар ч асуудалгүй болно. Тэнд ямар ч харгис хүчин байхгүй. Хэн ч муу муухай бодлууд тээхгүй. Тэнд зөвхөн ариун хүмүүс л очиж чадна. ✨

Гарчиг



Нийтлэгдсэн: 2006 оны 4 сарын 1
Байгуулагдсан: 1990 оны 4 сарын 1
Нийтэлсэн: Цаглашгүй Дээд Чин Хай
Багшийн олон улсын нийгэмлэг
Нийтлэгч: Сие-Син-лин

Богино зурвас:
Бурхан эмэгтэй, эрэгтэй гэсэн хүйсний маргаанаас зайлсхийдгийг бодолцон Бурхны талаар болон Цаглашгүй дээд оюуны тухайд хүйсний ялгаагүй жинхэнэ анхдагч төлөөний үгийг хэрэглэхийг Багш бидэнд зөвлөсний дагуу дараах төлөөний үгийг ашигласан болно:
She+He=Hes
Her+Him=Hirm
Hers+His=Hiers

Жишээ нь: When God wishes, Hes makes things happen according to Hiers will to suit Hirmself.

Цаглашгүй Дээд Чин Хай Багшийн тогтмол хэвлэл /сонин сэтгүүл/ нь интернэтэд дараах хэл дээр тавигддаг болно: Аулак /Вьетнам/, Хятад /уламжлалт болон хялбарчилсан аль аль хэл дээр/, Англи, Франц, Герман, Индонез, Испани мөн Тайланд. Энэхүү мэдээллийн сонин, сэтгүүлийг Гуань Инь www холбогдох интернэт хуудсуудаас олж үзнэ үү.

2 Багшийн Айлдвар

Бүхий л Гай Зовлон Бидний Муу Санаанаас Үүдэлтэй

4 Гуань Инь ВЭБ сайт

God's Direct Contact

5 Үйл Явдлын Зах Зухаас

Их Британи/Аргентин/АНУ/Формоса

12 Цагаан Хоолтон Гараг Ертөнцийг Бий Болгох нь

Финланд/Коста Рика/Чили/АНУ/Солонгос/Малайз/Формоса/Feedback of Love

26 Онч Мэргэн Үг

Бид бол нэг

27 Багшийн Амьдралын Цонхоор

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай—Энэрэл Нийгүүлсэлийн Хосгүй Үлгэр Жишээ

30/66 Талархлын Захидал

Багшаас Эрхэмсэг Ноён Поол Маккартни болон Хатагтай Хээдэр Миллз Маккартнид бичсэн захидал/Багшаас CNN-ийн Захирал, Сурвалжлагч Нарт Илгээсэн Захидал

31 Багш Айлдахдаа

Төр Засгийн Байгууллагууд ард иргэддээ мах, архи, согтууруулах ундаа болон тамхины хор уршгийн талаар сайтар мэдлэг боловсрол олгох хэрэгтэй.

38 Цагаан Хоолны Эрин Үе

Хүний Амьдралыг Архи, Тамхи ба Мах хэрхэн сүйтгэдэг вэ-нүд хальтармаар дүн

40 Алтан Үеийн Зөнч Хараа

Шинэ Эрин Үе, Шинэ Бодол Санаа, Шинэ Хандлага

44 Тодрон Гялалзах Дэлхийн Хүчит Удирдлагууд

Гэгээрсэн Удирдлага доор Гэрэлт Ирээдүйг Цогцлуулах нь--Канад/Австрали/Коста Рика/Шинэ Зеланд/Словени/Голланд/Дэлхий Маань Ариун Шудрага Амьдралын Хэв Загварыг Сонгон Сэрж Байна/Манай гарагийн агаар ер бусын цэвэрхэн болно

57 Шилэгдмэл Асуулт, Хариулт

Оюун Санааны Бясалгал, Дадал бол Гараг Ертөнцийг Хайрлах Дээд Хэлбэр юм

58 Хайрын Илэрхийлэл

Унгар/АНУ/Солонгос/Пакистан Пакистаны Газар Хөдлөлтөнд Өртсөн Хүмүүст Үзүүлсэн Тусламж /Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай/Филиппин Улс/Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай болон түүний Олон Улсын Нийгэмлэгээс Филиппиний гамшигт өртсөн ард түмэнд хүргэсэн тусламжинд зарцуулсан нийт зардал

67 Хэвлэл Мэдээлэл

Пакистаны Өдрийн Мэдээ Сониноос

71 Тодорхойлолт Захидал

Филиппин Улс

72 Багшийн Хошигнол

Санаанд Оромгүй Төлбөг/Нохойтой Хамт Одсон Номлол!

73 Ахуй Ойлголтоо Дээшлүүлэх нь

Их Баш Чин Хайн Хамгийн Сүүлд Гарсан Шүлгийн Цоморлиг

Гуань Инь вэб сайт

Бурхантай шууд холбогдох — Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн олон улсын вэб хаяг:

<http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

This portal provides a directory of links to Quan Yin Web sites in a variety of languages, as well as 24-hour access to the TV program A Journey through Aesthetic Realms. You may also download multilingual editions of *The Key of Immediate Enlightenment* sample booklet, download or subscribe to *The Supreme Master Ching Hai News* available in eBook or printable format or browse the sites' contents online.

ИХ БРИТАНИЙН НЭГДСЭН ВАНТ УЛС

Сүррейд болсон бэлэг дэмбэрэлтэй үйл явдал

Чэнг Ву, Сүррей (Англи хэл дээр)

[Сүррей] 2006 оны 1-р сарын 2-ны өглөө Сүррейн Бясалгалын Төв дээр Багшийг ирэхийг дуулаад 100 гаруй номын ах эгч нар хамгийн үнэтэй шинэ жилийн бэлгээ авахаар яаран ирсэн байлаа. Багш үнэхээр үзэсгэлэнтэй, амар амгалан харагдаж байсан ба бидэнтэй шөнө болтол хамт байсан юм. Багшийг явсны дараа бид өөрсдийнхөө азтайг гайхаж Багшийн адислалыг хүртсэндээ туйлын баяртай байв. Маргааш өдөр нь Төв дээр 20 хүрэхтэй үгүйтэй хэдхэн хүн ирж нилээд орой болсон хойно үдийн зоог барьцгаан, Багшийн видео хуурцгаас үзэж суутал гэнэт Багш ороод ирэв. Ийнхүү тэр оройг ахин Багшийнхаа адислал доор инээд хөөрөөр дүүрэн шог хошин яриа өрнүүлж өнгөрүүлэв.



Дараагийн бүтэн сайнд нь буюу 1-р сарын 8-ны өдөр Багш Төв дээр дахин хүрэлцэн ирж Төвийн байранд чихцэлдэн цугласан нийт 130-140 орчим номын ах эгч нарыг хайр ивээлээрээ адисласан юм. Тэр өдөр архины хаяг шошгон дээр анхааруулга бичиг тавих ажиллагааг дэмжиж урамшуулах болон архи, тамхи ба мансууруулах бодисны хор уршиг нийгмийн бүхий л цар хүрээг хамран хөгшин залуу, дарга цэрэггүй сүйрүүлж байгааг олон нийтэд таниулах зэргээр дэлхий нийтэд хэрхэн тус нэмэр болох талаар ярилцав.

Түүнчлэн шувууны ханиадны тархалтыг зогсоох үүднээс жигүүртэн шувуудтай хүнлэг бус харьцаж байгаа явдалд Багш туйлын харамсаж буйгаа илэрхийлээд, хүмүүст өрөвч энэрэнгүй амьдралын замналыг сонгон цагаан хоолтон болж, амьтдад сайн сайхан сэтгэлээр хандах ёстойг сануулах хэрэгтэй гэлээ. Тэр ч байтугай номын ах эгч нарт Бурхан чанараа харуулсан буянтай үйлс хийж олон түмэнд санаачлагаараа туслах ёстой гэдгийг бас давхар сануулсан юм. Тэр оройноо Багш биднийг өрөөндөө урин архины хольцгүй оргилуун дарс хуваалцангаа онигоо ярьж цагийг хөгжилтэй өнгөрүүлэв. Мөн хүндтэй үүрэг хүлээж эхэлсэн тэр үед үзэсгэлэнт сайхан байгаль дунд майхан барин, түүндээ энгийн амьдралаар амьдарч хичнээн жаргалтай байснаа ярьсан юм. Ийнхүү биднийг бяцхан групп бүрдүүлэн хотын амьдралаас түр ч атугай холдож, үзэсгэлэнт газрууд руу яван байгалийн тансаг сүр жавхлан, амар амгалан дунд бясалгамаар болтол хүсэл төрүүлж, сайхан дурсамжаасаа хуваалцав. Багш байх үед манай Төвийн энерги маш хүчтэй байсан төдийгүй бид бүгдээрээ Багшийн сайхан дурсамж, тэнгэрлэг мөрөөдөл дунд умбаж үнэхээр жаргалтай байлаа. Харамсалтай нь Багш явахгүй бол болохгүй нь хэмээн удаа дараалан сануулж, хэдий Багшийг үлдээхийн тулд бид чадах ядахаараа ятгахыг оролдсон ч маргааш өглөө нь буцсан юм. Тэр мөчид бид бүхэнд Багшийнхаа хосгүй гоо үзэсгэлэн, агуу их хайр энэрлийн илэрхийлэл болох чин хүсэл төрж байлаа! ✨

АРГЕНТИНААС ИРСЭН МЭДЭЭ

Багшийн адислалаар дүүрэн газрын диваажин



Сильвиа, Анибал нарын бэлтгэсэн мэдээ,
Буэнос Аэрос (Испани хэлээр)

[Посадас, Мишионэс] Мишионес бол сүр жавхлантай Игүаз хүрхрээ урсдаг, баян тансаг, өвөрмөц ургамалтай, мөн галт уулын улаан хөрстэй Парагвай болон Бразил улстай хиллэдэг, Аргентиний зүүн хойд зүгт орших үзэсгэлэн төгөлдөр байгалтай нутаг юм. 2006 оны 2-р

сарын 8-нд тус мужийн нийслэл болох Посадаст Буэнос Аэрос хотоос авшигтнууд ирж, видео семинар зохион байгуулан Багшийн адислалыг хүртээжээ.

Энэхүү бэлэг дэмбэрэлтэй сайхан үйл явдал Висенте Сидаде соёлын төвд болсон бөгөөд тэр үед техникийн ажилчид нь амралттай, эзгүй байсан тул тус төвийн захирал ноён Бенито Дел Пүэрто видео семинарыг өөрийн биеэр хариуцан явуулжээ. Мөн авшигтнудаас ярилцлага авсан орон нутгийн Мишионэс FM радио, ТВ 6 болон Эл Территорио ба Примера Эдишион сониноос хүрэлцэн ирсэн сурвалжлагч нарын өгөөмөр сэтгэл, илтөд байдал, сайхан зан чанар нь авшигтнуудад үнэхээр их урам зориг өгсөн юм. Семинар найрсаг сайхан болж өнгөрсөн төдийгүй Багшийг амьтны эрх ашгийг хамгаалах тухай болон амьтдыг эмнэлгийн

ба косметик судалгаанд ашиглахгүй байх талаар ярьж эхлэхэд үзэгчид гэнэт алга ташиж байлаа. Дараа нь семинарт оролцсон нийт хүмүүсийн тал орчим хувь нь Дөхөм аргад суралцсан бөгөөд зарим хүмүүс төрөлхийн өндөр ахуйн ойлголттой байсан төдийгүй тэдний дундаас нэгэн хүү авшигтнууд дээр ирж : “Өнөөдөр Есүс намайг явуулсан юм” гэж хэлжээ. Мөн өөрийнхөө амьдралаас залхаж шаналсан нэгэн эмэгтэй дөхөмийн бясалгалын үеэр Багшийн хайр энэрлийн хүчинд тайвширсан байна.

Маргааш өдөр нь шинэ номын ах эгч нар нэгэн Дөхөм аргаар бясалгагчийн гэрт уригдан очсон бөгөөд бясалгалын тухай сонирхсон асуултандаа хариулт авч, хамтаар бясалгал хийхийг ихэд таашаажээ. Посадаст болсон видео семинарт оролцсон бүх авшигтнууд Их Багшдаа тус хотыг болон Мишионэсийн номын ах эгч нарыг хайр энэрлээрээ адислаж, газар дээр диваажинг бий болгон, авшигтнуудад бусдад туслах боломж олгосон явдалд чин зүрхнээсээ талархсан байна. ✨

Америкаас ирсэн мэдээ



Сар шинийн баярыг угтаж хайр энэрлээр дүүрэн ариун гэгээлэг амьдралыг сурталчлах нь

Дайана Нгүен, Хьюстон (Англиар)

[Хьюстон, Техас] Техасын Хьюстон хот бол соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах болон олон улсын баяр наадам тэмдэглэдэгээрээ алдартай газар билээ. Жишээ нь, жил бүрийн сар шинийн баяраар Ази бүжиг, Вьетнамын алдартай хөгжимчдийн тоглолт болон бусад сонирхолтой үзүүлбэрүүдээс бүрдсэн соёл урлагийн томоохон арга хэмжээ байнга зохион явуулдаг байна. Жил ирэх тусам оролцогчдын тоо нэмэгдэж байдаг тул энэ жилийн ёслолын ажиллагааг спонсорууд Хьюстон Техасчуудын (мэргэжлийн хөл бөмбөгийн баг) гэр болох Рэлайнт Арэна хэмээх спортын том цогцолборт зохион байгуулжээ. Энэ жил нутгийн авшигтнууд баярын арга хэмжээнд оролцож өөрсдийн байрласан павильонд том дэлгэц, прожектор зоон Багшийн видео бичлэгүүд, концерт, буяны ажлууд болон гамшигт нэрвэгдсэн газруудад хүргэсэн тусламжийн ажиллагааны бичлэгүүдийг олонд үзүүлсэн байна. Авшигтнуудын павильон цогцолборын бүх хэсэг рүү хүрч болох буюу баярын ажиллагааны хамгийн гоё үзүүлбэрүүд байрласан хэсэгтэй маш ойрхон зайнд байсан нь бэлэг дэмбэрэлтэй явдал болсон юм. Мөн зохион байгуулагчдын зүгээс элгэмсгээр хандаж, Багшийн болон Арьяабалын Номын Цогцсын Бясалгалын

Аргын талаарх мэдээлэлтэй зурагт хуудсыг 3000 гаруй хувилж хүмүүст тараасан нь урьд нь болж байгаагүй явдал байлаа.

2006 оны 1-р сарын 29 буюу баяр болсон өдөр Хьюстон болон Аустины хэсэг бүлэг номын ах эгч нар өглөөний бясалгалын дараа спортын цогцолборт шууд хүрч очин бэлтгэл ажиллагааг дуусгасан ба удалгүй хөл бөмбөгийн талбай руу урсан орж ирсэн тоо томшгүй олон хүмүүсийг баяртайгаар угтан авчээ.

Баярын өдөрлөгт тусгайлан захиалсан мэт нар ээсэн сайхан өдөр болж авшигтнууд маань ч халуун дулаан, элгэмсэг дотно орчин бий болгохын тулд хичээнгүйлэн ажиллаж байсан юм. Түүнчлэн, Багшийн үзэсгэлэнтэй зургийг харсан хүмүүс удтал ширтэн зогсож олон асуулт асууж байв. Авшигтан ах эгч нар бүгдээрээ зочдын сонирхсон асуултанд хариулт өгөх, Багшийн “Цагаан хоолтон байхын ач тус”, “Жинхэнэ баатрууд” видео бичлэгүүдийг “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудас болон үлгэр дэвтрийн хамт зочдод бэлэглэх зэргээр их тус болов. Бэлгийг хүлээн авсан зочид маш их талархаж зарим нь бүр үнэ хөлсийг нь төлье гэлцэхэд авшигтнууд эелдгээр татгалзан “Энэ бол Бурханаас илгээсэн бэлэг!” хэмээн тайлбарласан юм. Харин зарим зочид Багшийн тухай нилээд мэдлэгтэй байсан төдийгүй ажлын багийнхантай хөгжилтэй сайхан яриа өрнүүлж, улмаар бүхэл өдрийн турш үргэлжилсэн энэхүү тохиол хүн бүрийг Тэнгэрийн орны баяр баясгалан, амар амгалан дунд умбуулах шиг болжээ.

Ийнхүү 2006 оны Сар Шинийн Баярт хүрэлцэн ирсэн Хьюстон болон Аустин хотын авшигтнууд Багшийн ном сургаалийг дэлгэрүүлэх үйлст оролцох боломж олгосон явдалд туйлын их талархаж, олон хүмүүс Багшийн хайр энэрлийг хүртсэн гэдэгт итгэлтэй байлаа. Түүнчлэн, Багшийнхаа тэнгэрлэг үйлст үргэлжлүүлэн гар бие хайрлахгүй оролцож, ном сургаалийг тань олон түмэнд дэлгэрүүлэх болно гэдгээ амласан юм. ✨

Бурханы Ивээл доор амжилттай явагдсан Номын Үзэсгэлэн

Тайпэйн мэдээний багаас (Хятад хэл дээр)

[Тайпэй] 2006 оны 2-р сарын 7-12-ны хооронд Тайпэйн Дэлхийн Худалдааны Төв (ТДХТ) дээр 14 дэх удаагийн Тайпэйн Олон Улсын Номын Үзэсгэлэн (ТОУНУ) гарч, нийт 440,000 (хамгийн дээд үзүүлэлт) гаруй хүн үзэж сонирхжээ. Өмнөх жилүүдэд тус ажиллагааны үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн компани (ТГИБЧХОУНХК) өөрийн павильонд “Дотоод гэрлээ олох нь—Амьдралаа өнгөлөг болгох нь” сэдвийн доор үзэсгэлэн гаргаж байжээ.



Хэвлэлийн компанийн павильон өөрийн гэсэн өвөрмөц стилистэй харагдаж байсан ба Багшийн томоос том зургийг шинэхэн цэцэг, хөөрхөн хэлбэртэй шаазан амьтдаар алаглуулан чимэглэсэн нь олны харааг булааж, олон олон зочид, мэргэжлийн хүмүүс ирж сонирхон, зураг



дарж байлаа. Мөн номын ах эгч нар Багшийн ном сургаал дэлгэрүүлэх болон ариун энэрэнгүй, эрүүл энх амьдралыг сурталчлах зэрэг олон олон санаачлага бүхий үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон. Жишээ нь, 2-р сарын 9-ний өглөө Тайпэй дэх их сургууль, коллежийн хэсэг бүлэг авшигтнууд амьтны баг хувцас өмсч, ТДХТ-өөр явцгаан, хүмүүст “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тараахад жаахан хүүхдүүд тэдэнтэй тэврэлдэж, мөн зургаа авахуулж байлаа. Үдээс хойш Үзэсгэлэнгийн гол талбай дээр авшигтнууд сэтгэл хөдлөм үйл явдал зохион

байгуулсан нь, “Салхины Өнгө” дууг ардын дуу дуулаач хатагтай Зэнг Шү-кин туршлагатай хөгжимчин- продюссер авшигтан эгч Ванг-ийн хамтаар хоршин дуулснаар эхэлсэн юм. Дараа нь “Хөгжмийн эгшиглэнд амар амгаланг олохуйяа... Нэг Дэлхий,” нэртэй концертын бичлэгийг Багшийн Зочид Буудал нэртэй Амьдрал (Фресно, Калифорни, АНУ. 2001 он) видео бичлэгийн хамтаар дараалуулан үзүүлжээ. Тэнд байлцсан өөр аргаар бясалгагч хэд хэдэн зочид хүртэл халуун дулаан энерги мэдэрлээ гэлцэж, Багшийн дуу хоолой, ярианд сэтгэл нь хөдлөн, улмаар Дөхөм аргад суралцжээ. 2 сарын 11-ний үдээс хойш алдартай телевизийн хөтлөгч, ноён Давид Вү, Багшийн ном товхимлыг худалдан авсан зочдод зориулан (2006 оны нохой жилтэй холбоотой) Шинэ Жилийн хэдэн мөрт бичжээ.

Тэмдэглүүштэй нь, Их Багшийн хэвлэлийн компани тус үйл явдалд оролцсоноор номын барилдлагатай олон сайхан хүмүүст оюун санааны дадал бясалгалын мөр хөөх замналыг эхлүүлж өгсөн нь лавтай. Жишээ нь, Буддын ном тарни уншигч, ноён Яанг гуай үзэсгэлэн үзэхээр ажлаа тараад шууд иржээ. Тэрбээр Багшийн Гоо Зүйн Ертөнцөөр Аялах нь нэвтрүүлгийг телевизээр үзээд Дөхөм аргад суралцахаар шийдэн уг үзэсгэлэнд ирсэн байна. Шөнөжингөө ажиллаад ядарсан ноён Яанг, дөхөм аргын бясалгалын дараа маш их энергээр цэнэглэгдсэнээ мэдэрсэн төдийгүй Арьяабалын Номын Цогцсын Бясалгалын аргын гайхамшигт хүчийг бишрээд барахгүй байв!

Тайландад амьдардаг Франц авшигтан ахаас түүхий мацаг хоолны тухай мэдэж авсан нэгэн зочин Формосад англи хэл заахаар иржээ. Ийнхүү Тайпейн бясалгагч нарт түүхий ногооны хоол хийхийг заах үедээ тэрбээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг болон Арьяабалын Номын Цогцсыг бясалгагч гэр бүлийн талаар маш өндөр сэтгэгдэлтэй болсон байна. Улмаар Багшийн ном сургаалийн

талаар илүү их мэдээлэл олж авахаар буюу Дөхөм Аргад суралцахаар үзэсгэлэнд хүрэлцэн ирсэн бөгөөд авшигтан ах эгч нарт хандан: “Би Багшийн амьд амьтдыг хайрлах агуу сэтгэлийг үнэхээр хүндэлж биширч явдаг. Багшийн ном сургаалд хамгийн гол нь цагаан хоолтон байхын ач холбогдлыг илүүд чухалчилж үздэг болов уу гэж бодох юм.” гэж хэлжээ. Хэдэн сарын туршид мацаг барьсан тэрбээр Сэтгэлийн Авшиг хүртэхийг хүсэж буй бөгөөд удахгүй номын авшигтан ах болох болно.

Мөн 2-р сарын 10-ны үдээс хойш Тайландаас нэгэн өндөр, том бадриун биетэй хуврага Багшийн DVD бичлэгүүдийг үзэхээр үзэсгэлэнд ирсэн ба Багшийг сүүлийн 20-иод жилийн турш ном сургаалиа дэлгэрүүлсээр ирсэн төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт шавь нартай гэдгийг дуулаад бүр гайхаж биширч байв. Нэгэн авшигтан эгч түүнд Арьяабалын номын цогцсыг бясалгагчид насаараа мацаг барьж 5 сахилыг нарийн чанд сахих ёстой гэж тайлбарлахад тэрбээр хариулсан нь: “Би 5 сахилаа сахидаг боловч мацаг барьдаггүй ” гэжээ. Дараа нь хэсэг зуур бодсоны эцэст ламтан Дөхөм аргад



суралцахаар шийдсэн ба Дөхөм аргын бясалгалын дараа авшигтнуудын байрласан павильонд эргэн ирж номын эгчид хэлсэн нь: “Бясалгалын үеэр, хэдхэн минутын өмнө би Багшийн томоо гэгчийн ногоон малгай өмссөн гэрлэн бие миний зүг чиглэн ирж байхыг харлаа. Тэгээд Багш маань миний дотор оршиж буйг мэдэрлээ.” гэв.

2003 оны ТОНУ-д Ираны Шабавиз хэвлэлийн компаниас хатагтай Фаридэх Калатвбарий гуай ирж оролцон Дөхөм аргад суралцаж байжээ. Нутаг буцсаны дараагаар ч тэрбээр бясалгалаа хичээнгүйлэн үргэлжлүүлэн Бурханд ойр байж, улмаар амьдралд нь олон сайхан гайхамшигтай үйл явдал тохиосон байна. 2006 оны үзэсгэлэнд дахин оролцохоор ирсэн хатагтай Фаридэх Калатвбарий гуай “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг харсан даруйд сайн дураараа Иран хэл рүү хөрвүүлэн, улмаар эх орондоо аваачиж, нутаг нэгтнүүддээ түгээн амьдралын хэв маяг, хооллолтыг нь

жаахан ч атугай өөрчлөх итгэл найдварыг сэтгэл зүрхэндээ тээж буй аж.

Үзэсгэлэнгийн сүүлийн өдөр хажуугийн павильонд ажиллаж байсан Христийн шашны миссионер нэгэн дунд эргэм насны эмэгтэй Багшийн Хэвлэлийн компанийн павильонд ирж ийнхүү хэлсэн нь: “Үзэсгэлэн эхэлсэн цагаас л би ажиглалаа л даа. Арьяабалын Номын Цогцсыг бясалгагчдын баг бүрэлдэхүүн та бүхэн үнэхээр өөр юм.” гэжээ. Тэрбээр 6 өдрийн турш нарийн ажигласны эцэст үзэсгэлэнгийн хаалгын өдрийн үдээс хойш Дөхөм Аргад суралцахаар шийдэн ирсэн ба: “Миний Бурхан зөвхөн миний зүрхэнд бий” гэж хэлжээ. Харин авшигтан эгч түүнд хариулсан нь: “Таны зүрхэнд таны Бурхан байгаа гэдэг тань бидний Бурхантай адил юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүн бидэнд Арьяабалын Номын Цогцсыг уламжилж Бурхантай дахин холбож өгдөг юм шүү дээ.” гэжээ. Бясалгалын дараа уг эмэгтэй Бурхны хүчийг мэдрээд зогсоогүй, билгийн нүдний талаар ихэд сонирхож шинжлэх ухаанаар хэрхэн тайлбарладаг тухай мэдэхийг хүсч байлаа. Харин авшигтан эгч түүнд өөрөө сайтар уншиж ойлгохын сацуу, номын барилдлагатай олон сайхан хүмүүстэй хуваалцаарай хэмээн Багшийн Амьдралаа Өнгөлөг Болгох нь номыг бэлэглэжээ.

2-р сарын 12-нд Тайпэйн Олон Улсын Үзэсгэлэн Үнэн Ёсыг хуваалцах нь ажиллагаагаар ёслол төгөлдөр дууслаа. Уг арга хэмжээгээр нийт 50 гаруй хүн Дөхөм аргад суралцаж дотоод чанараа танин мэдэрсэн сайхан тохиол болов. Мөн номын ах эгч нар үзэсгэлэнгийн үеэр нийт 100,000 гаруй хүмүүст “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг тараасан ба хүмүүсийн олонх нь уншиж танилцсан даруйд хамаатан садан, ах дүү болон найз нартаа өгөхөөр илүү хувь авахыг хүсчээ.

Ийнхүү Гуравдагч Алтан Жилийн 2 дугаар сарын турш Тайпэй хотод номын хурбууж, оюун санааны арвин баялаг ургац хураасан, ирсэн зочид болон номын ах эгч нарт ач тусаа өгсөн тэмдэглүүштэй сайхан үйл явдал боллоо. Харин авшигтнуудын хувьд ариун сүнснүүдийг амьд сэрүүн Их Багштай уулзуулж, үйлийн үрээ гэтэлгэх замд нь хөтлөж, олон түмэнд эрүүл энх, ариун энэрэнгүй амьдралыг таниулах буянт үйлст гар бие оролцсон нь Бурхнаас хайрласан хамгийн дээд шагнал байлаа. ✨

Кинмэн дэхь дэнлүүний баяр 2006: Орчлон ертөнцийг гэрэлтүүлэх тэнгэрлэг гэрэл гэгээ

Кинмэний мэдээний багаас (Хятад хэл дээр)

[Кинмэн] 2006 оны 2-р сарын 12-ноос 14-ний хооронд Формосагийн далайн эргээс холгүй орших Кинмэн арал дээр жил бүр зохиогддог Дэнлүүний баярыг тэмдэглэсэн байна. Кинмэний Соёлын Харилцааны Товчооноос Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн салбар Төвийг энэхүү “Орчлон ертөнцийн тэнгэрлэг гэрэл гэгээ” сэдэвт ёслолын үйл ажиллагаанд дахин оролцохыг урьжээ.

Уг ёслолын баяр тус арлын эртний түүх дурсгалт газар болох соёлын музейд зохиогдсон байна. Авшигтнууд музейг Багшийн Лонгвити дэнлүүгээр гоёмсог гэгч нь чимэглэсэн ба үзэсгэлэнт дэнлүүнүүд нэг нэгээрээ асч эхлэхэд Багшийн урласан уран зургууд, өнгө алагласан хөшигнүүд болон нутгийн ойн аж ахуйн албаныхны дэлгэн тавьсан бутлаг моднуудыг

гайхамшигтайгаар гэрэлтүүлж байжээ. Мөн музейн хаалганы хоёр талд болон саравчинд Зул сарын гэрлийг эгнүүлэн тавьсан нь Багшийн Лонгвити дэнлүүний тэнгэрлэг гэрэлтэй хоршин өнгө, гэрэл хосолсон далай мэт харагдаж байв. Энэхүү гайхамшигт үзүүлэнг бишрэн сонирхсон соёлын музейн ажилчид Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүр жавхланг магтаад барахгүй байв! Дэнлүү асаах ёслолын үйл ажиллагаа эхлэхийн өмнө Кинмэн арлын эрхэмсэг шүүгч Ли-Жу-Фэнг гэргий болон бусад албаны хүмүүсийн хамт хүрэлцэн ирсэн бөгөөд хамгийн түрүүнд Чин Хай Багшийн Олон Улсын Нийгэмлэгээс гаргасан үзэсгэлэнгийн хэсэг рүү явж очсон төдийгүй Багшийн урласан бүтээл болгоныг намтрын хамтаар ихэд сайшаан сонирхсон байна.

Тэрбээр Багшийн “Надад хүсэл мөрөөдөл бий” хэмээх зурвастай зургийн өмнө ирүүт удаан гэгч нь хөдөлгөөнгүй ширтэн зогссон бөгөөд улмаар Соёлын Товчооны захирал эрхэмсэг шүүгчид “Ноёнтоон, бид Дэнлүү асаах ёслолоос хоцрох нээ” хэмээн сануулахад хүрчээ. Харин эрхэмсэг шүүгч Ли зурагнаас дурамжханаар холдон авшигтнуудтай гар барьсны дараагаар хэлсэн нь: “Би дараа дахин ирнэ ээ”, мөн нэмж “Та бүхэн үнэхээр шургуу ажиллажээ! Маш их хүч чармайлт гаргасан байна!” гэв. Дараа нь Дэнлүү Асаах Ёслолын ажиллагааны үеэр ноён Ли хэлэхдээ “Энэ жилийн Дэнлүүний баярт маш олон багууд, нэн ялангуяа Формосаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн нийгэмлэгийн гишүүд болох бидний сайн андууд хол зам туулан ирж оролцсон явдалд талархлаа илэрхийлмээр байна. Бидний уламжлалт баярт маань ийнхүү хоёрдахь удаагаа ирж оролцож буй бөгөөд олон сайхан бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргасан байхыг харлаа.” гэв. Мөн Багшийн хэлсэн “Надад хүсэл мөрөөдөл бий,” мэргэн үгнээс иш татан хэлсэн нь: “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хэлсэнчлэн, эх дэлхий маань ямар ч аллагагүй, мөнхийн амар амгалан дунд оршиж, бидний хойч ирээдүй хүүхдүүд маань аюулгүй тайван орчинд өсч торних болно гэдэгт би найдаж явдаг.” гэжээ. Дэнлүү Асаах Ёслолын дараа шүүгч Ли эхнэрийн хамтаар Багшийн Нийгэмлэгээс гаргасан үзэсгэлэнг дахин очиж сонирхсон бөгөөд мөн





“Урт удаан амьдрал” нэртэй Лонгвити Дэнлүү хүүхдүүдэд маш их таалагдаж, томчуул өндрөөр үнэлж байсан юм.

авшигтнуудтай цуг зургаа авахуулжээ. Дараа нь тэр хоёр бясалгагчдын босгосон Хүсэл Биелүүлэгч Модон дээр очиж бяцхан цаасан дээр чин сэтгэлийнхээ угаас: “Айл бүхэн аюулгүй, хүн бүхэн эрүүл энх байг” хэмээн бичиж үлдээжээ.

Нутгийн олон олон оршин суугчид Их Багшийн Олон Улсын Нийгэмлэгээс гаргасан үзэсгэлэнг үзэж сонирхон, сэтгэл нь хөдөлж, тун дурамжхан орхин явж байсан.

“Их Багшийн урласан Лонгвити Дэнлүүний загвар дэлхий дээр цорын ганц бий!” хэмээн нэгэн зочин бүр хөөрөн уулга алдаж байлаа. Мөн хэсэг хүмүүс Багшийн алгаа хавсарсан фото зургийн өмнө зогсон “Надад мөрөөдөл бий” хэмээн зөөлхөнөөр давтан хэлж байв. Өнгө өнгийн чулуу шигтгэн сийлсэн хөөрхөн яст мэлхийний хэлбэртэй

Дөхөм аргад суралцах болон Авшиг авахыг хүссэн байна. Түүгээр ч зогсохгүй авшигтнууд Их Багшийн “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг хэдэн мянгаар нь хувиалан тараахад ирсэн зочид баяртайгаар хүлээн авсан бөгөөд зарим нь бүр Багшийн үлгэр дэвтэр болон Мэдээ сэтгүүлийн дугааруудыг авахыг хүсэн цагаан хоолны талаар зөвлөгөө өгөөч ээ хэмээжээ. Ийнхүү Формоса, Кинмэн ба Хятадаас ирсэн авшигтнуудын хамтын ажиллагааны үр дүнд Багшийн Нийгэмлэгээс гаргасан үзэсгэлэн амжилттай боллоо. Багшийн Лонгвити дэнлүүг бахдан шагшсан зочдын сэтгэлд билэг ухаан, хайрын гэрэл бадамлан ассан бизээ гэдэгт найдаж байна. ✨

EVENT DATE BOOK

To keep pace with the planet's ongoing spiritual elevation, the local centers of The Supreme Master Ching Hai International Association are holding more and more video seminars and other Truth-sharing events.

You are welcome to join in these activities with your friends and relatives.

For the latest schedule of our activities, please visit the following URLs:

http://www.Godsdirectcontact.org.tw/eng/latest_news/events-datebook.htm



Цагаан хоолтон гараг ертөнцийг бий болгох нь

Багшийн Нигүүлсэнгүй Сэтгэлийн Үгсийг Дэлхий Нийтээрээ Хуваалцах нь

‘Өөрөөр Амьдарцгаая’

Хүн амьтны дунд давтагдан гарч буй аюумшигт өвчинд сэтгэл нь зовнисон Багш дэлхий нийтээрээ уг асуудлыг үндсээр нь устгах боломж бүхий шийдэлтэй “Өөрөөр Амьдарцгаая” нэртэй зурагт хуудсыг зохион бүтээн, түүндээ дэлхий нийтэд тулгамдаж буй эмчилгээний хямралаас гарахын тулд ан амьтдыг хороодгоо зогсоон, цагаан хоолтон болж ариун амьдралыг сонгон, гэмгүй амьтдыг аварч болохыг хүмүүст сануулсан утга санааг илэрхийлсэн аж. Мөн бүхий л авшигтнуудад дэлхийн өнцөг булан бүрт буй номын ах эгч нартаа энэхүү сэтгэлийн үгсийг дуулгахыг зааварчилгаа болгожээ. Хариуд нь авшигтнууд Багшийнхаа хайр энэрлийн үгсийг олон түмэнд түгээх их аяныг эхлүүлсэн байна. Олон улс оронд явагдсан тус аянтай холбоотой баримт мэдээллийг доор дурьдав.

ФИНЛЯНДААС ИРСЭН МЭДЭЭ

Багшийн эхлүүлсэн “*Ан Амьтнаа Аварцгаая*”

хөдөлгөөн болон *Цагаан хоолтон амьдралын хэв маяг*-ийг сурталчлах нь

Жусси Похжолайнэн, Хельсинк

[Хельсинк] Багшийн “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг хүлээн авсан Финлянд авшигтнууд ан амьтдын амийг аврах төслийг даруй эхлүүлэн, уг зурагт хуудсыг олон түмэнд тараахаар хэдэн мянган хувь хэвлүүлсэн байна.

Авшигтнууд зурагт хуудсыг Финляндын хэд хэдэн хотууд мөн нийслэл Хельсинкийн олон нийтийн газруудын зар мэдээллийн самбар, номын сангууд, кафенууд, их сургуулиуд, их дэлгүүрүүд, хүнсний дэлгүүрүүд ба бусад газруудад нааж, хажуугаар өнгөрөх хүмүүст цагаан хоолтон байхын ач тус, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө болон ан амьтдыг хэрхэн аварч болох талаар мэдээлэл олгохыг зорьжээ. Гоё зурагт хуудас энд тэнд нааж явахад, олон газрын хүмүүст ихэд таалагдсан ба зурагт хуудас наах боломжгүй байсан нэгэн газрын эзэн авшигтнуудад элгэмсэг хандаж, улмаар нааж болох тохиромжит газруудын талаар зөвлөгөө өгсөн аж.

Төслийг эхлүүлэх үед зөвхөн хэдхэн авшигтнууд гар бие оролцсон боловч одоогийн байдлаар хөдөлгөөнд олон олон номын ах эгч нар баяртайгаар нэгдэж, Багшийнхаа хайр энэрлийг олонд хүргэх буянт үйлст хувь нэмрээ оруулж байна. ✨



КОСТА РИКАГААС ИРСЭН МЭДЭЭ

Нигүүлсэнгүй амьдралын төлөө *Гэмгүй хүн амьтдын амийг аврах нь*

Лаура Чэн, Сан Жоүз (Испани хэл дээр)

[Сан Жоүз] Ан амьтдын амийг аварч, дэлхий нийтэд заналхийлж буй аюумшигт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс Ариун Амьдралаар амьдрах нь уриан доор эхлүүлсэн Багшийн санаачлагыг урамшуулан дэмжсэн Коста Рикийн авшигтнууд 2006 оны 2-р сард “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг лавлах ном ашиглан очих газраа сонгож олон түмэнд түгээж эхэлсэн байна. Авшигтнууд эхлээд Сан Жоүз хотыг зорьсон боловч, дараа нь хүн ам ихтэй хэд хэдэн хотуудаар явж, сүүлдээ хөдөө орон нутгийг хүртэл өргөн хүрээгээр хамарч чаджээ.



Ажлын багийнхан материалыг янз бүрийн хэлбэрээр олон түмэнд хүргэсэн ба үүнд, автобусны буудал, банк, цэцэрлэгт хүрээлэн, дэлгүүр хоршооны газар, АТМ машинууд мөн соёл урлаг болон спортын арга хэмжээгээр биечлэн явж тараажээ. Тухайлбал, машин тээврийн хэрэгсэл дээр, шуудангийн хайрцаг, их дэлгүүр, нийтийн зарлалын самбар дээр, цагаан хоолны хүнсний дэлгүүр, нарийн боовны дэлгүүр, эмийн сан болон бусад газруудад нааж үлдээсэн байна. Мөн хятад хэлээр гардаг нэгэн сэтгүүлийн дугаарт нийтлүүлж, ажлынхаа газрын хүмүүст хувилан тараан, э-шуудангаар гэр бүлийнхэн болон найз нөхөддөө хүртэл илгээжээ.

Эцэст нь хэлэхэд, номын ах эгч нар Панама, Гондурас болон Никарагуа дахь авшигтнуудад “Өөрөөр Амьдарцгаая” ухуулах хуудсыг давхар илгээж байгаа бөгөөд мөн Коста Рикийн хэд хэдэн орон нутгийн сонин сэтгүүлд хэвлүүлэхээр зэхэж буй юм. Зурагт хуудсыг тараах газрууд олшрох тусам, мөн олон түмэнд хэрхэн хүргэх талаар шинэлэг санаа олох тусам авшигтнууд баяртайгаар төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Багшийн ном сургаал амьдрал дээр хэрэгжиж байгаад туйлын сэтгэл хангалуун байгаа ажээ. ✨

ЧИЛЭЭС ИРСЭН МЭДЭЭ

Эрүүл энх амьдралыг сурталчлах нь

Сантьягогийн мэдээний багаас, Чили (Испани хэл дээр)

[Сантьяго] 2006 оны 2-р сарын 18 буюу хагас сайны өдөр Сантьягогийн төв дээр нийтийн бясалгал хийсний дараа хүч орсон авшигтнууд хотоор нэг явж, “Өөрөөр Амьдарцгаая”



зурагт хуудсыг түргэн зуур тараасан ба хүмүүний болон бидний хөөрхөн найзууд болох гэмгүй амьтдын амьдралд өнгө нэмж байгаадаа туйлын баяртай байлаа. Багшийн хайр ивээлийн ачаар зурагт хуудсыг амжилттай тарааж дуусгасан юм. Мөн Сантиагогаас цаг хагас явж хүрэх Ранкагуа хотын оршин суугчдыг зурагт хуудсаар дарсан байна. Улмаар тус 2 хотын бясалгалын төвийн хамт олон интернэтэд зурагт хуудсыг тавьж, холбогдох мэдээллийг цацан найз нөхөд болон гэр бүлийнхэндээ э-шуудангаар илгээжээ.

Шавь бидэндээ энэ хүү сайхан хүндтэй үүрэг хүлээлгэсэн Багш тандаа маш их баярлалаа.

АНУ-С ИРСЭН МЭДЭЭ

‘Өөрөөр Амьдарцгаая’ Уриа Шинэ Жилд Итгэл Найдвар Авчирлаа

Сан Жоүзийн мэдээний багаас (Англи хэл дээр)



[Сан Жоүз, Калифори] 2006 оны 1-р сарын 29-ний өдөр Сан Жоүзийн номын ах эгч нар 2 давхар баяр тэмдэглэж, “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг олон түмэнд түгээн Сар шинийн баяраа угтлаа. Эхнийх нь Сан Жоүзэд болсон Шинэ Жилийн баярын жагсаал байсан ба авшигтнууд хэдэн зуун зурагт хуудас энгэртээ тэврэн олны дундуур явж тараан, зарим нь хоёр хоёроороо салж гудамжаар яван хүмүүст өгч байлаа. Тэр оройноо жагсаал дууссаны дараа хэдэн номын эгч нар Сар Шинийн Баярын Үзэсгэлэн рүү явж ажиллагааг үргэлжлүүлжээ. Ийнхүү тус баярын өдөр номын ах эгч нар нийтдээ 5,000 гаруй зурагт хуудас олон түмэнд хүргэсэн

байна.

Түүнчлэн, 2-р сарын 4 - 5-нд болж өнгөрсөн, жил бүр тэмдэглэдэг Сан Жоүзийн 24 дэх удаагийн Шинэ Жилийн Баярын өдөрлөгийн үеэр авшигтнуудын зохион байгуулсан арга хэмжээг нийт 50,000 гаруй хүмүүс үзэж сонирхжээ. Гол хаалгаар орж ирэх зочдыг авшигтнууд инээмсэглэн угтаж, “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг тараан өгч байсан юм. Авшигтнуудын байрласан павильоны хажууд шахуу урлаг соёл болон спортын арга хэмжээнд зориулан засаж, зөндөө олон сандал тавьсан, томоо гэгчийн талбай байсан байна. Арга хэмжээний үеэр олон хүмүүс тайзан дээр болж байсан тоглолт шоуг үзэж сонирхохын оронд Багшийн хайр энэрэл, гоо үзэсгэлэнгийн нөлөөллөөр авшигтнуудын павильон руу өөрийн эрхгүй татагдан, сандлаа эргүүлж тавьж суугаад Багшийн видео бичлэгийг удаанаар үзжээ.

Хажуугийн павильонд гаргасан үзэсгэлэн дээр ажиллаж байсан нэгэн залуу эр



авшигтнуудын павильонд байн байн ирж: “Манай ээж саяхан Сан Жоүзэд нүүж ирсэн юм л даа, тэгээд дээх нь радиогоор Багшийн яриаг сонссон юм билээ. Тэрнээс хойш ээж маань зөвхөн мацаг барихыг хүсэх болсон.” гэж хэлсэн байна. Ийнхүү нөгөөх сүсэгтэй залуу маань ээждээ зориулж шинэ жилийн бэлэг болгон Дээд Зэргийн Гал Тогоо нэртэй хоолны ном худалдан авчээ. Тус залуу эр болон өөр бусад олон хүмүүс нааштай хандаж байсан нь үнэхээр сэтгэл хөдөлмөөр байв. Жишээ нь, нэгэн хос хоёр хэлсэн нь: “Бид долоо хоног тутам гардаг Багшийн нэвтрүүлгийг үзэх их дуртай. Болдог бол өдөр болгон ном сургаалийг нь сонсох юмсан гэж хүсдэг шүү.” гэжээ. Түүгээр ч барахгүй олон хүмүүс Багшийн уянгалаг хоолойгоор Вьетнам хэл дээр уншсан шүлгийг нь сонсоод, үнэхээр сэтгэл сэргэх шиг боллоо гэлцэж байсан бөгөөд харин яагаад тийм онцгой мэдрэмж төрснийг тайлбарлаж чадахгүй байв. Улмаар Дөхөм аргаар бясалгагч нэгэн номын ах олон сайхан зүйл ярьсан төдийгүй түүний хэлснээр: “Би заримдаа бясалгаж байгаад самадид орчихдог, бүр 2-оос илүү цаг үргэлжилсэн байдаг ч, надад хэдхэн минут болсон юм шиг л санагддаг.” гэжээ. Түүнийг дотоод Бурхан чанар нь сэтгэлийн авшиг хүртэх цаг чинь болсон хэмээн байнга сануулж байгаа нь тэр байх, мөн Багш бол түүнийг Бурхны оронд аваачиж чадах цорын ганц Төгс Гэгээрсэн Багш юм гэдгийг сайтар ойлгосон нь лавтай. Тийм ч учраас Сэтгэлийн



Авшиг хүртэх тэр нэгэн сайхан өдрийг баяртайгаар хүлээж байгаа ажээ.

Түүнчлэн, баярт хүрэлцэн ирсэн олон олон зочид гийчид Багшийн ном сургаалийг интернэт, радио, телевизээр болон семинар, өдөрлөг ба олон нийтийн арга хэмжээнд оролцох зэргээр сонсож мэдэн, Багшийн ачлалыг хүртсэн хэмээж байлаа. Багш маань бидний зүрх сэтгэлд үргэлж бидэнтэй хамт оршиж, өдөр бүрийг итгэл найдвар, баяр баяслаар дүүргэж байдаг гэдгийг хүмүүсийн яриа тод харуулсан юм. Мөнхийн хаврыг бидэндээ авчирсан хайрт Багшдаа баярлалаа! 

‘Энэрэнгүй Хэрэглээ’

Вай -Мэ, Лос Анжелос (Англи хэл дээр)

[Лос Анжелос, Калифорни] Лос Анжелосийн авшигтнууд Багшаас “Өөрөөр Амьдарцгаая” уриаг олон түмэнд хүргэх заавар хүлээн авсан даруйд Өмнөд Калифорнд очиж ажиллагааг эхлүүлжээ. Учир нь, тус нутгийн оршин суугчдын тоо 17,000,000 хол давснаас гадна, хэрвээ хүн амын төвлөрөлт ихтэй газраас ажиллагааг эхлэн бөөн бөөнөөр нь шуудангаар явуулбал, богино хугацаанд олон хүнд хүргэж болох ашигтай талтай гэдгийг авшигтнууд тооцоолсон аж. Ийнхүү 2006 оны 2-р сарын 15-ны байдлаар 613,000 хувийг Пэнни Сейвэрт (орон нутгийн бизнес зар сонин) нийтэлж, бүс нутгийн хэмжээнд хэдэн дүүрэг сонгон шуудангаар илгээжээ. Мөн Оранж Каунтийн Бүртгэл сонинны 2006 оны 2-р сарын 12-ны дугаарын “Эрүүл мэнд ба Гэр Бүл” буланд уг зурагт нүүрийг нийтэлсэн



ба ирэх хэдэн долоо хоногт өөр бусад хэд хэдэн сонинд нийтлүүлэхээр зэхэж буй юм. Түүнчилэн Ирвин дэхь Калифорнийн Их Сургуулиас эрхлэн гаргадаг Шинэ Их Сургууль сонин мөн Хантингтоны Вэст Коллежийн Баруунаас Ургах Наран сонин зэрэг хэд хэдэн сургууль, коллежийн сонингуудад Багшийн уриаг нийтэлжээ. Авшигтнууд сонин хэвлэл ашиглахаас гадна өөр бусад хэлбэрээр ч мөн адил олон түмэнд хүргэхийг зорьсон байна. Жишээ нь, нэгэн номын ах интернэтийн вэб хуудсаар АНУ-ын 40 гаруй хотуудыг хамарч чадах хэмжээнд үнэгүй цацаж өгчээ. Өөр нэгэн авшигтан сургууль, коллеж, орон сууцны зар мэдээллийн самбар дээр болон айл гэрийн шуудангийн хайрцгуудад наасан байна.

Мөн Лос Анжелос хот даяар нийт 395,000 гаруй өнгөт зурагт хуудсыг биечлэн явж тараав. Жишээ нь, 2006 оны 2-р сарын 4-ний өдөр буюу Сар Шинийн Баярын үеэр авшигтнууд Лос Анжелос хотын захын дүүрэг Эл Монтэ-д очиж тараасан байна. Ийнхүү Лос Анжелосийн номын ах эгч нар янз бүрийн арга хэлбэрээр Багшийнхаа Энэрэнгүй Хэрэглээг уриалсан сэтгэлийн үгсийг олон түмэнд хүргэхийг хичээн, улмаар эрүүл энх амьдралын талаарх хүмүүсийн ойлголтыг дээшлүүлэхэд зорьж, хүн төрөлхтний болон бидний найзууд болох ан амьтдын амьдралд гэрэл гэгээ нэмж байна. Мөн хүмүүсийг найз нөхөд болон гэр бүлийнхээ гишүүддээ үлгэр жишээ болж, энэрэнгүй амьдрахыг уриалж байгаа ажээ. “Өөрөөр амьдарцгаая” урианд хэлсэнчлэн, “Амьтны амь хороохыг таслан зогсоож, эрүүл энх, сайн сайхан амьдарцгаая.”

Хэрвээ бид илүү ухамсартай, бусдад халамжтай байх юм бол бидний ирээдүй ч гэрэл гэгээтэй болох болно. ✨

***Бурхны сэтгэлийн үгсийг* олон түмэнд янз бүрийн хэлбэрээр хүргэх нь**

Аустин ба Сан Антониогийн мэдээний багаас

[Аустин/Сан Антонио, Техас] Аустин болон Сан Антониогийн авшигтнууд Багшаас “Өөрөөр Амьдарцгаая” уриаг аль болох олон хүнд хүргэх даалгаврыг хүлээн авсан даруйд зурагт хуудсыг 70,000 гаруй хувилж 30,000 гаруй хувийг нийтийн номын сангууд, хүнсний их дэлгүүрүүд, цагаан хоолны зоогийн газрууд, эрүүл хүнс худалдаалдаг дэлгүүрүүд болон сургуулиудад түгээсэн байна.

Улмаар номын ах эгч нар материалыг их дэлгүүрүүд, машины зогсоол болон гудамжаар, мөн хаалганаас хаалга тогшин явж тараав. Дээрхээс гадна Тиенг Виет ба U.S. Виет Таймс зэрэг орон нутгийн сонин хэвлэлүүдэд нийтлүүлсэн байна. Нэгэн авшигтан “Өөрөөр Амьдарцгаая” уриаг хүмүүс холоос хараад уншиж болохуйц том хэмжээгээр маш гоёмсог самбар болгон бүтээж, зурагт хуудас гадуур тараахаар явах болгондоо биедээ авч явжээ.

Мөн номын ах эгч нар Багшийн уриаг интернэтийн олон олон вэб хуудас, хэлэлцүүлэг нүүрнүүдэд тавьсан байна. Тухайлбал, нилээд нэртэй нэгэн хэлэлцүүлэг хуудаснаас



Багшийн уриаг 1.5-хан өдрийн дотор хэдэн мянган хүн уншиж танилцсан төдийгүй олон хүн дэмжиж буйгаа илэрхийлээд, сэтгэгдлээ бичиж үлдээсэн ажээ.

Ийнхүү Аустин болон Сан Антониогийн авшигтнууд Багшийн дэлхий нийтээрээ энэрэнгүй байж, амьдралаа өөрчлөхийг уриалсан сэтгэлийн үгсийг бусадтай хуваалцаж буйдаа Бурханд талархан, цаашид ч энэхүү буянтай үйлст баяртайгаар оролцох болно хэмээн мэдэгдсэн байна. ✨

СОЛОНГОСООС ИРСЭН МЭДЭЭ

Энэрэнгүй хооллолтыг дэмжих олон талт хандлага

Сөүл, Бусаны мэдээний багаас (Солонгос хэл дээр)

[Сөүл/Бусан] Солонгос авшигтнууд Багшаас Ариун Амьдралыг сурталчлах уриаг олон түмэнд хүргэх даалгаврыг хүлээн авсны дараа, “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг нийт 970,000 орчим хувилан, янз бүрийн хэлбэрээр, 2-хон сарын дотор тарааж дуусгажээ. Түүнчлэн, Сар Шинийн Баяраар хэсэг авшигтнууд гэртээ харих замдаа, төмөр замын буудал болон экспресс автобусны буудлуудаар хүртэл тарааж амжив. Харин бусад нь ажлаа тараад гэртээ харих замдаа, мөн өөрийн амьдардаг хот тосгондоо өдөр тутам олон түмэнд түгээж байжээ.

Бусаны авшигтнууд хурдны замын мөнгө хураадаг цэгүүд дээр зурагт хуудсыг тараах тухай Солонгосын Хурдны Замын Корпорациас зөвшөөрөл хүсч, холбогдох мэргэжилтэнтэй уулзаж ярилцсан ба уг ажиллагаа нь ямар нэгэн бизнесийн ашиг сонирхол байхгүй, зөвхөн амьдралыг хүндэтгэх үзлийг олон түмэнд таниулах зорилготой юм хэмээн тайлбарлахад уг мэргэжилтэн дуртайяа зөвшөөрөл олгосон байна.

Мөн интернэтээр худалдаа хийдэг авшигтнууд зарагдсан бараа бүтээгдэхүүнийг худалдан авагсад шуудангаар илгээх бүрт “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг давхар хавсаргаж байсан бол сургуульд багшилдаг авшигтнууд сургуулийнхаа зар мэдээллийн самбарт нааж, харин гэрийн эзэгтэй авшигтнууд их дэлгүүр болон үзэсгэлэнгээр, улмаар



Initiates performing in cute animal costumes attract many passersby.

баг болж хуваагдан метроны буудлуудаар өдөр бүр ээлжлэн явж тарааж байжээ. Гайхалтай нь уг ажиллагааны үеэр номын ах эгч нарт олон сайхан үйл явдал тохиолдсон байна. Жишээ нь, “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсан дээрх хөөрхөн



амьтдын зургийг хүүхдүүд хараад маш их өхөөрдөн, томчуул утга санааг нь дэмжин, уг материалыг хэвлэн тараах ажлыг зохион байгуулсан хүмүүсийн талаар зарим нэг зүйл сонирхон асууж, мөн Багшийн болон Арьяабалын бясалгалын аргын тухай тодорхой мэдээлэл авахыг хүсч байв. Харин илүү мэдээлэл авахыг хүссэн хүмүүст авшигтнууд Багшийн үлгэр дэвтрийг бусад товхимлуудын хамт дагуулан өгчээ.

Авшигтнуудын ашигласан өөр нэгэн тун ашигтай мэдээллийн хэрэгсэл бол Интернэт байсан бөгөөд “Өөрөөр Амьдарцгаая” зурагт нүүрийг олон тооны хоүмпэйж, вэб хуудаст тавьж, улмаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар буюу ноён ерөнхийлөгчийн амьдарч, алба ажлаа явуулдаг Цэнхэр Ордон мөн Эрүүл Мэнд, Нийгмийн Халамжийн Яамнаас эрхлэн гаргадаг мэдээ сонинуудад тус тус хүргүүлжээ. Түүгээр ч зогсохгүй, “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсын арын нүүрэн дээр Цагаан Хоолтон Нобелийн шагналтан эрдэмтдийн нэрсийг жагсаасан нь, авшигтнуудын сэдсэн гайхалтай санаа байсан бөгөөд олон Солонгосчуудад ихэд таалагдсан төдийгүй дунд сургуулийн хүүхдүүдийн боловсролд ч хэрэгтэй мэдээлэл болжээ. Жишээ нь, Юүк Залуу Үс Төвийн ерөнхийлөгч, БН Солонгос улсын ерөнхийлөгч асаны охин, хатагтай Парк Сео-Яанг “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг хараад маш мэдээлэл сайтай болжээ гэж дүгнэхийн сацуу өөрийнхөө Төвийн 600 гаруй хүүхдүүдэд заавал тарааж өгнө хэмээн хэлсэн байна. Тус Хүүхдийн Төв 1970 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн ажээ.

1-р сарын 26-нд хэсэг авшигтнууд Сөүл хотын төвд болсон цагаан хоолтой холбоотой нэгэн цугларалтанд “Өөрөөр Амьдарцгаая” уриан доор Багшийн ном сургаал дэлгэрүүлэхээр хүрч очжээ. Авшигтнууд том том баннэр хийлгэж, түүндээ яагаад цагаан хоолтон болох тухай шалтгааныг жагсаан, мөн “Өөрөөр Амьдарцгаая” зурагт нүүрийг цагаан хоолтон Нобелийн шагналтнуудын нэртэй хамт том плакат болгон хэвлүүлж авч явсан байна. Мөн авшигтнууд шар буурцагны махаар төрөл бүрийн амтат хоол хийж, цуглаанд хүрэлцэн ирсэн хүмүүсийг дайлан, махыг орлох хоол хүнсний олон зүйл материал байдаг юм шүү гэдгийг мэдүүлэхийг оролджээ. Зарим нэг хүмүүс авшигтнуудын дайлсан хоолыг махтай байна хэмээн андуурч байсан ба харин шар буурцагны махаар хийсэн гэдгийг мэдээд үнэхээр гайхсан төдийгүй хоол тэдэнд маш их таалагдсан байна. Жишээ нь, нэгэн залуу эр: “Надад цагаан хоол таалагддаг л даа, гэхдээ биедээ зохих ёсны уураг авахын тулд би хааяа мах иддэг.” гэж хэлжээ. Харин шар буурцагны маханд жинхэнэ махнаас дутахааргүй хэмжээний уураг агуулагдаж байдаг гэдгийг сонсоод үнэхээр сайн юм боллоо хэмээн баярлаж байв.



Бас нэгэн бизнес эрхлэгч эмэгтэй: “Би тахианы мах байна гэж бодсон шүү. Үнэхээр амттай юм аа, хүмүүст маш их таалагдана даа. Мах холестрол ихтэй тул биед муу. Харин энэ бол шар буурцагнаас гаргаж авсан уураг тул ярих юмгүй сайн гэсэн үг. Та бүхэн үнэхээр буянтай ажил хийж яваа юм байна. Энэ бүхнийг санаачилсан явдалд баярлалаа. Би Юунгсан буудалд дэлгүүртэй л дээ. Маш их хөл хөдөлгөөнтэй газар. Би та бүхнийг манай дэлгүүрт очиж сурталчилгаагаа хийгээч ээ гэж урих байна. Энэ бол бид бүхний эрүүл мэндэд маш тустай зүйл, тийм үү?” гэв.



Ийнхүү авшигтнууд маань “Өөрөөр Амьдарцгаая” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж олон түмэнд хүргэхийн тулд өөр бусад зохимжит хэлбэрийг ашиглан, жишээ нь, нохой, гахай, тахиа болон үхэр зэрэг амьтны баг хувцас худалдан авч өмсөөд гудамжаар явцгаан, хажуугаар өнгөрөх хүмүүсийн нүдийг хужирлаж, тэдэнтэй мэндэлж байсан ба харин амьтанд хайртай зарим нэг хүмүүс өөрийн эрхгүй сонирхолдоо автан авшигтнууд дээр ирж байжээ. Түүнчлэн, амьтны баг хувцас өмссөн авшигтнууд олон нийтэд, хүмүүс яагаад цагаан хоолтон байх ёстой тухай яриа хийж, мөн амьтад, хүмүүс биднээс болж хэрхэн зовж шаналдгийг харуулсан бяцхан жүжигчилсэн тоглолт тоглож үзүүлсэн байна. Тус аяны үеэр Багшийн ивээл доор Монголоос алдартай дуучин нэгэн авшигтан эгч зочлон ирж олон сайхан дууг Англи болон Монгол хэлээр дуулж сонирхуулжээ. Дуу хөгжим тус арга хэмжээг маш цоглог болгож, олон олон хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөсөн төдийгүй, улмаар “Өөрөөр Амьдарцгаая” уриаг урьд урьдаас илүү сонирхож эхэлсэн байна. Солонгос авшигтан эх эгч нар маань “Өөрөөр Амьдарцгаая” зурагт нүүрийг олон түмэнд хүргэхийн тулд маш олон бүтээлч санааг олж сэдсэн төдийгүй хамгийн гол нь хүмүүст цагаан хоолтон байхын ач тусыг таниулахыг ихэд хичээсэн юм. Аливаа амьтдын амьдралыг эрх тэгш хүндэтгэх ариун үйлст бие сэтгэлээрээ зүтгэх нь тэдний хувьд сэтгэлийн агуу их баяр баясгалан бөгөөд цаашид ч урам зоригтойгоор Багшийнхаа эхлүүлсэн энэхүү аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр зорьж буй ажээ. ✨

МАЛАЙЗААС ИРСЭН МЭДЭЭ

Олон түмэн “Өөрөөр Амьдарцгаая” уриаг сайхан хүлээж авлаа

Пэнангийн мэдээний багаас

[Пэнанг] Цагаан хоолтон байхын ач буяныг дэлхий нийтэд таниулах үүднээс ариун энэрэнгүй амьдралыг сурталчлах тухай Багшийн тавьсан хүсэлтийн дагуу 2006 оны 2-р сард Малайзийн Пэнанг дахь төвийн авшигтнууд “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг хувиараа болон группээрээ явж олон түмэнд хүргэж эхэлсэн байна. Пэнанг бол Хятад, Энэтхэг үндэстнүүд голчлон амьдардаг томоохон хот бөгөөд хүн амын ихэнх нь Мусульман шашны үзэл баримтлалыг дагаж мөрддөг аж. Энэхүү амар амгалан орчин бүрдсэн сайхан хотод авшигтнууд Малайя, Хятад, Англи болон бусад Малайзын хэл дээр хөрвүүлэн хэвлэсэн “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг хүн ам ихтэй дүүргүүдээр явж тараажээ.

Мөн том том их дэлгүүрүүд болон жижиг дэлгүүрүүдээр явж тараасны дараа авшигтнууд Пэнангийн Төв Эмнэлэгт хүрч очсон ба тэнд олон олон өвчтөнгүүд цагаан хоол буюу эрүүл хооллолтыг сонгон, амьдралынхаа хэвшмэл хэв маягийг өөрчлөх сонирхолтой болохыг анзаарчээ. Эмнэлэг дээр олон





тооны өвчтөнгүүд, эмч сувилагч нар зурагт хуудсыг маш их сонирхож байсан ба тун богинохон хугацаанд буюу 20-хон минутын дотор Багшийн маань сэтгэлийн үгс “Өөрөөр Амьдарцгаая” уриагаар дамжин олон хүний зүрх сэтгэлд хүрч очих шиг санагдсан. Гайхалтай нь, олон хүмүүс тус урианы агуулгыг дэмжиж буйгаа илэрхийлж эрхий хуруугаа гозойлгож байлаа. Мөн нэгэн цагаан хоолтон эмч баяртайгаар хэлсэн нь, “Та бүхэн сурталчилгааг илүү сайн хийх хэрэгтэй. Бас энэ сайхан, гэгээлэг мэдээллээр манай эмнэлэгт шуурга тавьж , орвонгоор нь эргүүлэх хэрэгтэй!” гэжээ.

Дараа нь Сар Шинийн Баяраас долоо хоногийн хойно буюу 2006 оны 2-р сарын 10 - 11-ний хооронд Хиндү шашны Цагаан Хоолны Баяр Дхайпусамд тохиосон ба уг баярын арга хэмжээг үзэж сонирхохоор нийт 600,000 гаруй зочид гийчид, гадны жуулчид Пэнангийн Хүхрээ, Жоржтаун нэртэй газарт цугласан байна. Тэр хавийн бүхий л замын хөдөлгөөнийг хааж, ямар нэгэн машин тээврийн хэрэгсэл явахыг хориглосон байсан ба сунгасан мэт урт замын 2 талаар цагаан хоол, ундаа тавьсан жижиг тэргэнцрүүд эгнүүлэн тавьж, хүмүүс олноороо хөлхөлдөн явж баярлаж байв. Баярын арга хэмжээний үеэр авшигтнууд тоо томшгүй олон зурагт хуудас хүмүүсийн хүртээл болгож чадсан ба уужим бодолтой олон сайхан нутаг нэгтэн Малайзчууд нь ариун энэрэнгүй амьдралыг сонгон, цагаан хоолтон болж, хүмүүн төрөлхтний болон ан амьтдын амьдралд гэрэл гэгээ нэмэх бизээ гэдэгт чин сэтгэлээсээ итгэж найдаж буй аж. ✨

Багшийн “Өөрөөр Амьдарцгаая” уриан доор хайр энэрлийг хилийн чанадад хуваалцах нь

Формосагийн мэдээний багуудаас (Хятад хэл дээр)

Багшийнхаа нийгүүлсэнгүй сэтгэлийн үгсийг дэлхий нийтэд хүргэх үүднээс Формосагийн авшигтнууд, тэдний арлын хөрш улс орнуудаар “Өөрөөр Амьдарцгаая” уриаг сурталчлан түгээж, мөн 2006 оны 1 - 2 саруудад бясалгалын төв байдаггүй газрууд болох Бангладеш, Египет, Фижи, Гуам болон Кампучид биечлэн очиж, холбогдох материалыг тараасан төдийгүй, нутгийн ардуудын зүгээс асар их дэмжлэг үзүүлж, авшигтнуудын буянт үйлсийг өндрөөр үнэлж сайшаасан байна.



БАНГЛАДЕШААС ИРСЭН МЭДЭЭ

Бангладеш бол Энэтхэгийн зүүн хойд хэсэгтэй хиллэн Боршдог, хүн ам шигүү суурьшсан газар нутагтай улс орны нэг билээ. Жуулчид тэр болгон дурлаад байдаг газар биш тул авшигтнууд тус газар нутгийн талаар зөвлөгөө авахаар Бангладешт бизнес эрхэлж амьдардаг, тайвань үндэстэн, ноён Бианд хандсан ба харин Биан гуай тэдэнд маш том тус хүргэж, 1-р сарын 27-нд нийслэл Така хотын Зиа онгоцны



буудлаас тосч аван зочид буудалд хүргэж өгчээ. Маргааш өглөө нь авшигтнууд цаг бага, унаа тээврийн асуудал хүнд байсан тул юуны түрүүнд 30 сая хүн амьдардаг нийслэл Така болон Бангладешийн 2 дахь том хот болох Читагонг хэмээх далайн боомт хотод материал тараах төлөвлөгөө гаргасан байна. Авшигтнуудын хамгийн эхний зочилсон газар бол Такагийн Их Сургууль байсан ба хүрч очсон даруйд 2 баг болон хуваагдаж, тохиолдлоор эмнэлгийн коллежийг сонгон зорьсон эхний багт 2 эмнэлгийн ажилтан явж таарчээ. Авшигтнуудын тарааж явсан материалыг Бангладешийн ирээдүйн эмч сувилагч нар анхааралтай гэгч нь уншиж байхыг харсан багийнханд Багшийн маань зохиосон зурагт хуудас хүмүүсийн амьдралд маш том нөлөө үзүүлэхнээ гэсэн сэтгэгдэл төрсөн байна. Ийнхүү дараа дараачийн коллежууд руу үргэлжлүүлэн явж материал тараах явцад авшигтнууд нилээд хэдэн багш, профессор болон хуульчидтай уулзсан бөгөөд зөвхөн хайр энэрэл, эрүүл энхийг бэлгэдсэн амьдралыг хүмүүст сурталчлахын тулд авшигтнууд ийм хол зам туулан ирсэнд тэд бүр гайхаж бишрэн, элгэмсгээр нэрийн хуудсаа өгч: “Бид найзууддаа баяртайгаар энэхүү зурагт хуудсыг өгөх болно.” гэж хэлжээ. Бангладешт жуулчид ховор ирдэг тул нутгийн хүмүүс авшигтнуудыг хараад маш их сонирхон тэдний хаанаас ирснийг асууж, мөн тарааж буй материал ямар утгатай болохыг хэлж өгөхийг хүсчээ. Авшигтнуудын зорьж ирсэн сэтгэл, эрхэм зорилго ариун энэрэнгүй болохыг нутгийн ардууд мэдээд ихэд уяран, идэвх зүтгэлийг нь үнэлж, зарим нь элгэмсгээр гар барьж, Бурхны сэтгэлийн үгсийн илэрхийлэл болгон алгаа цээжиндээ наан: “Бурхан таныг ивээг.” хэмээн хэлж байсан юм. Түүнчлэн, Багшийн ариун санааг дэмжсэн хэсэг оюутнууд сайн дураараа ажиллагаанд оролцож, зурагт нүүрийг хүмүүст тараан, агуулгыг нь тайлбарлаж байсан ба мөн өөрсдийнхөө э-шуудангийн хаягийг авшигтнуудад өгч, Багшийн болон Нийгэмлэгийн талаар мэдээлэл авч байхыг хүсчээ. Авшигтнуудын 2 дахь багийнхан хүн олноор цуглардаг хар зах мэт газрууд руу явж материалыг тараасан бөгөөд авшигтан эгч зурагт нүүрийн агуулгыг тайлбарлахад нэгэн настай эмэгтэй ирж номын эгчийг тэврэн авч хэлсэн нь: “Та үнэхээр гайхамшигтай! Та бүхэн ийм сайхан үнэтэй сэтгэлийн үгс авчирсан байна шүү дээ!” гэжээ. Зарим хүмүүс зурагт нүүрэн дээр байгаа гахайн зураг яагаад “Би танд хайртай!” гэсэн юм болоо гэж гайхахад авшигтнууд: Намайг оройн зоогныхоо ширэнд тавиагүйд баярлалаа гэж байгаа нь тэр юмаа хэмээн тайлбарлан өгч, асуусан хүмүүсийг ихэд инээлгэв.

Гурав дахь өдрөө авшигтнууд Така хотын төвөөр явж автобусны буудал, их дэлгүүр хавиар бөөгнөрөн эргэлдэх олон

олон хүмүүст тараажээ. Ийнхүү 2-хон цагийн дотор хэдэн мянган хувийг тарааж амжив. Зарим нэг цагдаа нар зурагт нүүрийг маш ихээр сонирхон уншиж, харин хэсэг бүлэг хүүхдүүд авшигтнуудад тусалж, хэн нэгэнд зурагт хуудас өгөлгүй өнгөрөөчих вий хэмээн санаа тавьж байлаа. Ихэнх тохиолдолд явган хүмүүс эсрэг талаас аймаар урсгалтай замын хөдөлгөөнийг хайхралгүй туулан гарч ирэн, эсвэл бүр холоос авшигтнуудыг зорин ирж зурагт хуудсыг авч байсан юм. Ажиллагааны үеэр нэгэн авшигтан ах хэлсэн нь, “Энэ бүхнийг зүүдэндээ харсан шиг санагдах юм,” гэхэд бас нэгэн авшигтан эгч адилавтар утгатай зүйл хэлжээ. Үүнээс харахад энэхүү аяллыг Бурхан урьдчилаад төлөвлөчихсөн байжээ!

Авшигтнууд Така хотод ажлаа дуусгасны дараа Читагонг хотыг зорьсон бөгөөд далайн эрэг хавиар цугласан байсан маш олон хүмүүст материалыг агшин зуур тарааж дууссан нь үнэхээр гайхамшигтай





үзэгдэл болов. Дараа нь Читагонгийн Их сургууль руу явсан ба тэнд хэдэн оюутнууд тусалж, авшигтнуудыг сургуулийн удирдлагын байр луу аваачин материал тараасан төдийгүй улмаар захирлын өрөөнд уригдаж сүүтэй цайгаар дайлуулжээ. Тэр үед сургуулийн байр руу тоо томшгүй олон оюутнууд орж ирж тааран, зурагт хуудас ч хоромхон агшинд дууссан байна. Авшигтнууд Бангладешд байхдаа сонин уншигчдын талаар судалгаа явуулж дунд болон дундаас дээш зэрэглэлийн хүмүүс л Англи хэл дээр нийтлэгддэг өдөр тутмын сонин захиалж уншдаг, харин хүн амын олонхийг бүрдүүлэгч буюу дундаас доош болон доод зэрэглэлийн хүмүүс зөвхөн Бенгали хэл дээр гардаг орон нутгийн сонин захиалж унших санхүүгийн чадвартай гэдгийг олж мэдэв. Тиймээс авшигтнууд англи хэл дээр нийтлэгддэг сонингийн нүүрэн дээр “Өөрөөр Амьдарцгаая” уриаг тавихаар шийдэж, харин зурагт хуудас хэлбэрээр нь Бенгали хэлээр хэдэн мянган хувийг хэвлэж гаргахаар шийдсэн ба орон даяар тараах ажлыг ноён Биан болон түүний найзууд хариуцахаар болжээ. Ийнхүү Бангладешд хийсэн авшигтнуудын аялал үнэхээр гайхамшигтай сайхан, санамсаргүй явдлуудаар дүүрэн болж өндөрлөсөн ба номын ах эгч нар бүгдээрээ Багшийнхаа агуу хайр халамжийг цаг ямагт мэдэрч байсан гэдгээ хэлж, тэд үнэхээр Бурхны зэмсэг юм

байна гэдгээ сайтар ойлгосон байна. “Өөрөөр Амьдарцгаая” уриа олон олон Бангладеш хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч, цагаан хоолтон байхын ач тусыг ухаарсан байх хэмээн авшигтнууд итгэхийн сацуу олон хүмүүс зурагт хуудсанд өгөгдсөн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн албан ёсны вэб хуудасны хаягаар зочлон Арьяабалын Бясалгалын Аргын талаар өргөн мэдлэгтэй болж, соён гэгээрэн, улс орноо тэнгэрлэг гэрлээр гэрэлтүүлнэ гэдэгт найдаж байгаа аж.

ЕГИПЕТЭЭС ИРСЭН МЭДЭЭ

2-р сарын 4 ба 11-нд авшигтнууд 2 хуваагдан Египетийг зорьжээ. Замд гарахаас өмнө багийн гишүүд Египет хүмүүс, нутгийн зан заншил болон цаг агаарыг сайтар судалсан хэдий ч маш хүнд аялал байх болно гэдгийг мэдэрч байсан ба “Бурхан бүгдийг зохицуулдаг” гэдэгт итгэн, санаагаа шулуутган аяллаа эхэлжээ.

Авшигтнуудын аяллын албанаас тэдний онгоцны билет, зочид буудлын өрөө зэргийг захиалж, харин онгоцны буудлаас зочид буудал руугаа явж хүрэх унааны асуудлыг зохицуулж чадаагүй байна. Азаар авшигтнууд онгоцноос буусан даруйд маш санамсаргүй байдлаар Формосаас ирсэн нэгэн аяллын хөтөчтэй таарч, аврагч маань ч номын ах эгч нарт зочид буудалдаа хүрэх унаа болон нутгийн хөтөч олж өгсөн байна. Авшигтнууд ч Бурхандаа зөндөө талархав. Дараагийн нэгэн тааламжтай явдал бол авшигтнуудын буусан буудлын эзэн номын ах эгч нарт санаа тавин аяллын талаар үнэтэй зөвлөгөө өгч, улмаар буудлынхаа PR менежерээр тэдний төлөвлөснөөс илүү зохимжит аяллын маршрут гаргаж өгөхийг даалгасан ба авшигтнууд ч дуртайяа зөвшөөрөхийн сацуу Бурхандаа энэ бүхнийг зохицуулж өгсөн явдалд дахин талархлаа илэрхийлэв. Эхний багийнхан Каирийн ойролцоо буудалласан бол харин хоёрдох багийнхан хойд зүгт орших Александра мөн өмнө зүгт орших Асван ба Луксор луу тус тус явсан байна. 2-р сарын 5-нд эхний багийнхан Каирийн хамгийн их хөл хөдөлгөөнтэй зах болох Мэйдэн ал-Атабах талбайд зурагт хуудсыг тараасан ба хүмүүс маш сайхан хүлээн авч зарим нь бүр олон дундаас авшигтнуудыг хайн ирж байлаа. Тийнхүү 1 цагийн дотор 3,000 гаруй зурагт хуудас тарааж дуусгав. Дараа нь Каирийн их сургуулийн хажуугаар өнгөрч явтал үүдэнд нь зөндөө олон хүн цугласан байхыг хараад тэнд түр саатаж, 3 хэсэгт хуваагдан, хамгийн их хүн байгаа цэгээс эхлэн тараасан бөгөөд Египетчүүдийн нөгөө л зоригтой мөртөө сониуч занг анзаарахгүй байхын аргагүй байв.



Сургуулийн байранд нэвтрэх эрхгүй байсан ч олон олон оюутнууд сургуулийн хашаанаас гарч ирж зурагт хуудсыг авсан байна. Харин зурагт хуудсыг уншиж, агуулгыг нь ойлгосон даруйд олон оюутнууд эргэн харж, эрхий хуруугаа гозойлгон “Гайхамшигтай!” гэж хэлжээ.

Ийнхүү хэдэн өдрийн турш авшигтнууд хүн их цуглардаг Кан ал-Калили болон Сүк ал-Наххасин зэрэг зах, дэлгүүр хоршооны газрууд, сургууль, метроны буудлуудаар явж тараасан ба хүмүүс ч нааштай сайхан хандаж зарим нэг нь эрхий хуруугаа гозойлгон, мөн буянт үйлс бүтээж буй авшигтнуудыг магтаж сайшаах хүн ч олон байв. Авшигтнуудыг зурагт хуудсаа тарааж дууссаны дараа гудамжны худалдаачид олноороо хоршин алга ташин баяр хүргэж, маргааш өдөр нь дахин ирэхийг урьжээ.

Авшигтнууд аяллынхаа хамгийн сүүлийн өдөр Каирийн голын эргийн дэргэд орших Имбаба дүүрэг рүү явж, тэнд олон хүн холхисон зах дэлгүүрээр хүрээлэгдсэн автобусны зогсоол буудал байхыг харсан ба азаар оюутнууд хичээлээ тараад харьж яваа таарч, тэдний хамтаар маш олон хүн зурагт хуудас авахаар ирж номын ах эгч нарыг тойрон зогсчээ. Тэр ч байтугай автобусны жолоочид, сууж явсан зорчигчид хүртэл түр саатан зогсож, зурагт хуудас авахаар ирсэн ба тэр үед нийтдээ 6,000 гаруй хувийг цаг хагасын дотор тарааж дуусгасан байна. Ийнхүү авшигтнууд маань Египетийн найрсаг сайхан ард түмний тусламжтайгаар зурагт хуудсыг амжилттай тарааж дуусгасан төдийгүй олон сайхан Египетчүүд тэдний буянт үйлс бүтээж буй ариун сэтгэлийг үнэлэн дэмжиж, магтаж сайшаан зарим нэг нь номын ах эгч нартай англиар ярьж нутагтаа тавтай морилохыг урьжээ. Зарим нэг хүмүүс зурагт хуудас авахыг цааргалж байсан ч, агуулга нь махнаас татгалзаж, эрүүл амьдрах утга санаатай юм гэдгийг дуулаад эргэн ирж байсан юм. Мөн нилээд хэдэн нутгийн худалдаачид болон залуучууд сайн дураараа авшигтнууд дээр ирж зурагт хуудас тараахад туслан, сонирхсон хүмүүст агуулгыг нь тайлбарлан өгч байв. Аливаа хүнд бэрхшээл тохиох үед номын ах эгч нар Бурхандаа залбирахыг бие биедээ захиж явсан юм. Иймэрхүү тохиолдолд бид бүхэн санаанд урсан орж ирэх элдэв бодлоо таягдан хаяж, гагцхүү Бурхны хүчинд итгэж, бие сэтгэлээрээ Түүний бүрэн зэмсэг болж, дэлхий нийтэд харгислалгүй амьдрах тухай үнэтэй мэдээлэл хүргэхээ эрхэмлэн санаж явах хэрэгтэй.

ФИЖИГЭЭС ИРСЭН МЭДЭЭ



Фижи бол Өмнөд Номхон Далайд орших бүлэг арлаас тогтсон, жуулчлалын салбарын хөгжил нь дээд зэргээр өсч яваа улс юм. Авшигтнууд Фижийн хүн амын гуравны нэг нь амьдардаг нийслэл Сүва болон зэргэлдээх хотууд болох Наусори, Нади болон Лаутокад очиж “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг тараажээ. Авшигтнууд 1 сарын 28-нд Сүвахотын төвөөс ажиллагаагаа эхэлж үдийн дотор 8,000 хувийг тарааж дуусгасан байна. Маргааш өдөр нь хагас сайны өдөр таарч, гудамжууд ч хүнээр пиг дүүрэн, авшигтнуудын хувьд цагийг нь хэмнэсэн ашигтай сайхан тохиол боллоо. Юуны түрүүнд хүмүүсээ 2 багт хуваав. Эхнийх нь буюу 7 хүнээс бүрдсэн 1-р багийнхан Сүвад үлдэж, ойролцоогоор 16,000 гаруй хувь зурагт хуудас олон холхисон газруудаар явж тараав. Формосын 3 болон нутгийн хэд хэдэн бясалгагчид хамтарсан 2-р багийнхан Наусори руу



таксигаар хөдөлсөн ба очсон даруйд 8,000 гаруй хувийг дуусгасан байна.

Маргааш нь буюу бүтэн сайнд нутгийн хүмүүсийн сүмд очдог өдөр байж тааран, ихэнх дэлгүүрүүд хаалттай, гудамжууд нам гүм нойрсох мэт байлаа. Харин авшигтнууд сайхан амарч, мөн давхар төлөвлөгөө боловсруулж амжсан байна. Ийнхүү 4 дэх өдрийнхөө өглөө авшигтнууд эртлэн босч, Нади ба Лаутока хотуудыг зорьсон ба нутгийн иргэдийг хичээл сургууль, ажилдаа гарахаас нь өмнө амжиж хүрэхээр тооцоолж байв. Харин зорьсон газраа хүрсэн даруйд авшигтнууд ажиллагаагаа эхлэн, ганцхан өглөөний дотор 12,000 хувь зурагт хуудсыг тарааж дуусгасан ба нутгийнхан ч маш элгэмсгээр хүлээж авсан юм. Юутай ч Багшийнхаа хайр ивээлийн ачаар богинохон хугацааны дотор бид бүхэн даалгавраа амжилттай биелүүлж чадлаа.

ГУАМААС ИРСЭН МЭДЭЭ

Номхон далайн баруун хязгаарт орших Гуам арал хэмжээгээр Тайшэй хотоос хоёр дахин том, жилийн турш нар ээж байдаг, цэвэр ариун ард түмэн амьдардаг, сайхан газар билээ. 2-р сарын 3 - 6-ны хооронд авшигтнууд

Гуам арлын Засаг даргын ордон, удирдлагын төв газрууд, автобусны буудлууд, зах дэлгүүр хоршоонууд, сургуулиуд болон эмнэлгээр явж зурагт хуудсыг тараасан юм. Нутгийн иргэдийн олонх нь Христийн шашинтай тул сүмийн гадна зурагт хуудас тараахад баяртайгаар хүлээн авч байсан байна. Мөн авшигтнууд цагаан хоол худалдаалдаг хувийн дэлгүүртэй, алтан цагаан хоолтон нэгэн эмэгтэйтэй тааралджээ. Ижил хүсэл зорилготой хүмүүстэй уулзаж баярласан уг эмэгтэй номын ах эгч нарт утасныхаа дугаарыг өгч, дахин ирж уулзахыг хүсч буйгаа хэлжээ.



Тус ажиллагааны үеэр номын ах эгч нар хэдэн цоглог багш нартай таарсан ба тэд зурагт хуудсыг өөрсдийнхөө сургуульд аваачиж тараая хэмээн санал тавьсан байна. Ийнхүү авшигтнууд маань нийт 26,000 гаруй зурагт хуудас тарааж дуусгаснаар барахгүй орон нутгийн хэд хэдэн нэр хүнд бүхий сонин сэтгүүлд хүртэл нийтлүүлж амжсан ба улмаар Багшийн маань сэтгэлийн үгс Гуамын олон олон ард иргэдийн зүрхэнд үлдэх болно гэдэгт найдаж буй аж.

КАМПУЧААС ИРСЭН МЭДЭЭ

Кампуч бол Энэтхэг Хятадын хойгын өмнөд хэсэгт буюу Вьетнам ба Тайланд улстай зэргэлдээ оршдог орон билээ. 2-р сарын 3-нд 10 авшигтан нутгийн хэлэнд хөрвүүлэн хэвлэсэн нийт 40,000 гаруй зурагт хуудсыг нийслэл хот Фном Пэнх рүү авч явсан байна. Хотод ирсэн даруйд авшигтнууд 2 багт хуваагдан, 2 нь зурагт нүүрийг орон нутгийн сонинд хэвлүүлэхээр, үлдсэн 8 нь тус хотын хамгийн том зах гардаг газарт тараахаар Төв зах руу явжээ. Мөн арай илүү өргөн цар хүрээг хамрахын тулд маргааш өглөө нь авшигтнууд машин хөлслөн Баттамбангийн зүг хөдөлсөн бөгөөд дараа нь нийслэл Фном Пэнх рүү 5 дугаар хурдны замаар буцахаас өмнө Тонлэ Сап голоор эргэж Сиёмриэпээр дайрсан байна. Авшигтнуудын замын маршрут Кампонг Чнанг, Пүрсат, Баттамбанг, Бамтиэй Минчи, Сиёмриэп, Кампонг Том ба Кампонг Чам зэрэг газруудаас бүрдэж байсан бөгөөд



очсон газар бүрт ажиллагаа амжилттай явагдаж, хүүхэд хөгшидгүй зурагт хуудсыг анхааралтай уншиж, агуулгыг нь нандигнан хэн нь ч зүгээр нэг уншчихаад газарт хаяагүй байна. Тэр ч байтугай мотоцикл жолоодож явсан залуус саатан зогсож, тун анхааралтайгаар уншиж байжээ. Хүмүүс ийнхүү хүндэтгэлтэй хандсан явдалд авшигтнууд ч туйлын их баярлав! Заримдаа, хэт олноороо цугларснаас болж нэгэн зэрэг хүн бүрт зурагт хуудас тараах боломжгүй болох тохиолдол гарч байсан ба харин энэ үед хүмүүс тэвчээртэй хүлээж, эсвэл дахин ирж авах зэргээр зохицуулагдаж байв. Хүмүүсийг харж байхад зурагт хуудсыг олонх нь хүндэтгэлтэй нь аргагүй хоёр гараа тосон авах, зарим нь бүр 2 алгаа хувцсандаа байдгаараа арчиж байгаад ичингүйрэн байж авах зэрэг нь тун хөөрхөн байв. Ийнхүү Багшийн маань сэтгэлийн үгсийг нутгийн иргэд туйлын их нандигнан хүлээн авсан нь авшигтнуудын сэтгэлийг хөдөлгөсөн юм.

Авшигтнууд аялалд гарахаас өмнө Кампучийн ард иргэдэд туслах чин хүсэлтэй ноён Пантай урьдчилж холбоо барьсан

бөгөөд ноён Пан ч аялалын хөтөч, машин тээвэр олж өгөх гээд л аялал дуусан дуустал авшигтнуудын хамаг ажлыг зохицуулж өгсөн ажээ. Тэрбээр үнэхээр Бурхнаас тусгайлан илгээсэн сахиусан тэнгэр байсан юм! Мөн Ноён Паны танил Баттамбангид амьдардаг ноён Хуанг авшигтнуудыг гүүрэн дээр хэдэн цагийн туршид тэвчээртэй хүлээсэн байсан бөгөөд хамгийн хөөрхөн нь гүүрэн дээр ирэхийн тулд бүтэн 6 км-ийг унадаг дугуйгаар туулсан байв! Ноён Хуанг даруу төлөв, шулуун шударга зантай хүн байсан бөгөөд Багшийн маань эхлүүлсэн цагаан хоолны аяныг сэтгэлээсээ дэмжин, улмаар авшигтнуудыг нутгийнхаа нилээд хэдэн Буддын сүм хийдээр авч яван, мөн цагаан хоолны зоогийн газруудаар аялуулсан ба харин уулзсан хүн бүр “Өөрөөр Амьдарцгаая” уриаг олон түмэнд дэлгэрүүлэхэд гар бие оролцохдоо дуртай байх болно гэхийг сонсоход тааламжтай байлаа. Авшигтнууд Баттамбангийн зах дээр зурагт хуудсыг тарааж байхдаа үнэн ёсыг хүлээн зөвшөөрдөг нэгэн англи хэлний багш залуутай таарсан ба тэрбээр Багшийн зурагт хуудсыг анхааралтай уншсаны дараа, Багшийн санаачлагыг дэмжиж буйгаа илэрхийлээд нилээд олон хүнийг авшигтнуудад туслахыг уриалан нийт 3,000 гаруй хувийг тарааж дуусгажээ.

Сиемриэпэд, ноён Пан багийнхныг Тайпэйн Хилийн Чанад дахь Энхийн Үйлчилгээний Алба буюу TOPS (TOPS - хөгжил буурай бүст амьдардаг ядуучууд болон дүрвэгсдийг эрүүл ахуй ба эмнэлгийн үйлчилгээний сургалтанд хамруулах зэргээр албан бус боловсролыг дэмждэг байгууллага)-д аваачсан байна. TOPS-оос энэхүү төсөлд хамгийн ядуу 15 бүсийг сонгон авч хамруулж буй ажээ. Харин TOPS-ийн ажилтнууд авшигтнуудын хийж яваа ажлын тухай сонсоод Багшийн санаачлагыг сэтгэлээсээ дэмжиж, ижил хүсэл мөрөөдөл тээж явдаг юм байна хэмээж байсан ба түүгээр ч барахгүй төсөлд хамрагдаж буй 15 бүсийн хүмүүст зурагт хуудсыг дуртайяа тараах болно гэв. Мөн авшигтнууд ядуу буурай Кампуч ах эгч нартаа жаахан ч атугай туслахыг хүссэнээ илэрхийлж, TOPS-ийн төлөөлөгч нарт мөнгө хандивлажээ.

Ийнхүү 2006 оны 1-2-р сард зохион байгуулсан “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсыг олон түмэнд хүргэх ажиллагаа хэдийгээр 5-хан өдөр үргэлжилсэн ч, Багшийн ивээл доор амжилттай явагдаж дууссан ба Формоса дахь шавь нар болон ажиллагаанд оролцсон хүн бүрт маш сайхан дурсгалтай үйл явдал болж үлдлээ. ✨



Хайрын Илгээмж



Бурхан Бидэнд ТЭНГЭРИЙН ЭЛЧ ИЛГЭЭДЭГ

Амтат гуаны үр, Таоюуань, Формос

Саяхан Бангладеш руу Формос-ын авшигтан нартай “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тараахаар явахад орон нутгийн барилгын материалын компанийн эзэн, Христийн шашинтан ноён. Биан бидний баг бүрэлдэхүүнд ихээхэн тус нэмэр боллоо. Биднийг онгоцны буудлаас тосч аван, элчин сайдын яамдууд байрладаг нам тайван дүүрэгт орших нэгэн зочид буудалд буулган, бидний авчирсан “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг хэдэн зуугаар нь Бенгаль хэл рүү хөрвүүлж хэвлэх, машин түрээслэх, хөдөө орон нутаг руу аялах онгоцны билет захиалах болон урьдчилсан төлбөрт гар утасны карт авах зэрэгт цаг зав гарган тусалсан юм. Мөн тэрбээр компанийхаа боловсон хүчинд биднийг харж хандаарай гэж давхар захин Бангладешд цагаан хоолны бэрхшээл нилээд тул авшигтнуудад өөрийнхөө гэрийн гал тогоог хэрэглүүлэн, байшингийнхаа 2 давхарт амрахыг зөвшөөрсөн юм. Ноён Бианы ачаар бидний бэрхшээж байсан тав тухгүй байдал ор мөргүй алга болж, бид хоёр үнэхээр гайхаж биширсэн бөгөөд түүнийг үнэхээр Бурхны илгээсэн элч мөн юм байна гэдэгт итгэсэн билээ. Түүнчлэн, бидний байрласан зочид буудлын өрөөнүүд үнэхээр гоёмсог, уужим цэлгэр байсан нь авшигтнуудад маш их таалагдсанаас гадна өрөө болгоны ширээн дээр сагс дүүрэн жимс, үзэсгэлэнтэй цэцэг тавьсан байсан нь ноён Бианы тусгай хүсэлтийн дагуу зохион байгуулсан нь энэ ажээ. Аялалын маань 3 дахь өдөр ноён Биан бидэнд зориулан өдрийн болон оройн хоол өөрөө тусгайлан бэлдсэн байсан ба гайхалтай нь түүний хувьд анх удаа хийж байгаа цагаан хоол гэхэд үнэхээр сайхан амттай, анхилуун үнэртэй байж билээ. Оройн хоолны өмнөх залбирлаараа тэрбээр хэлэхдээ: “Эдгээр хүмүүсийг Бангладешт аюулгүй, амжилттай сайхан аялахад нь болон олон түмний төлөө хийж буй буянт үйлст нь намайг чадлынхаа хирээр туслахад минь Бурхан ивээх болтугай” гэв. Түүний залбиралд сэтгэл хөдөлсөн бидний зарим нэг нь бүр нулимс унагааж суулаа. Ноён Бианы өгөөмөр зан, ариун үйлсийг үнэлж баршгүй юм. ✨



Онч Мэргэн Үг

Бид Бол Нэг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Будапешт, Унгар 5 сарын 24, 1999, Видео хуурцаг № 652

Билэг нээгдсэнээр бид улам бүр ухаажиж, биднийг гэсэн хүн бүрт автоматаар туслаж Бэхэлдэг. Бид бусдын зовлонг өөрийн мэт мэдэрч, бидний эргэн тойронд буй хүн бүрт аз жаргал авчрахыг хүсдэг. ✨

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэрэл нигүүслийн хосгүй үлгэр жишээ

Бүтээх урлагийг бүрэн ойлгодог гэгээнтнүүдийн хувьд ууланд даяанчилж амьдрах нь нэг төрлийн юугаар ч сольшигүй аз жаргал, эрх чөлөө байдаг. Хэдий тийм боловч гэгээнтнүүд энгийн хүмүүсийн дунд амьд жишээ болон оришиж, амьдралд нь туслаж байхыг эрхэмлэдэг. Тиймээс заримдаа бидэнд эдгээр эгэл гэгээнтнүүдийн амьдралын зах зухаас нь олж харах, тэдний ариун үйлс болон гэгээн сургаалиас сурч боловсрох аз завшаан тохиож байдаг юм.

Багшийн шавь нараас (Англи хэл дээр)



2005 оны 9-р сард Багш Зүүн Унгарын 2 хөдөө нутаг дахь гахай болон бусад амьтад өсгөдөг бохир заваан, ямар ч зохион байгуулалтгүй нэгэн ферм рүү нисдэг тэргээр хүрч очсон юм. Гол хаалганы ойролцоо манаачийн гэр байсан бөгөөд хажууд нь хуучин машин техник хадгалдаг байсан бетон ханатай том гэгчийн талбай байлаа Багш нисдэг тэрэгнээс буунгуут манаачийн гэрийн өмнө хоёр метр хагасаас уртгүй гинжээр гинжлэгдсэн хоёр жижиг нохой байхыг олж харав.

Ноходын хэвтэх газар дэндүү бохир заваан байснаас гадна нэг талд нь хуучирсан эвдэрхий нохойн үүр, нөгөө талд нь хэдэн сараар хуримтлагдсан нохойн ялгадас байв. Тэдгээр өрөвдмөөр

амьтдын урд талд таллан хуваасан бохир хуванцар саванд өмхий үнэртэй ус, хатсан талх хийж тавьсан байсан бөгөөд харахнээ Европын нэгэн урт үст үүлдрийн нохой бололтой, тогтмол хооллодоггүйгээс болоод турж эцсэн, ялгадсан дунд хэвтсээр байж үмхий үнэртэй болчихсон арай дэндүү харагдаж байлаа. Бетон талбайн эсрэг талд бие бие рүүгээ тонгойн тогтсон байр аятай 2 муруй хананы өмнө нэгэн Герман шёфёрд үүлдрийн эрлийз том нохой байхыг багш болон түүний дагалдагч нар ажиглав. Мөн л бусад нохдын адил гурван метрээс уртгүй гинжтэй. Түүнд бусадтай адил ямар ч нохойн оромж байсангүй, харин хоёр талаараа онгорхой, салхи бороо чөлөөтэй орохоор зайтай, бохир ялгадас

болон шавраар дүүрсэн 2 муруй бетон ханан доор хоргодож байв. Хөөрхий нохой цэвэрхэн байхын тулд хананы нэг өнцөгт ялгадсаа гаргадаг бололтой. Харамсалтай нь гинжээрээ хамаг ялгадас, бохир заваанаа талаар нэг тараачихдаг нь илт, бүр түүн дээрээ хэвтэж тухлан бохир завантайгаа найзлахаас өөр сонголтгүй байдаг аж. Үүнийг хараад балмагдан цочсон Багшийн дур гутаж, эдгээр нохдын эзэн хэн болон яахаараа ийм аймшигтай байдалд оруулдаг байна гэж асуув. Өрөвч нинжин сэтгэлдээ хөтлөгдсөн Багш эхлээд том нохой руу очиход хөөрхий нохой баярлан, сүүлээ шарвалзуулж, илт сонирхсон янзтай харж байв. Багш түүнийг илбэхэд тэрбээр элдэг, зөөлхнөөр сарвуугаа өгөв. Бусад хүмүүс түүнд энэрэлгүй хандаж ирсэн ч, багшид ийнхүү хайр ивээл үзүүлж байгааг хараад Багш уйлж эхэлсэн юм. Дараа нь Багш өөрт байсан бүх хоолоо цэвэр усны хамт нохойнуудад өгсөн.

Тэр өдөр тус эзэнгүй хаягдсан ферм дээр ямар ч хүн байгаагүй тул нохдын эзний талаар асууж лавлах боломж байсангүй. Харин Багш тэдгээр өрөвдөлт амьтдын амьдрах нөхцөл байдлыг дээшлүүлэхийн тулд ямар нэгэн зүйл хийхээр шийдэж, өөр очих ёстой газар, амжуулах ёстой чухал ажил байсан хэдий ч хойш тавин, ноходтой үлдэв. Дараа нь Багш дагалдагчдынхаа нэгийг ноходод зориулан төрөл бүрийн бяслал, ногооны зайдас, нохойны органик цагаан хоол, ногооны яс, сүү болон нохойны жигнэмэг зэрэг нохдын дуртай хоол аль болох их хэмжээгээр авчруулахаар явуулав. Мөн дагалдагчдаараа нохойн эзэнд: Тэднийг зөв зохистой харж хандаж байх, өдөрт ядаж нэг удаа гинжнээс нь суллан тавьж чөлөөтэй байлган, ялгадсан дээр нь хэвтүүлж өдөр өнжүүлэхгүй байлгах тухай хүссэн захидал бичүүлж, захиандаа, хэрэв тэр нохойнууддаа дургүй бол тэд нарыг өөртөө үлдээх хэрэггүй бөгөөд тэд нарт тохирсон дулаахан оромж бэлдэж

өгөхийг хүсэв.

Улмаар дараагийн сарын турш дагалдагч нар Багшийн хүссэнээр нохдыг хэд хэдэн удаа эргэн тойрч хоол хүнс, ус авчирч өгчээ. Харин тэднийг ирэх болгонд манаачийн гэр хоосон цоожтой байдаг байсан бөгөөд нохойны эзэн гэмээр нэг ч хүнийг олж хараагүй байна. Хамгийн сүүлд дагалдагч нар нохдыг хооллохоор иртэл, тус фермд ажилладаг ахимаг насны эмэгтэй дугуйтай ирэв. Түүнээс нохдын эзний талаар асуутал, фермийн эзнийх юм гэж хэлэв. Магадгүй нохдын эзэн тэднийг гинжнээс нь суллагчид хөрш зэргэлдээх тосгонд очиж төвөг учруулах вий (Багшийн бодсоноор) гэж сэрэмжилснээс үргэлж гинжтэй байлгадаг байсан байх гэж тайлбарлав. Мөн ноходод ус, хатсан талхнаас гадна хааяа нэг мах өгдөг гэж хэлсэн боловч тийм янз байсангүй. Тэгээд уг эмэгтэй Багшийн захидлыг нохдын эзэнд дамжуулж өгнө гэж амласан юм.

Сар өдөр өнгөрсөөр, Багш нохойнуудад санаа зовсоор байсан бөгөөд эзэн нь Багшийн захидлыг хүлээн авч, зөвлөгөөг нь даган ноходод арай хүнлэг ханддаг болсон болов уу хэмээн байнга ярьдаг байлаа. Төдөлгүй өвөл болж, хүйтний эрч чангарч эхлэхэд Багш дагалдагч нараа нохойнуудыг дахин нэг эргэж тойрон хоол аваачиж өгөхийг хүссэн бөгөөд Багшийн хувьд тэдгээр нохдын нөхцөл байдал дээрдсэн эсэхийг мэдэх нь чухал байсан юм. Хэрэв ямар ч өөрчлөлт гараагүй байвал эзнээс нь нохдыг худалдан авч ирэхийг захив.

Дагалдагчнар фермдирэхэд нохдын байдал юун дээрдэх, харин бүр дордсоныг хараад туйлын зовов. Гурвуулаа байсан тэдний нэг жижиг нь хүйтэн, өлсгөлөнгөөс болсон уу нас барж, том, жижиг хоёр нохой үлдсэн байсан бөгөөд жижиг нохойны гинж нь орооцолдон зөвхөн нэг метр гаруй урттай болсон байлаа. Гинж нь богинохон тул хүйтэн оромж болон хоосон усны савандаа ч хүрч чадахгүй, мөн урьдынхаасаа хамаагүй илүү турсан

байв. Том нохойны байдал ч мөн адил дээрдсэнгүй. Нөгөө л нэг хоргодож байсан бетонон хана нь саяхан орсон борооноос болж норж, улам бохир болсон байв. Хажууд нь үхсэн хөлдүү жижиг торой байсан ба магадгүй түүнийг идэг гэжүлдээсэн бололтой. Гэвч тэрбээр уг үхдэлд хүрсэнгүй, харин Багшийн явуулсан бяслаг, ногоонызайдсыг амтархан идэв. Азаар дагалдагч нар нохойн эзэнтэй холбоо барьж нохдыг худалдан авч чадсан бөгөөд гайхалтай нь буцах замд ноход машин дотор тун томоотой явсан юм. Жижигхэн нь жолоочийн өвөр дээр эрхэлж явав. Багш дагалдагчдаасаа нохдын талаар утасдаж мэдээд баярлан уйлж, ноход анх удаа хүний хайр халамжийг эдлэх болсонд туйлын ихээр баярласан юм.

Дараа нь Багш нохойнуудыг малын эмнэлэгт аваачин шинжилгээнд оруулах зааварчилгаа өглөө. Цусны шинжилгээгээр жижигхэн нохой хүйтэн болон Өөлсгөлөнгөөс болж бие нь суларсныг эс тооцвол өөр ямар нэгэн өвчингүй гарав. Гэртээ ирсний дараа жижигхэн нохойг усанд оруулж, үсийг нь засуулахыг дагалдагч нартаа даалгав. Харин том нь тийм азтай байсангүй. Түүний хүзүүнээс хурц, өмхий үнэр үнэртэж байсан ба өргөн мөртлөө нимгэхэн хүзүүвч зүүлгэснээс болж өвлийн хүйтэнд хүзүүг нь зүссэнийг олж мэдэв. Хүзүүвчийг хүзүүнээс нь салгаддаггүй байснаас гадна нохой үргэлж хөдөлгөөнтэй байдаг тул шарх нь сэдэрч эдгэрдэггүй байжээ.



Шархнаас нь шингэн гоожиж, үс ноостой нь барьцалдан наалдаад бүр өмхийрсэн байв. Эмч цаг алдалгүй мэдээ алдуулах тариа тарьж, шарханд нь хагалгаа хийсэн байна.

Ийнхүү Багшийн ачлалаар амжиж тусалсны эцэст хагалгаа амжилттай болон одоо шарх нь эдгэж байна. Энэ хооронд хоёр нохой маань уураг, витаминаар баялаг цагаан хоолоор хооллон, өдөрт таван удаа салхинд гардаг болсон. Мөн Багшийн хайр

энэрлээр эдгээр амьтад дулаан цэвэр орчинд зөөлөн хөнжил дэрэнд унтан амьдарч байна. Бүрэн эдгэрснийхээ дараа сайхан сэтгэлт эзэн болон халуун дулаан гэр оронтой болох болно.

Багш нохдынхоо тухай хэлэхдээ: “Би дэлхий дээр байгаа сая сая нохойнуудыг зэрэг зэрэг халамжилж чадахгүй л дээ, харин халамж хайраар дутагдсан нохойнууд надтай тааралдах юм бол би заавал тэдэнд туслах ёстой.” гэжээ.

Тэдгээр хоёр Европ нохойнд үзүүлсэн Багшийн маань хайр халамж энэрэнгүй сэтгэлийн тод жишээ юм. Хэдий Багш маань маш завгүй байдаг ч тусламж хэрэгтэй хүн, амьтдад хайр энэрлээ заавал хүртээж байдаг билээ. Хайрын хүчийг мэдэрсэн энэ цаг мөчид бид бүхэн Багшийнхаа үлгэр жишээг дагаж амьдран, дэлхий ертөнц маань илүү сайхан болж байгааг ухаарах болно. ✨

Талархлын Захидал

Багшаас Эрхэмсэг ноён Поол Маккартни болон Хатагтай Хээдэр Миллз Маккартнид бичсэн захидал

Багш алдарт дуучин Поол Маккартни эхнэрийн хамтаар, хүмүүс далайн хавын арьс үсийг ашиглахын тулд их хэмжээгээр агнадагийг болиулах үндсэн дээр далайн хав агнахыг хориглох тухай заалт хуулинд оруулах талаар Канадын Засгийн Газарт хандсаныг телевизор болон бусад мэдээллийн хэрэгслээр үзэж мэдээд тэр даруй талархлын захидал бичсэн байна.

Хатагтай Маккартнийн буянт үйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх цахим хуудаснуудаас харна уу :

(<http://news.bbc.co.uk/1/hi/entertainment/4769628.stm>)

<http://www.ehethermillsmccartney.com/>

2006 оны 3 дугаар сарын 4


Эрхэмсэг ноён, хатагтай Поол Маккартни болон Хээдэр Миллз Маккартни,

Дэлхийн хүйтэн хэсэгт амьдарч буй гэмгүй далайн хавуудын амь амьдралын төлөө ийнхүү хичээл зүтгэл гаргасанд тань үнэхээр их сэтгэл хөдөллөө.

Та бүхний хүнлэг сэтгэл, буянт үйлс тань дэлхийн олон олон хүмүүст жишээ болж амьтдад хандах хандлагыг өөрчлөхөд заавал нөлөөлөх болно.

Сайн сайхныг хүсье,

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай





Төр Засгийн Байгууллагууд ард иргэддээ
**Мах, Архи, Согтууруулах
Ундаа болон Тамхины**
хор уршгийн талаар сайтар мэдлэг боловсрол олгох
хэрэгтэй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Сүррей, Их Британийн Нэгдсэн Вант Улс, 2006 оны 1 сарын 8 (Англи хэл дээр)

Б: Ирээдүйд бүх улс орнууд тамхины хайрцган дээр “Тамхи таныг үхэлд хүргэнэ”, “Тамхи уушигны хорт хавдар үүсгэн таны насыг богинсгоно” гэж бичдэг шиг, хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгон дээр мөн ижил утгатай үг, өгүүлбэр бичдэг болох байх гэж би



боддог юм. Хэрэв ингэвэл ирээдүйд хүмүүс олноороо махнаас гарч цагаан хоолтон болох болно.

Иймээс төр засгийн байгууллагууд, удирдагчид энэ талаар хүмүүст анхааруулж, дэлгүүрт ядаж үхсэн үхэр мэтийн юм тавих хэрэгтэй. Эсвэл хүмүүст нядалгааны газрын үйл явцыг (бүр ч илүү нөлөөлнө)гэр чигээр нь үзүүлэн тэдний юу идэж ууж, юунд мөнгөө зарцуулж байгааг мэдэх боломж олгох хэрэгтэй. Тэгэхгүй бол ямар ч хэлбэр дүрсгүй хэсэг мах хүмүүст худалдах нь хуурамч санагддаг. Жишээ нь, тахиаг заримдаа бүтнээр нь эсвэл юу нь ч мэдэгдэхгүйгээр хэсэгчилж зардаг. Амьд тахианы толгойг яаж тасддагийг та нар хардаггүй. Үхрийг нэг хөлнөөс нь дүүжлэн орхиход, цус нь шалан дээр нэг нэгээр яаж дусалдагийг ч та нар хардаггүй. Хоолойгоо хэрчүүлсэн гахай хэрхэн тийчилж чарлан, заримдаа онож судсыг нь таслаагүйгээс болж дахин хэрчих хэрэгтэй болдог зэргийг та нар бас л хардаггүй. Хүмүүс иймэрхүү харгислалыг хардаггүй.

Санаж байна уу, “Жинхэнэ баатрууд” /DVD#760/ нэртэй хичээлийг?

Д: Өө, тэгэлгүй яахав. Яг энэ сэдвээр байсан. Британы засгийн газар олон нийтийн газар тамхи татахыг хориглох гэж оролдож байгаа гэсэн.

Б: Тийм, Ирландад анх үүнийг хэрэгжүүлсэн юм. Итгэмээргүй шүү, Ирландад маш олон баар цэнгээний газар бий, гэвч хүмүүс нь ухамсартай л байна. Бусад улс оронд ч аажмаар энэ жишгийг дагаж эхэлж байгаа. Ирланд болж дээ.

Би үнэхээр их бахархаж байна, учир нь тамхи хэнд ч хэрэггүй



зүйл шүү дээ, эрүүл мэндэд

хортой гээд л, хайрцаг дээр сануулга тавьдаг хэдий ч хүмүүс худалдаж авсаар л байгаа. Тэгэхээр олон нийтийн газар тамхи татахыг хориглох нь ядаж татдаггүй нэгэнд нь тустай.

Гэхдээ заримдаа үнэхээр аймшигтай. Жишээ нь: Би буудалд тамхигүй давхарт байрладаг. Гэтэл ванны өрөөнд тамхи үнэртэж л байдаг. Яагаад хажуугийн өрөөний хүмүүс нууцаар тамхи татдаг байна аа? Гэдэнд бусдыг хүндлэх сэтгэл алга, яагаад гэвэл өдөр бүр л иймэрхүү байдалтай байдаг. Хүмүүс ванны өрөөнд тамхи татвал мэдэгдэхгүй гэж боддог юм шиг байгаа юм, гэтэл тэд сэнсээ залгангуут л, утаа нь миний өрөө лүү ороод ирдэг, зочид буудлын өрөөнүүд хоорондоо холбоотой байдаг. Заримдаа хүмүүс тамхигүй өрөө авчихаад тамхи татах сонирхолтой байх жишээтэй. Магадгүй сахилгагүйтмээр санагддаг байх л даа. Тэгэхээр хориод зогсохгүй, торгууль тавих хэрэгтэй. Жишээ нь: Онгоцны бие засах өрөөнд тамхи татвал 2.000 доллараар торгох зэргээр. Зочид буудал болон өөр бусад газарт ч мөн адил. Ингэвэл хэрэгжих болно, зөвхөн хоосон ярих нь хангалтгүй. Хүмүүс тэр болгон хүмүүжилтэй, мөн ёс суртахуунтай байж чаддаггүй.

Түүнчлэн, согтууруулах ундаан дээр “Архи таны тархийг гэмтээнэ”, “Архи таныг үхэлд хүргэнэ” гэх мэтийн хаяг тавих хэрэгтэй. Архи үхэлд хүргэдэг нь үнэн шүү дээ. Жил болгон олон зуун мянган хүн согтуугаар жолоо барьж явж байгаад осол аваарт орж амиа алддаг. Хүн болгон үүнийг мэднэ.

Бараг амиа алдах нь хамгийн таагүй зүйл ч бас биш юм. Учир нь зарим хүмүүс эрэмдэг зэрэмдэг болж, нийгэм ба гэр бүлийнхэндээ тээр болж байхаар үхсэн нь дээр гэж үздэг. Өөрөө ч зовж, бусдыг ч зовоодог. Мэдээж, бид бусдыг ингэж зовж амиа алдаасай гэж хүсэхгүй ч, үхэж чадаагүйн улмаас, эсвэл амьд явах ёстой учраас гар хөлгүй болж, ой ухаанаа алдвал бүр ч хэцүү болох биш үү? Энэ нь нийгэмд болон татвар төлөгч нарт тээр болдог. Мөн маш их зовлон шаналал авчирдаг.

Хэрвээ танай гэр бүлийн нэгэн гишүүн ийм байдалд орсны улмаас танай гэр бүлийнхэн түүнийг өдөр шөнөгүй асарч тойлох болбол яах вэ? Гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн хувьд асар их дарамт, зовлон

шаналал авчирна, тийм үү? Тэгвэл үхлээс илүү хэцүү байх болно биз дээ. Хэрвээ аав нь ч юм уу, эсвэл ээж нь ийм байдалд орвол хоёуланг нь алдсанаас ялгаагүй гэсэн үг шүү дээ.

Хүүхдүүд сургуульдаа явахад нь, ангийнх нь хүүхдүүд асууж шалгаахад, тэдэнд олигтой санагдах уу, ичнэ, зовно, бас уйтгарлаж гуниглана. Тэгэхээр эмнэлгийн орон дээр, эсвэл гэртээ амьгүй төмс мэт хэвтэж байгаа ааваасаа болж, хүүхэд нь сэтгэлийн дарамтанд ордог. Хүүхэд яаж тайлбарлахаа мэддэггүй тул бусад хүүхдүүд түүнийг юм уу, аавыг нь шоолж байдаг. Төсөөлж байна уу? Тиймээс энэ бүхэн зөвхөн үхэх тухай биш юм.

Мэдээж согтуу жолоо барьж яваад амиа алдахыг бид хэрхэвч хөхүүлэн дэмжихгүй, гэвч ихэнх тохиолдолд эрэмдэг зэрэмдэг болсноос нас барах нь дээр гэж үздэг, яагаад гэвэл түүнээс үүдэн гарах уршиг их ба гэр бүл, найз нөхдийг нь сэтгэлийн хүнд дарамтанд живүүлдэг юм. Бид болон бидний гэр бүл ийнхүү зовж шаналах ёстой болбол ингэж ярих нь сайхан сэтгэгдэл төрүүлэхгүй нь ойлгомжтой.

Тиймээс төр засгийн удирдлагууд чадах бүхнээ төдийлөн хийхгүй байна даа гэж би боддог. Ядаж хүүхдүүд уншаад ойлгохоор тайлбарыг бүхий л аюултай бүтээгдэхүүнүүд дээр тавих хэрэгтэй. Хүүхдүүдэд: “Архи ууж болохгүй” гэж хэлдэг ч, тэд яагаад гэдгийг ойлгодоггүй. Хэрвээ гарт нь баригдсан архины лонх бүр дээр: “Тархийг чинь гэмтээнэ”, “Ухаан санааг чинь муутгана”, эсвэл “Таны шүүмжлэх чадварыг сулруулна” гэх зэрэг бичиг байвал, хүүхдүүд ядаж, “Аан ийм учиртай юм уу” гэж бодох болно.

Телевизээр ганц удаа ярьснаар юм уу, Тэсвэл сонин дээр ганц өгүүлбэр бичсэнээр тэд олж харж уншиж чадахгүй шүү дээ. За тэгээд архи, согтууруулах ундаа биед хортой гэсэн зар сурталчилгааг өдөр бүр телевиз радиогоор нэвтрүүлэх биш. Тэд бидний хүүхдүүдэд: Архи битгий уу л гэж хэлдэг. Хүүхдүүд ямар билээ дээ. Тэд бол зөрүүд, сахилгагүй. Та Үгүй гэж хэлбэл тэд яаж ийгээд л нууцаар, эсвэл хулгайлаад ч болов туршаад үзэхийг бодно. Бүр цаашилбал, баар цэнгээний газруудаар явж үзнэ. Яагаад хаяг шошгон дээр анхааруулга тавьдаггүй юм бэ? Яагаад болохгүй гэдгийг хүүхдүүдэд

ойлгогдохоор хэлж болдоггүй юм бэ? Яг л тамхины хайрцган дээрх шиг. Харин зарим хүүхдүүд эхнээсээ муу хор уршигтай гэдгийг ойлгосон байдаг нь авууштай.

Д: Багшаа би төр засгийн удирдлагууд хангалттай арга хэмжээ авч чадахгүй байна гэж боддог. Тэд юуны түрүүнд эдийн засгаа л бодож байдаг. Яагаад гэвэл тамхи бол орлогын татварын гол эх үүсвэр болохоор тэр байх л даа.

Б: Гэхдээ тэд зүгээр суугаагүй. Тамхины хайрцган дээр анхааруулга тавьсан л даа. Харин яагаад архин дээр ийм арга хэмжээ авахгүй байгаа юм бол? Бас л эдийн засаг уу? Засгийн газар татварыг өөр бусад олон хэлбэрээр хуримтлуулдаг. Хэрвээ дайн хийхээ больчихвол зэр зэвсэг мэтэд мөнгө их хэмжээгээр зарцуулахаа больж, дэлхийг тэр чигээр нь тэжээх мөнгөтэй болж чадна. Тиймээс аливаа Засгийн Газар хор хөнөөлтэй л бол архи гэлтгүй, бүх зүйл дээр анхааруулга тавих хэрэгтэй. Төр засгийн удирдлага, бүх л бүтэн улс орныг удирдаж байна гэдэг утгаараа иймэрхүү ухаалаг арга хэмжээ авах нь зүйтэй. Татвар төлөгчдөөс цуглуулсан мөнгийг хүнд өвчтэй хүмүүсийн эмчилгээнд нь зарцуулахын (заримдаа бүр хэт оройтсон байдаг) оронд, наана нь урьдчилсан арга хэмжээ авч ард иргэдээ хамгаалах хэрэгтэй. Зарим тохиолдолд эмчилгээ амжилттай боллоо ч, тэр хүртэл тухайн өвчтөн болон түүнийгэрбүлийнхэн сэтгэлзүйн дарамтанд орж ихээхэн зовж шаналаад амжсан байдаг. Ер нь төр засгийн удирдлагууд юу хийгээд тийм завгүй байгаад байдгийг би мэдэхгүй. Хамгийн гол нь асуудлын үндсийг олох хэрэгтэй юм шүү дээ: Тамхи татахыг хориглох, хэрэв зөрчвөл торгууль төлдөг болгох, яг л хууль зөрчвөл шийтгэл хүлээдэгтэй адилаар. Хэрвээ хэн нэг нь ар нуруу руугаа хутга зоолговол, үйлдэгч этгээдийг шоронд хорьдог биз дээ. Хэн нэг нь таны хамар луу тамхины утаа үлээе гэж бодоход тодорхой хэмжээгээр хорт хавдар мэтийн хүнд өвчин үүсгэх шалтгаан нь болж болно. Тиймээс таны хамар луу тамхины утаа үлээсэн хүн ч шоронд суух, эсвэл торгууль төлөх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ мэтийн үйлдэл бол нэгэн төрлийн аллага,



нэгэн төрлийн доромжлол юм. Гэхдээ бие махбодийн шинж чанартай. Таныг хутгалж байгаагаас өөрцгүй шүү дээ. Харагдахгүй, удаан хугацааны дараа илэрдэг өвчин шаналал болохоос биш. Шууд бус хэлбэрээр тамхи татна гэдэг, өөрөөр хэлбэл, тамхины утаанд хордон зогсоно гэдэг бол тамхи татахаас дутахааргүй хор хөнөөлтэй. Олон хүнийг хөнөөдөг, маш их зовлон шаналал авчирдаг, олон хүнд өвчин тусгадаг, бүр цаашилбал, үндэсний нийгмийн хамгааллын системд ч аюултай юм. Хүн бүр л мэднэ. Даанч, хэн ч, юу ч хийхгүй юм. Тийм болохоор хүмүүсийг тамхи битгий худалдан аваач хэмээн уриалахын зэрэгцээ эдийн засгийн гарз хохиролд орно хэмээн айж эмээх, эсвэл анхааруулгатай тамхи худалдаанд гаргавал хүмүүс худалдан авах нь багасна хэмээн зовохын хамтаар түүнээс үүдэлтэй өвчин туссан хүмүүсийг эмчлэхэд орлогын татвараас олсон мөнгөө зарцуулах зэрэг ямар утга байна?

Д: Илүү үнэтэй тусч байна гэж судалгаагаар батлагдсан.

Б: Харин тийм. Илүү их зардал ордог, нэгдүгээрт. Хоёрдугаарт дэндүү их өвчин шаналал авчирдаг. Зөвхөн мөнгөний тухайд ч яриагүй юм шүү. Бие сэтгэлийн зовлонд давхар унагааж, улс үндэстний оюуны чадамжид муугаар нөлөөлж байдаг. Хичнээн олон сайхан мундаг сэхээтнүүд архи, тамхинд толгойгоо мэдүүлчихээд, улс орны бүтээн байгуулалт, дэлхийн энх тайван, сайн сайхны төлөө зүтгэхэд гар биеэр оролцох боломжгүй болчихоод байгаа билээ. Зуун жилийн өмнө архи уухыг хориглодог байсан юм шүү дээ. Яагаад ингэхээ больсныг би мэдэхгүй. Хүн бүр архи бол хор гэдгийг мэдэх хэрнээ нээлттэй хэрэглэсээр. Зөвхөн насанд хүрэгсдэд архи худалдаална гэх боловч худалдан авсан шил вискигээ өдөржин гэртээ ууж суугаад л, хүүхдүүддээ ямар үлгэр дууриал үзүүлж байгаа нь энэ вэ? Эсвэл нэгэн өдөр найзтайгаа яриад сууж байтал, нөгөө архи гээч нь сайхан

харагдаад болдоггүй, өөрийн эрхгүй ууж эхлээд л, жаргалтай гэгч нь чалчиж өгнө. Иймэрхүү дүр зураг хүүхдүүдэд маш их нөлөөлдөг. Улмаар: “Өө, виски уухаар жаргалтай болдог юм байна” гэж бодох болно.

Заримдаа та эхнэртэйгээ, эсвэл нөхөртэйгээ хайр сэтгэлээ тэмдэглэж архи уух юм бол хүүхдүүд чинь ийнхүү: “Аан, ойлголоо, хайртай хүнтэйгээ цагийг сайхан өнгөрүүлсэ гэвэл яг ээж аав хоёр шиг архи уух юм байна шүү” гэж бодно.

Мөн найз бүсгүйгээ уриад л, хамтдаа архи уухыг ятгаж кинон дээр гардаг шиг, эсвэл гэртээ харсан тэр л дүр зураг шиг хайр сэтгэлтэй хүмүүс цагийг хэрхэн сайхан өнгөрүүлдгийг дууриах мэтээр оролдох гээд л.

Нийгэм хүүхдүүдэд энэ мэтийн хог заадаг байж, яаж тэднээс үүрэг хариуцлагатай, ухаалаг, үлгэр жишээч иргэн болж төлөвшихийг шаарддаг байна аа? Насанд хүрэгсдийн бодлогогүй үйлдлийг өдөр тутам харж сонжиж байдаг хүүхдүүд, яаж эрүүл оюун санаатай иргэн болж торних вэ?

Тиймээс бид бодох хэрэгтэй. Таны үг дэвшилт авчирна. Та хэлэхэд л хангалттай. Хүмүүс анзаарч ч мэднэ, үгүй ч байж мэднэ, гэвч та хэлэх л хэрэгтэй. Ийм л байх ёстой юм.

Хэрвээ бараа бүтээгдэхүүний хаяг шошгон дээр бичдэггүй юм бол, ядаж зоогийн газруудад “Архи таныг хөнөөнө” гэсэн бичиг тавих хэрэгтэй. Яагаад зөвхөн тамхи, янжуураар хязгаарлах ёстой гэж? Тамхи архинаас бага хортой шүү дээ. Архи илүү хурдацтай нөлөөлдөг. Нэг нөхөр архи ууж согтонгуугаа гадагш гарч, нөгөө нэгэнтэй маргалдаж, зодоон цохион хийн, улмаар бие биеийгээ алж хөнөөх, эсвэл бие махбодийг нь гэмтээх энүүхэнд л байдаг биз дээ. Тиймээс яагаад архины лонхон дээр анхааруулга тавьж болохгүй гэж? Үүнийг би ер ойлгодоггүй юм. Бас тархины үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг, хүн бүр л мэднэ. Тархины эд эс нөхөн ургадаггүй юм. Та жаахан архи уусны дараа, архинд гэмтсэн тархины хэсэг эд эсээ эргүүлэн ургуулахын тулд удаан хугацааны турш дахин архи уугаагүй гэж бодъё л доо, гэвч үгүй дээ, тархины эд эс хэзээ ч нөхөн

ургадаггүй юм. Хэрвээ та архи уусаар байвал өөрийнхөө тархиа алсаар байна гэсэн үг. Та хэт хүчтэй архи уугаад байвал сүүлдээ тархины гэмтэлтэй болж дуусна. Архи тархинд гаруут хүрсэн эд эс бүрээ гэмтээж байдаг, тэгээд гэмтсэн эд эс бүр чинь хэзээ ч эргэн төлжихгүй, мөн сэргэхгүй. Олон хүн үүнийг мэднэ. Хэрэв та телевиз үзэж сонин уншдаг бол би мэдэхгүй гэж лав хэлэхгүй биз ээ. Тиймээс яагаад архины лонхон дээр анхааруулга тавьж болохгүй гэж? Дараа нь та махны дэлгүүрээс эхлээд л хор хөнөөлтэй юм болгонд анхааруулга тавьж болно. Хэрчим мах бүрт “Та үхсэн биен дээр амьдарч байна”, эсвэл “Таны өнөөдрийн хоолонд зориулж хөөрхий энэ амьтныг зэрлэгээр нядаллаа” гэсэн бичиг наах хэрэгтэй. Тэгвэл зарим хүмүүс юу худалдан авч буйгаа мэдэх болно. Мөн махны дэлгүүрт, эсвэл хүнсний дэлгүүрийн махны тасагт, зэрлэгээр хөнөөгдсөн үхрийн зургийг зай завсаргүй наах хэрэгтэй. Тэгвэл зарим хэрэглэгчид юунд мөнгө зарцуулж буйгаа мэдэх болно.

Хэдийгээр бараа бүтээгдэхүүн худалдаалах нь гэмт ажиллагаа биш боловч, худалдан авч байгаа хүмүүсийн нүдийг боож бараагаа зарах нь үнэнд нийцнэ гэж үү? Энэ бол хууран мэхлэлт. Шударга биш шүү дээ.

Д: Заримдаа хэрчим мах жинхэнэ мах шиг харагддаггүй. Хиам ч юм уу, утсан гахайн мах болгон боловсруулаад худалдаалахаар, хүүхдүүд хиам идэхдээ, юугаар хийснийг нь мэддэггүй л дээ.

Б: Тиймээ, тэд яаж ч мэдэхэв дээ. Миний нэг танилын 4-хөн настай зээ хүү, маханд тун дургүй байж билээ. Тэр бяцхан хүү махгүй юм болгонд дуртай, харин эцэг эх нь хүчээр мах идүүлдэг байсан. Заримдаа хүү махнаас болж өвддөг гэхийг сонсоод би найздаа хэлсэн юм: “Эцэг эхэд нь хүүдээ сонголт хийх боломж олго гэж хэлэх хэрэгтэй” гэлээ. Түүнээс хойш юу болсныг би мэдэхгүй л дээ. Гэхдээ тэр үед миний хийж чадах зүйл тэр л байсан.

Олон нийтэд таниулах үйл ажиллагааг өргөжүүлснээр, газар дэлхийг диваажин болгож болно

Энэ дэлхий дээр амьдарч буй хүн бүрт та хэлж чадахгүй л дээ, гэхдээ ядаж чадах чинээгээрээ олон хүнд хүргэхийг оролдох хэрэгтэй. Чадах бүхнээ хий. Бид хамтдаа оролдвол амтат жимс ургах болно. Телевиз, радиогоор нэвтрүүл, зурагт хуудас гадуур тараа. “Цагаан хоолтон болооч, өнөөдөр ядаж нэг ч атугай гэмгүй амьтны амийг авраач”.

Тэгээд нэг хөлнөөс нь дүүжилсэн, үхсэн үхрийн зургийг гадуур тараа, тэгвэл хүмүүс үхэр яаж гаргадгийг харах болно.

Д: Багшаа, Их Британийн Вант Улсын Цагаан Хоолтны Нийгэмлэг энэ тал дээр нилээд ажил хийж байгаа. Дунд сургуулиудад тусгай хичээл орж, мөн нүүрний зурагтай футболк тараадаг.

Б: Тийм ээ, би мэднэ. Тиймээс хөлнөөс нь дүүжилсэн, үхсэн үхрийн хажууд балиус барин зогсох яргачингийн зургийг гадуур тараавал 1000 үгнээс ч илүү үнэтэй байх болно. Зарим хүмүүст тархи руу нь шаах шиг л болох байх гэж би найдаж байна. Хэрвээ та оюун санаагаар аварч чадахгүй бол (учир нь хүмүүс таныг сонсохгүй), ядаж хөөрхий мал амьтдыг аврах хэрэгтэй. Дэлхий ертөнцөө цэвэрлэхийн тулд бид өөр юу хийж болох вэ? Сургуулиудад анхааруулга наах хэрэгтэй. Жишээ нь: “Хар тамхи таныг хөнөөнө”, “Хар тамхи таны оюун санааг муутгана”, “Та хар тамхинаас хамааралтай болж, байнгын мансуурлын байдалд орно”, “Хар тамхи таны мөнгийг сэгсэрч, бэлгийн чадавхийг сулруулна” гэх мэтээр, гэхдээ үнэн биз дээ? Хар тамхинд орсон хүн хар тамхинаас хамааралтай болж, хувхайран зэвхийрч, бие махбод нь суларч, царай зүс нь муудаж, муухай үнэртэй болж, хурдан хөгширч, өвчин тусдаг. Тэд яагаад энэ талаар сургуулиудад бичдэггүй юм бэ? Зөвхөн “Хар тамхи хэрэглэхийг хориглоно” гэж бичээд яах юм бэ? Хүүхэд бүрт тэрхүү бичгийг уншаад байх боломж байхгүй, учир нь тэд чинь хичээл номоо хийгээд завгүй байдаг. Харин хар тамхины хор уршгийн талаар сайтар тайлбарлах ёстой юм шүү дээ. Хэрвээ багш энэ талаар



ер ярьдаггүй, эсвэл ганц хоёр удаа хэлээд л өнгөрдөг бол нөлөө үзүүлэх нь юу л бол. Харин хар тамхи, архи согтууруулах ундаа, тамхи болон махны хор уршгийн талаар уриа лоозон хаа саагүй өлгөх хэрэгтэй. Мөн “Таны өнөө оройны хоолыг бэлдэх гэж нэгэн гэмгүй амьтны амь насыг аймшигтайгаар бүрэлгэжээ” зэрэг бичгийг хэрчим үхрийн болон гахайн мах болгон дээр нааж тавиад, хэр олон хүмүүс худалдаж авахыг харж болно. Тэдэнд бодох боломж олго. Хүн албал хүн амины хэрэг гэдэг шиг амьтан алах нь бас л нэгэн аллага шүү дээ. Амьтан танд ямар ч гэм хор хүргэхгүй, мөрөөрөө эрхэлж наадаж явахад нь та очоод ална гэдэг бол санаатай аллагаас өөрцгүй. Өөр юу гэж нэрлэх билээ дээ, тийм үү? Тиймээс бид: “Таны хоолонд хэрэглэх хэрчим махны төлөө хөөрхий нэгний амийг бүрэлгэжээ” гэж бичээд, худалдан авч байгаа хүмүүсийн царайнаас бодлыг нь уншиж болно. Ирээдүйд, төр засгийн удирдлагууд эдийн засагтаа санаа зовж суухын оронд, арай илүү ёс суртахуунтай байж, үүрэг хариуцлагаа жинхэнэ ном ёсоор биелүүлж эхэлбэл дэлхий маань цэвэрших бизээ. Яагаад гэвэл татвар хуримтлуулахад тэгтлээ санаа тавьчихаад, цуглуулсан мөнгөө эргүүлээд өвчтөнүүдэд зарцуулна гэдэг маш буруу тооцоо. Зовлон шаналлын үүдийг өөрсдөө л бий болгож байна гэсэн үг. Нэгэнт эдгэрэх нь өнгөрсөн өвчтөнүүдийг эмнэлгийн шилдэг техник хэрэгслээр эмчлэх гэж оролдоод, эм тангаар булаад яах юм бэ? Оронд нь тамхи худалдахаа больчих л доо, эсвэл архи тамхины шонгон дээр анхааруулга бичиг наа л даа, тэгвэл өвчлөх хүмүүсийн тоо цөөрнө шүү дээ. Бидэнд ч, өвчилсөн хойно нь тэдний эмчилгээнд зориулж татварт авснаас илүү их зардал гаргах шаардлагагүй болно. Бизнес тань алдагдалтай байгаа хэрэг биш үү? Ямар ч оюуны чадамжтай Засгийн Газар зөв тооцоо хийж чадвал, бизнес эрхлэхийн жинхэнэ утга учир юу болохыг ухаарах болно. Түүнчлэн, хүмүүст анхааруулга өгч, тэднийг хамгаалах нь Засгийн Газрын хийх ёстой ажил. Ард иргэдийнхээ эрүүл

мэнд, аюулгүй байдлыг хангах нь тэдний үүрэг. Та бүхэнд үлгэр дууриал болох олон олон зүйл бий: миний хувьд гэвэл, миний ном сургаал, мөн миний алхам бүр гэх мэт. Ямар нэгэн зүйлээс татгалз гэж би хэзээ ч та нарыг шахахгүй. Та бүхэн гоё алт эрдэнэс зүүж болно, би бүр та нарт зориулж загварыг нь гаргадаг. Үдэшлэгт явахдаа гоё хувцасла. Бидэнд үргэлж иймэрхүү зүйлс хийгээд байх шаардлага байхгүй л дээ, гэхдээ хүсвэл болно. Хэрэв ёсгүй бол хэрэггүй. Бид байгаагаараа л жаргалтай. Бид гадаад төрхөөрөө ч, дотоод сэтгэлээрээ ч адилхан гоо үзэсгэлэнтэй. Тиймээс гоё ганган харагдах гэж сайхан хувцас өмсөх ч шаардлагагүй байдаг, гэхдээ та нарыг гоё хувцас битгий өмс гэж би хэзээ ч хориглохгүй. Та бүхнийг энэрэнгүй сэтгэлээсээ үүдэн цагаан хоолтон болж даяанчил гэж би бодохгүй. Дотоод сэтгэлдээ гоо үзэсгэлэнг цогцлуулах тусам гадаад төрхөөрөө улам өнгө орж жавхаажина. Тиймээс та нарын хувцасны сонголт ба бусад зүйлст хандах хандлага өдөр ирэх тусам дээрдэх болно. Дээр үед Хятадад, Яао ба Шүн зэрэг Их Багш хэмээгддэг, ард иргэдээ өөрсдийн хүүхдүүд мэт хайрлаж халамжилдаг хаадууд байж гэнэ. Тэр үеийн хүмүүс гадагш гарахдаа гэрээ цоожилдоггүй, татвар ч төлдөггүй байсан байна. Хаандаа зориулж ямар нэгэн тусгай зүйл хийх шаардлагагүй байж л дээ. Юм гэдэг ийм л байх ёстой юм шүү дээ. Тиймээс төр засгийн удирдлагууд биднийг шагнах хэрэгтэй: “Та бүхэн сайн үйлс хийж байна. Бидэнд туслаж байна” гэх ч юм уу. Бид ямар ч цалин мөнгө нэхэлгүй ажилладаг. Тэд бидэнд ямар нэгэн төлбөр төлөх хэрэггүй! Засгийн газрууд, цэрэг цагдаагийн байгууллагуудад ард иргэдээ хамгаалуулж, гэмт хэрэгтнүүдийг журамладагийнх нь төлөө мөнгө төлдөг. Бид ямар ч цалин хөлсгүй, цагдаа нартай тэрсэлдэлгүй, хэн нэгнийг хохироолгүй, мөн хэн нэгнийг хөнөөх зэр зэвсэг хэрэглэлгүйгээр ажлаа хийдэг. Тэгэхээр бид муу хүмүүс биш шүү. Засгийн газрууд анзаарахгүй байгаа нь хачирхалтай. Энэ дэлхий дээр зарим нэг харилцаа тун урагшгүй байдаг, мэдээж хэрэг Бурхан хэнд ч өс санадаггүй, Бурхан хүн бүрт өсөн дэвжихэд нь туслаж байгаа. Хэрэв хүн болгон бидэн шиг байсан бол эх дэлхий

маань ямар байхсан бол гэж төсөөл дөө? Хүн болгон цагаан хоолтон биш юмаа гэхэд ядаж архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхээ больчихвол арай илүү эрүүл саруул, цэвэр цэмцгэр болж, зөндөө их мөнгө хэмнэхгүй юу. Түүгээр ч зогсохгүй хүн болгон илүү аз жаргалтай болж, сайхан байранд амьдарч, сайн машин унаж, эрүүл мэнд нь сайжирч, мөн сайхан гэр бүлтэй болж, эд бүгд дунд сургуулийн сурагчдад сайхан үлгэр дууриал болохсон. Хэрвээ бид архи, мах болон тамхийг өдөр тутмын хэрэглээнээс бүр мөсөн алга болгочихвол, гэр бүлийн маань амьдрал цэгцэрч, сургууль цэцэрлэг ч илүү аятай сайхан газар болохсон. Тиймээс ариун амьдралыг сонгох нь нэг хүн, нэг гэр бүл гэлтгүй, нийгэмд тэр чигээр нь, цаашилбал, бүхий л зүйлд эерэг нөлөө үзүүлнэ. Тиймээс л дэлхий нийтээрээ эдгээр арга хэмжээг авах ёстой гэж би хэлж байгаа юм. Хэрвээ хүмүүс бидний жишээг дагавал заавал бясалгалд суралцаад л лам хувраг болох албагүй юм шүү дээ. Би ч тэдэнд заах хэрэггүй болно. Тэд ч надтай уулзах гэж ирэх хэрэггүй болно. Зөвхөн ариун амьдралыг л сонгох хэрэгтэй. Хүмүүс Бурханд юм уу, өөрийнхөө итгэдэг гэгээнтэнд сүсэглэн залбирч болох агаад тэдний ариун үйлс, гэгээлэг амьдрал олон нийтэд нөлөөлж, улмаар эх дэлхий маань диваажин болж хувирна. Бүр миний ч хэрэг байхгүй. Дэлхий яагаад үүнийг олж харахгүй байна вэ? Яагаад улс үндэстнүүдийн удирдагчид, ард иргэдээ ариун амьдралаар амьдрахыг уриалж, байгаа газраа диваажин болгохыг оролддоггүй юм бол? Хэрвээ гэр бүлээ аз жаргалд умбуулж, хайрлаж халамжлахыг хүсч байгаа бол ариун амьдралыг сонгох ёстой юм. Ядаж өөрөө амьд жишээ бол. Та хүсвэл дэлхийг өөрчилж чадна. Хэрвээ та төр засгийн удирдагч бол дор хаяж өөрийнхөө улс орныг өөрчлөх боломжтой. Алхам алхмаар урагшлахыг хичээ, аяндаа бүтнэ. Тэр хооронд хэдүүлээ ариун амьдрал удахгүй ирнэ, дэлхий нийтийн төр засгийн удирдлагууд заавал бодитой арга хэмжээ авна хэмээн найдаж, мөрөөдөж л сууя даа. Уул нь аль хэдийн эхэлчихсэн юм шүү дээ. Асуудлын гол үндэс шалтгаан нь тамхи татах, архи уух, мансуурах бодис хэрэглэхэд оршдог гэж би боддог. Эдгээрээс муу бүхэн эхлэлтэй. Нэгэнт

ухаан санаагаа алдчих юм бол юу л бол юу хийх гээд байдаг. Бурхан Буддагийн цаг үед болсон нэгэн түүх юм: Нэг хүн нэгэн залууд хэлж л дээ: “За тэгэхээр чи бүх сахилаа сайтар сахих ёстой. Амьтны амь хөнөөхийг цээрлэх. Хулгай хийж болохгүй. Садар самуун явахгүй байх. Худлаа хэлэхгүй байх ба Архи уухгүй байх. Залуу хэлсэн нь: Би эхний 4-ийг сайтар баримталж чадна. Гэвч 5 дахийг нь чадахгүй юм байна гэжээ. Дараа нь тэрбээр архи ууж, амьтан алж, худлаа хэлж л дээ. Түүний бүхий л бусармаг үйлдэл архи ууж согтсоноос болжээ. Согтуу үедээ замд нь хөндөлссөн хэнийг ч хамаагүй хороож зогсоохыг оролдсон ч нэгэнт ухаанаа алдсан тул дийлдэхгүй байлаа. Юу хийж байгаагаа мэдэхгүй болтлоо ухаанаа алдаж, өөрийгөө хянах чадваргүй болсон байв.”

Тиймээс би ойрын ирээдүйд төр засгийн удирдлагууд зохихарга хэмжээ авах байх гэж найдаад байгаа юм л даа. Юуны түрүүнд архины шошго болон архины дэлгүүрт анхааруулга тавих хэрэгтэй. Дараа нь махны дэлгүүрт: “Таны хоолонд зориулж гэмгүй нэгний амийг бүрэлгэлээ” гэсэн бичиг тавих зэргээр хүмүүст үнэнийг хэлж, тэдэнд сонголт хийх боломж олгох хэрэгтэй. Үгүй бол хүмүүс мэдэхгүй байж болно шүү дээ. Хүмүүс махаар хооллодог гэдгээ мэдэх хэдий ч өдөр болгон хэрэглээд заншчихсан тул бодох сэхэлгүй байдаг. Ихэнх хүмүүст мах, архины хор уршгийн талаар хэнбугай нь ч заагаагүй тул рекламдаж буй боловсруулсан мах, архи сайхан харагдахаас яахав. Бүгд худлаа. Хэрвээ та хүмүүст бидэнд сонголт бий юм шүү гэдгийг ойлгуулж чадвал тэд жаахан ч гэсэн бодох л болно. “Та заавал цагаан хоолтон болох ёстой ” хэмээн тулгаж хэрхэвч болохгүй. Харин яагаад цагаан хоолтон болох ёстой вэ гэдэг дээр сайтар мэдлэг олгох хэрэгтэй юм: “Бидэнд өөр сонголт бий. Та амьд үлдэхийн тулд бусдын амийг хороох албагүй ”. Дараа нь хүмүүс сонголтлоо хийх болно. Харин тэдэнд сонголт хийхэд нь туслаж үнэн зөв мэдлэг олгох чухал юм. 



Хүний амьдралыг Архи, Тамхи ба Мах хэрхэн сүйтгэдэг вэ – нүд хальтармаар дүн



Хүн амьдралынхаа туршид мах, архи болон тамхиныхаа хэрэглээнээс болж ямар аймшигтай өр төлөөс төлдөг талаар статистикийн мэдээнээс авч доор харуулав. Бид өөрсдийн бусармаг, бодлогогүй үйлдлээрээ газар дэлхий дээрх амьд хүн амьтны амьдралыг хорлон сүйтгэж хувийн болон нийгмийн амьдралаа бусниулж хаясаар байх уу?

Амьтны Амь: 424 тэр бум

Мэдээлэл авсан: 2005 FAOSTAT, Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага, НҮБ 7

Архи - бодит зардал

Амьдрал	<ul style="list-style-type: none"> • Жил бүр дэлхий дээр нийт 1,800,000 хүн үхэж байна • 1 жилд 60 сая жилтэй тэнцэх хэмжээний амьдрал үгүй болон устаж байна
Сэтгэлийн Шаналал	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хүчирхийлэл: гэмт хэргийн 50% • Гэр бүлийн хүчирхийлэл: гэмт хэргийн 30% • Зэрлэг харгис үйлдэл : гэмт хэргийн 40–80% • Амиа хорлох: гэмт хэргийн 20-50%
Тархины гэмтэл	<ul style="list-style-type: none"> • Архидан согтуурах: архи уун согтуурч хэлсэн, хийснээ санахгүй байх • Нойрны өвчин: орон гаран унтах • Ой санамжаа алдах ба шизофринтэй болох: суралцах чадваргүй; одоо болж буй явдлуудаа тэр дороо мартдаг болох ба дээр үеийнхээ хамаг юмыг мартаж; хараа муудах, хий дэмийрэх • Тархи агших <ul style="list-style-type: none"> * Тархины хальс(сонсгол, ойлгоц,яриа) * Хишпокампус (ой санамж, жолоодох); Бага тархи (зохицуулах, тэнцвэржилт); Сабкортикал хальс (удаан хугацааны ой санамж)
Бие эрхтний ажиллагааг сулруулах нь	<ul style="list-style-type: none"> • Нүд (архи тамхитай холбоотой амблиопиа [‘лазан нүд’]); зүрх, элэг, бөөр, улаан хоолой, ходоод, нарийн гэдэс, нойр булчирхай, мэдрэл, цусны эд эс, булчин, яс, бэлэг эрхтэн, түрүү булчирхай
Төрөлтийн гажиг	<ul style="list-style-type: none"> • Мэдрэлийн согог: Барууны орнуудад хамгийн их газар авсан өвчин • Архины синдром: Өсөлт зогсох; хэлбэргүй нүүр царайтай болох • Хүүхэд гэнэт нас барах синдром • Үр зулбах

Тамхины жинхэнэ Үнэ Цэнэ

Амьдрал	<ul style="list-style-type: none"> • Жил бүр дэлхий дээр нийт 5,000,000 хүн үхэж байна • Жилд 61,000,000 сая жилтэй тэнцэх хэмжээний амьдрал устан алга болж байна.
Эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> • Уушиг, багалзуур хоолой, төвөнх, зүрхний цусан хангамж, тархи, арьс, амны хөндий, ходоод гэдэсний үйл ажиллагаа, нойр булчирхай, цусны өвчин • Хараагүй болох, дүлийрэх, үнэрлэх мэдрэмжээ алдах • Энерги дутагдах, анхаарал төвлөрүүлж чадахгүй байх, дарамтанд орох • Ам өмхийрэх, үс, шүд унах
Хайртай хүмүүс	<ul style="list-style-type: none"> • Бусдыгаа шууд бус хэлбэрээр хордуулах • Хүүхдүүд багтраа тусах магадлал өндөр, хүүхэд гэнэт нас барах, синдром, бронхит тусах, чихний өвчин

Махны хэрэглээ - Хамгийн өндөр зардал

Хүний Амьдрал (2002 он)

<i>Өвчлөлт</i>	# Нийт нас баралтын тоо (Хэмжих нэгж: саяар)	<i>Мах идсэнээс болж %</i>	# Махтай холбоотой нас баралт (хэмжих нэгж: саяар)
Бүх төрлийн өвчин	57.03		--
Зүрхний цусан хангамжийн өвчин	16.73	85 ¹	14.20
Хорт хавдар	7.12	60 ²	4.27
Халдварт өвчин	10.90	61 ³	6.60
Чихрийн шижин	0.99	50 ⁴	0.50

25.57 сая

Жилийн амьдрал устаж үгүй болж байна = 162 сая

Мэдээлэл авсан: Дэлхийн эрүүл мэндийн тайлан 2004, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Эмнэлгийн зардал (зөвхөн АНУ-д):

нэг жилд \$30-60 тэр бум

Мэдээлэл авсан: "Махны хэрэглээнээс үүсэлтэй өвчин эмгэгийг эмчлэх эмчилгээний зардал" Prev. Эм, эм тариа. 1995-

11 сар;

24(6):656-7.6



Шинэ эрин үе Шинэ бодол санаа Шинэ хандлага

Авшигтан Чэн ах, Тайпэй, Формоса (хятад хэл дээр)

Эрт дээр үеэс хүмүүн бид дайтах цагтаа дайтаж, эвлэрэх цагтаа эвлэж, хөгжил дэвшилтэйгээ хамтдаа урагшилсаар ирсэн бөгөөд аз жаргалын төлөөх эцэж цуцашгүй хүсэлдээ хөтлөгдөн он удаан хүнд жилүүдийг ардаа орхиж дээ. Өнөөдөр дэлхий дээр олон хүмүүс сайн хоол идэж, сайхан хувцаслаж амь зогоохын тулд тэгтлээ тэмцэх шаардлагагүй болсон хэдий ч жинхэнэ сэтгэлийн амар амгаланг олтлоо өдий байгаа мэт санагдана. Улс төр, эдийн засгийн хийрхэлд эцэс төгсгөлгүй автах хүмүүн бид сэтгэлийн дарамтанд живж, өдөр тутмын үүрэг хариуцлагаас болж бие сэтгэлээр давхар зовж шаналан, амьдралыг жинхэнэ утгаар нь ойлгож, мэдэрч, сайхныг нь амсах цаг зав өөрсөлдөө гаргаж чадахгүй байх шиг. Шашин хоорондын утгагүй мөргөлдөөн өдөр ирэх тусам ширүүсч, удахгүй дэлбэрэх гэж буй галт уул мэт оволзох юм. Харин дэлбэрвэл үр дагавар нь ямар хэмжээний аюул, хор хохирол авчрах уршигтайг хэн хүнгүй мэдэж байгаа нь ойлгомжтой. Дээр өгүүлсэн нөхцөл байдалд үндэслэж Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүн бид уршигтай үйлдлээ үндсээр нь засч залруулахын тулд ямар шийдэлтэй арга хэмжээ авч болох талаар зөвлөснийг доор дурьдав.

Улс төр

Бүхий л улс үндэстний ард түмэн дургүй байлаа ч гэсэн улс төрийн хатуу дэглэмийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Багшийн хэлснээр, “Энэ дэлхийд тулгарч буй хүнд асуудлуудаас болж ямарваа нэг улс төрч, аливаа улс орны эдийн засгийн систем болон ямар нэгэн улс орны ‘изм’ үзлийг буруутгах нь дэмий хэрэг юм. Харин дотоод чанараа хөсөр хаяж, хичнээн агуу гэдгээ мэдэхээ байсан сэтгэлээ, амар амгалангийн эрэлд хөтлөгдөн дахин дахин төрж мэндэлж байдгаа мартсан оюун ухаанаа болон бид зөвхөн хайраас бүтдэг гэдгээ ухаарахаа больсон мунхаглалаа л буруутгах ёстой. Тиймээс Гэгээрэл бол бүх өвчин эмгэг, дэлхий нийтэд тулгамдсан асуудлууд

болон дайн дажинг устган үгүй хийж чадах цорын ганц зам юм!” (#37 Мэдээ сэтгүүлээс ‘Багш айлдахдаа—Амьдралаа үнэл, Гэгээрлээс эхэл’).

Ямар арга хэмжээ авч болох талаар Багш зөвлөх нь, “Хүмүүс гоц ухаантныг эрж хайх хэрэгтэй, зөвхөн Засгийн Газар болон улс төрчдөд найдаад зүгээр суугаад байж болохгүй. Жинхэнэ санал хураалтыг жирийн иргэд санал болгох ёстой юм шүү дээ. Ард түмэн өөрсдөө л хэн хэний нэр дэвшүүлэхийг шийдэж жагсаалт гаргах ёстой, дараа нь олноороо зөвшөөрөх эсэхээ шийдэх хэрэгтэй. Иймэрхүү тохиолдолд ухаантай, авьяастай жинхэнэ удирдагч болох эрхтэй хүмүүс сонгуулийн сурталчилгаанд зориулж ямар нэгэн хэмжээгээр мөнгө төгрөг зарцуулах шаардлагагүй болно.” (#51 Мэдээ сэтгүүлээс ‘Багшийн Үгс—Ухаантай, авьяастай хүмүүсийг сонго’).

Багш үргэлжлүүлэн, “Ернэдэлхийн хэмжээнд Ерөнхийлөгчийн сонгуулийн системийг өөрчлөх хэрэгтэй гэж би боддог. Жишээ нь, ерөнхийлөгч сайн байлаа гэж бодоход ажлаа үргэжлүүлээд хийх ёстой биш үү. Яагаад заавал шинэ сонгууль, шинэ ерөнхийлөгч хэмээн хөөрцөглөж баахан мөнгө дахин дахин үрэх шаардлагатай юм бэ? Хэрвээ ерөнхийлөгч маань үнэхээр агуу хүн байж таараад өөрийгөө хэрхэн рекламдахаа мэддэггүй байвал яах вэ, магадгүй зөв сурталчилгаа хийх стратеги байхгүй байж болно шүү дээ? Тэгвэл агуу ерөнхийлөгч маань сонгуульд ялагдаад өөр хүн ерөнхийлөгч болноо доо. Ялагч болсон хүн маань бизнесийн хурц ухаантай, зар сурталчилгааг ашиглаж өөртөө байдлыг хэрхэн урвуулж болохыг мэддэг, маш их мөнгөтэй баян, бас хээл хахуульд мэргэжсэн нөхөр байж болохыг үгүйсгэх аргагүй. Зүгээр л нэг иймэрхүү юм боллоо гээд төсөөлөөд үз дээ, ингээд л бид чадвартай хүмүүсээ алддаг байх нь! Шинэ нөхөр ажлаа сайн хийж чадахгүй байж магад. Тэгээд 2 юм уу 3 жилийн үүрэгт албаа хаших богино хугацаанд улс орны ерөнхийлөгчийн хувьд тэр юу хийж чадах вэ?” Үүн дээр Багш мөн хэлсэн нь, “Түүнчлэн алдар нэр, эд баялгийн төлөөх тулаан болж хувирна. Энэ ч тийм сайн юм бишээ. Магадгүй үнэлгээний стандартад өөрчлөлт хийх байх гэж би найдаж байна. Хэрвээ ерөнхийлөгчийн хийсэн ажилд тодорхой шалгуураар үнэлгээ хийсний дүнд Ерөнхийлөгч ажлаа хүлээн авснаас хойш тухайн улс орны эдийн засаг, соёл урлаг, дипломат харилцаа болон нийгмийн тогтворжилтонд тодорхой хэмжээгээр дэвшилт авчирч чадсан гэж үзвэл дахин сонгогдох эрхтэй байх ёстой. Ингэвэл олон асуудлаас аврагдана шүү. Мэдээж хэрэг, үгүй тохиолдолд нөгөө л нэг ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад гэдэг шиг цаг зав, мөнгөө үрсээр л байх болно. Бид ер нь зөв хүнээ ерөнхийлөгчөөр сонгож чаддаг бил үү, тиймээс түүнийг ажилд нь үлдээх хэрэгтэй. Ингэх нь хамаагүй дээр байх болов уу гэж би боддог юм. Мэдээж хэрэг ардчилсан үзэл баримтлалын дагуу, цаг ч бага үрэх болно, яагаад гэвэл хүн бүр ерөнхийлөгчөөр сонгогдоод байвал утгагүй. Бүх зүйл ойлгомжтой байх болно.” (Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Нийгмийн төвөгтэй байдалд зохицож өөрийгөө авч явах нь видео хичээлээс, Шиху, Формоса, 11 сарын 5, 1995, DVD #512).

Эдийн Засаг

Өдрөөс өдөр ирэх тусам гүнзгийрч буй баян хоосны ялгааг устгахад дэлхийн хүмүүс анхаарах цаг нь болжээ. Хүмүүсийн аж амьдралыг хамгаалах хэрэгтэй, хүмүүс ажил хийхдээ дуртай байх ёстой. Багш айлдах нь, “Одооноос 2000 жилийн дараа хүмүүс тэтгэлээ ажиллах хэрэггүй болох байх гэж би төсөөлж байна. Бид шал өөр системтэй болно, арай ухаалаг систем гэх үү дээ, хүмүүс зүгээр сонирхлын журмаар ажил хийж магадгүй, гэвч мөнгөний төлөө биш. Хүн бүр өөрт хэрэгтэй бүхнээ үйлдвэрлээд түүнийгээ бусадтайгаа хуваалцах болно. Энэ



нь ч дээр, яагаад гэвэл хэрвээ эрчүүд цаг зав ихтэй болчихвол өөртөө оюуны ч юм уу, сонирхлын ч юм уу, илүү их хөрөнгө оруулалт хийх боломжтой болно. Чөлөөт цагаараа ямар нэгэн юм үйлдвэрлэж, суралцаж, өөрийгөө өөр ажилд сургаж, мөн оюун ухаанаа зөвхөн сонирхлоо хөгжүүлэхэд ашиглана. Ер нь заримдаа хүмүүс, сонирхлоо дагаж хүч энергээ зарцуулахад арай илүү үр дүнд хүрэх тохиолдол байдаг шүү дээ. Миний бодлоор хүн бүр хагас өдөр л ажиллах ёстой. Тэгэхэд л хангалттай, нөгөө хагасыг нь сонирхлоо хөгжүүлэхэд зарцуулахгүй юу, дуртай зүйлээ зохион бүтээгээд л, ямар нэгэн юм бодож сэтгээд л, судлаад л гэх мэт” (Багшийн Буруу бодлууд хүн төрөлхтнийг сүйрүүлэх аюултай видео хичээлээс, Бангконг, Тайланд, 9 сарын 14, 1994, видео хуурцаг #446).

Боловсрол

Практик мэдлэгийн эрэлд явах нь зөв ч гэлээ, хүн ер нь өөрийнхөө оюун санааны хөгжилд анхаарч, боловсруулах нь юунаас илүү чухал юм. Саяхан зүүн Өмнөдөд болсон Мусульманчуудын бослого бол тод жишээ юм л даа, юу гэхээр аливаа шашин шүтлэгийн үндэс суурийг дутуу ойлгосноос болж зөрчилдөөн үүсч бий болдог. Бүхий л шашин шүтлэг, улс төрчдийн хоорондын ялгааг эс тооцвол тэдний дунд нэг ижил тал бий; Үнэний мөрийг хөөх хүсэл. Тиймээс бид аливаа шашин шүтлэг дэх өнгөн талын мухар сүсэглэлийг үл тоож, харин жинхэнэ мөн чанарыг нь таньж мэдэхийг зорих хэрэгтэй.

Энэхүү санаанд үндэслэж Багш доорх шийдэлд хүрсэн юм: “Бүх Их Сургуулиуд аливаа шашны номын маш өргөн цугуулгатай номын сантай болох хэрэгтэй. Тэгвэл оюутнууд хамтдаа тайван гэгч нь сууж байгаад өнгөрсөн үеийн Их Багш нарын үзэл баримтлалын талаар чөлөөтэй ярилцаж хэлэлцэх болно. Бидэнд ч амар, учир нь хөршийнхөө болон найз нөхдийнхөө сүсэг бишрэлийг ойлгодог болчих тул, мөн шашин хоорондын мөргөлдөөн болон иргэний дайн гэх мэт балай зүйлс ч нэг их гарахгүй.” (Багшийн Яагаад шашин хоорондын мөргөлдөөн үүсдэг вэ хичээлээс, Тайчунг, Формоса, 11 сарын 16, 1988, видео хуурцаг #18). Дээр дурьдсан хэрэг бол зөнч Мухаммадыг шогчлон сонинд гаргаснаас болж дэлхийн хэмжээнд самуун үүсгэхэд хүргэсэн юм. Хэрвээ хүмүүс үнэхээр л мөнхийн энх тайван, амар амгалан дунд амьдрахыг хүсч байгаа бол бие биенээ ойлгож, бие биенээсээ суралцах цаг болсон баймаар.

Үндэсний аюулгүй байдал

Үндэсний аюулгүй байдлын талаар Багш айлдахдаа: “Засгийн газрууд өөрийн улс орны эрчүүдийг хэрхэн сэтгэл хангалуун байлгаж болох, хүний хүч хөдөлмөр, мөнгө төгрөгийг буу зэвсэгт зарахгүйгээр улс орноо хамгаалах, хөрш зэргэлдээх болон дэлхийн бүхий л улс орнуудтай тэдэнд дуртай цагтаа ирж очиж байх бүрэн эрх чөлөө олгохгүйгээр эв найрамдалтай байж, улс орныхоо эрх ашгийг хамгаалан үндэсний эв нэгдлийг хэвийн хэмжээнд барьж байх талаар мэдэж байх ёстой.” (Багшийн Улс оронг юу агуу болгодог вэ хичээлээс, Сингапур, 3 сарын 8, 1993, видео хуурцаг #327)

Хил дамжсан асуудлыг хэрхэн зохицуулбал зүйтэй вэ гэсэн асуултанд Багш хариулсан нь, “Хүмүүс бие биенээсээ ялгарахыг хүсдэг тул өөр хоорондоо дайтаж байдаг, махан биедээ шаардлагатай байгаа бүхнээ олж авахын тулд бие биенээ алж хөнөөдөг. Үүнээс гарах цорын ганц зам бол бид зөвхөн махан бие цогцсоос тогтдог юм биш гэдгийг ухаарах явдал юм. Тэгвэл хэн ч бидний эсрэг юм хэлэхээ больж, эдийн засгийн хувьд ч тэр, улс төрийн хувьд ч тэр аюулгүй болно.

Гэгээрэл бол үлдэж буй цорын ганц үнэн хариулт юм шүү, хэрэв тэгж бодохгүй бол бид нөгөө л нэг махан бие цогцостойгоо зууралдаж, идэж уухаа булаалдан, авгай хүүхнээ хулгайлалцаж, улс орон руу тань халдан довтолсоор байх болно. Зарим улс үндэстнүүд зөвхөн эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс цар хүрээгээ улам өргөтгөхийн тулд хоорондоо дайтдаг. Хэмжээнээс хэтэрсэн олон хүн амаа тэжээхийн тулд, илүү удам газар нутагтай болохын тулд, зах зээлийн хүрээгээ тэлж, эдийн засгаа өсгөхийн тулд гэх зэргээр тэд дайтдаг. Хэдийгээр, үгүй ээ, ялгаа бий хэмээн зөрж болох авч, уг мөн чанарыг нь бодоод үзэхээр, бүгд махан бие махбодын хэрэгцээнд тулгуурласан байдаг нь үнэн. Тиймээс хэрвээ бид гэгээрэлд хүрч чадвал иймэрхүү дайн дажин өөрсдөө л устаж үгүй болох юм шүү дээ. Тэгээд хүн төрөлхтний эв найрамдал, нөхөрлөл гэж юу болохыг жинхэнэ утгаар нь ухаарах болно.” (#102 Мэдээ сэтгүүлээс ‘Багшийн Үгс—Дотоод амар амгалан’).

Нийгмийн амьдрал

Багш маань настангуудын билэг ухааныг үргэлж нандигнаж явдаг билээ, мөн хүүхдүүдийн боловсролын асуудлыг бодлогогүй эцэг эхэд нь хариуцуулснаас, эмээ өвөөд нь даалгах нь хамаагүй дээр гэж хэлдэг юм. Цаашилбал, бид хэн ч өлсөж цангах зовлонгүй орчинг бүрдүүлж, хувь хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн гал тогоог хаа саагүй байгуулах хэрэгтэй. Энэ асуудлаар Багш нэмж айлдсан нь, “Та амьдралаа залгуулахын тулд ажил хийх хэрэггүй тийм зарим нэг дэвшилтэт нийгэм энэ ертөнцөд бий. Учир нь, нийтийн хэрэглээнд зориулан барьсан гал тогоо, хүмүүс хөдөлмөрлөж, хөлсөнд нь өөрт хэрэгцээт бараа материал сольж авах зориулалт бүхий дэлгүүр хоршооны газрууд хаа сайгүй байж байдаг ба мөн солилцох зүйл байхгүй ч гэсэн тодорхой хэмжээгээр авч болох аж. Харин илүүг авахыг хүсвэл арай өөр аргаар, жишээлбэл, амьдарч буй нийгэмдээ өөрийнхөө авьяас чадварыг ашиглан хувь нэмрээ оруулах ёстой, гэхдээ мөнгөний төлөө биш, зүгээр л аль алинд нь таатай санагдах байдлаар, өөрөөр хэлбэл, хүндэтгэлтэйгээр хувь нэмрээ оруулах” (#93 Мэдээ сэтгүүлээс, ‘Багш айлдахдаа—Ертөнц дэхь адилгүй ажиллах систем’).

Түүнчлэн, бид улс төр, эдийн засаг, боловсрол болон нийгмийнхээ тогтолцоог сайжруулах хэрэгтэй юм. Ингэснээр бид бүхэн хүссэн орчиндоо амьдарч, эрх мэдлийг үйлчилгээгээр сольж, хуваалцангаа өрсөлдөж, ойлголцонгоо шүүмжлэлцэх болно. Бид зөвхөн ганцхан газар дэлхийтэй гэдгээ ухаарч харилцан итгэлцэх ёстой юм. Бид хүмүүсийн бий болгосон яс үндэс, шашин шүтлэг болон өөр бусад ялгааг таягдан хаях хэрэгтэй. Энэ асуудал дээр Багш Арьяабалын бясалгагчдад хандан : “Бид бусдаас арай илүү түрүүлж гүйгээд байгаа юм шүү дээ, өөрөөр хэлбэл дэлхийн удирдагчид гэсэн үг, гэхдээ улс төрийн хөдөлгөөнд оролцож гавьяа байгуулснаар биш, хувьсгал удирдаж ялалт авчирснаар бус, зөвхөн хайр энэрэлийн хосгүй жишээ болон гялалзах удирдагчид юм. Бид ингэж л эх дэлхийгээ аврана. Бид ингэж л эх дэлхийгээ шинэ эрин зуун р+уу чиглүүлж, бие биенийгээ хайрлаж, бие биенийхээ төлөө гэх сэтгэлтэй болоход нь хөтлөх болно. Бид энд байх хугацаандаа хүн төрөлхтний сайн сайхны төлөө, дэлхий ертөнцийн амар амгалангийн төлөө амьдралаа зориулах ёстой юм. Бидний зөн билэг амьдралаас тасархай, холч, бидэнд алдах зүйл байхааргүй тийм ариун эрхэм байх ёстой. Ийм зөн билэгтэй байхад ямар ч хэцүү бэрхшээл жижигхэн болж, ямар ч хувь хүний төөрөгдлүүд утгагүй болж хувирдаг. Бид зөвхөн хоосон мөрөөдөөд л, төсөөлөөд л байна гэж би бодохгүй байна. Гэвч нэг л өдөр энэ бүхэн биеллээ олох болно” (#21 Мэдээ сэтгүүлээс ‘Багш хэлэхдээ—Шинэ Эрин Зуун руу Дэлхийгээ Хөтлөх нь’). ✨



Гэгээрсэн Удирдлага доор Гэрэлт Ирээдүйг Цогцлуулах нь

Багшийн захиалга болон үнэлэмжийн дагуу бэлтгэсэн мэдээ



Канад

Канадын засгийн газар ‘Газар Дээрх Диваажин’-г бий болгохоор хичээнгүйлэн зүтгэж байна

Торонтогийн мэдээний багаас (Англи хэл дээр)

Олон жилийн туршид Канадын Засгийн Газар олон улсын тавцанд энхийг сахиулах, дүрвэгсдэд тусламж хүргэх, хүмүүнлэг үйлсийн аянд оролцох, гамшигт нэрвэгдсэн бүст аврах ажиллагаа явуулах, мөн олон нийтийн эрүүл мэнд ба нийгмийн халамж буюу өөрийн орны ба дэлхийн бусад улс орнуудын ард иргэдийн эрүүл энх, сайн сайхныг дээшлүүлэх болон байгаль орчныг сэргээх зэрэг томоохон хэмжээний асуудлуудад ихээхэн анхаарч ирсэн билээ. Бусад улс үндэстнүүдийн төр засгийн удирдлагад үлгэр жишээ болохуйц хосгүй үйлсийг доор дурьдав.

Дэлхийн II Дайнаас хойш, гадаад харилцааны хувьд Канад улс үргэлж төвийг сахих үзлийг баримталж, өөрийн энхийг сахиулах армия дэлхийн хэмжээнд гарч байсан томоохон хэмжээний асуудалтай газрууд руу илгээж байсан юм. Иймэрхүү армийн цэргүүд, үүргийн дагуу ярвигтай цэгүүдэд оршин суудаг иргэдийн нийгмийн халамжийг дээшлүүлэх асуудлыг зохицуулдаг мэргэжлийн хүмүүсийн ажлыг давхар хийхэд хүрдэг байна. Канад улс дэлхийн хэмжээнд олон олон хүмүүнлэг үйлсийн аянд оролцож, гамшигт нэрвэгдсэн бүс нутагт аврах багаа илгээж байсан ба жишээ нь, түргэн тусламжийн багууд даруй илгээж, ундны ус, эм тариагаар хангах болон

гамшигт өртсөн газруудад урт хугацааны сэргээн босголтын ажилд туслах мөн тээвэр харилцааны тогтолцоог нөхөн сэргээхэд шаардагдах үндсэн дэд бүтцийг засварлахад туслах зэргээр гар татахгүй оролцдог аж. Түүнчлэн, Канад улс дэлхийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран янз бүрийн сэргээн босгох төслүүд дээр ажиллаж гамшигт өртөгсдийн амьдралыг бүтээн босгохын төлөө зүтгэдэг байна. Дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалах үүднээс Канад улс аливаа ялгаварлах үзлийг үл зөвшөөрөн, харин тусламж хэрэгтэй байгаа хүмүүст үүд хаалгаа нээн өгч, тэднийг амьдралд хөл залгуулахыг хичээн ажлын байраар хангаж, боловсролын үйлчилгээнд хамруулж, мөн эрүүл мэндийн халамжинд авдаг ажээ. Мөндүрвэгсдэд мөнгөн тусламж олгож, байр сууцанд оруулж, зээл олгох зэргээр Канадад хэрхэн амьдрах талаар чиглүүлж өгдөг байна. Канад улс олон нийтийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт үнэлүүштэй нэгэн том алхам хийсэн нь, 1976 оноос хойш цаазаар авах ялыг үгүй болгосон бөгөөд тэр цагаас хойш хүн амины гэмт хэргийн тоо ч харьцангуй багасчээ. Түүгээр ч барахгүй, бүхий л олон нийтийн болон албан газруудыг тамхигүй орчин болгон хуулиараа хориглоод өгсөн төдийгүй Канадын Дэлхийн Олон Нийтийн



Эрүүл Мэндийн Даатгалд бүртгэлтэй л бол тухайн хүний орлогын үзүүлэлт их бага байхаас үл хамааран, үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулдаг болжээ. Мөн Канадын Засгийн Газар бага орлоготой айл өрх, хувь хүн, ахмад настнууд, орон гэргүйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст орон сууц түрээслэхэд нь болон байрны засвар хийлгүүлэх зэрэгт хөнгөлөлт үзүүлж, улмаар түр орогнох байраар хангадаг байна. Цаашилбал, улс орныхоо хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлөх бодлого баримталж, залуу хүмүүст доорх хэлбэрээр тусламж үзүүлдэг ба үүнд:

а. Залуу хүмүүсийг коллежд суралцахад нь урамшуулан дэмжиж, хүүгүй зээл олгох

б. Ажлын байраар хангах (мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил хайх, ярилцлаганд бэлтгэх, гэх мэт.) өөрөөр хэлбэл, залуусыг ажлын талбарт хөл тавих тэрхүү шилжилтийн үеийн эмзэг байдлыг зөөлрүүлэх

с. Залуу хүмүүст байгаль экологийн талаар тодорхой мэдлэг олгох тал дээр анхаарч, янз бүрийн сургалтанд хамрагдах боломж олгон, байгаль дэлхийгээ хамгаалж

хайрлах сэтгэлгээтэй болгон төлөвшүүлэх

Мөн олон тооны ашгийн-бус буяны байгууллагууд улс орныхоо сайн сайхны төлөө хувь хэмрээ оруулж байна. Жишээ нь, Хүнсний Банкнууд орон нутгийн оршин суугчдаас хоол хүнс цуглуулж, нийгмийн халамжинд хамрагдагсад буюу өлсгөлөн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, настангууд, ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд болон орлого муу иргэдэд тараадаг ажээ. Тухайлбал, нэг эгнээ тарьж, нэг эгнээ ургуул нэртэй аяны хүрээнд цэцэрлэгч, ногоочдыг өөрсдийн дуртай хүнсний ногоог нэг илүү эгнээ тарьж ургуулан, хураасан ургацаа нутгийн хүнсний банкинд хандив өргөхийг уриалсан хөдөлгөөн зохион байгуулдаг байна. Түүнчлэн, Чэрний Хүнс (факсийн машины болон принтерийн хор дахин боловсруулах) хөтөлбөр нь маш олон шагнал хүртсэн төсөл ба хэрэглэсэн принтерийн хор болон гар утсыг цуглуулан дахин боловсруултанд оруулж, олсон орлогоор нь байгаль дээрх хог хаягдлыг цэвэрлэх, мөн өлсгөлөнд нэрвэгсдэд туслах үйл ажиллагааг санхүүжүүлдэг ажээ. ✨



Австрали

Австралийн засгийн газар Үлгэр Жишээ боллоо

Австралийн мэдээний багаас (Англи хэл дээр)

Олон жилийн туршид Австралийн Нөхөрсөг Холбооноос ард иргэддээ зориулж олон талт ашиг тус бүхий янз бүрийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж иржээ. Үр дүнд нь Австраличуудын амьдралын түвшин өндөр, мөн эрүүл энх аж төрж, хамгийн дээд зэргийн эрүүл мэндийн (эм тариа, эмчилгээнээс авахуулаад өтөлж хөгшрөхөд нь хүртэл тусгайлан харж хандах) үйлчилгээний бүх түвшинд хамрагддаг ажээ. Австралийн Засгийн газраас эрүүл мэндийн салбарт ихээхэн



хэмжээний хөрөнгө зарцуулдаг ба эрүүл мэндийн судалгаа болон эмнэлгийн сургуульд сурч буй оюутан залуусыг сайтар сургахад анхаарч, санхүүжүүлэгч гол эх үүсвэр нь болдог байна. Түүнчлэн, 2006 оны 3-р сард Ажлын Сонголт нэртэй хууль хэрэгжүүлж эхэлсэн ба уг хуулийн заалтанд ажилчдын эрх ашгийг хамгаалах талаар, өөрөөр хэлбэл, цалингийн доод хэмжээ, жилийн амралт, чөлөө авах, жирэмсний амралт, ажиллах хамгийн дээд цагийн хэмжээ, хууль бусаар ажлаас халагдах тохиолдолд хуулиар хэрхэн хамгаалагдах, ямар нэгэн эвлэлийн гишүүн болж элсэх, гишүүнчлэлээс гарах болон гэрээ байгуулах зэргийг бүгдийг нь нарийвчлан тусгажээ.

Мөн залуу хүмүүсээ дэмжих бодлого баримтлан, саяхнаас зурагтаар тусгай нэвтрүүлэг олон нийтэд цацдаг болсон ба агуулга нь хүүхдүүдийг биеийн тамир спортоор идэвхтэй хичээллэн, өдөрт ядаж 1 цаг дасгал хийж байхыг уриалдаг аж. Тэр ч байтугай Австралийн сөрөг хүчний намын удирдагч ноён Ким Бизли тус аяныг дэмжиж буйгаа илэрхийлээд хэлсэн нь: “Ямар ч улс

орны хувьд хийх ёстой хамгийн том хөрөнгө оруулалт бол хүүхдүүдийн эрүүл мэнд юм.” гэв.

Түүнчлэн, 1974 оноос эхлэн Австралийн Олон Улсын Хөгжлийн Албаны зүгээс (AusAID) ихэнхдээ Ази Номхон далайн орнуудад, мөн зарим нэгэн Африкийн болон зүүн азийн хөгжиж буй орнуудад тусламжийн гараа сунгасаар иржээ. Ийнхүү тус Алба өнөөг хүртэл нийт 58 сая гаруй хүнд ач тусаа өгсөн байна. Тухайлбал, Номхон Далайн бүсийн орнуудын хэмжээнд тухайн бүс нутгийн боловсролын байгууллагуудад мастерийн зэрэг горилж буй оюутнуудад тэтгэлэг олгон, мөн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд олон тооны хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх вакцинд хамруулжээ. Мөн инженерийн хөтөлбөрийн хүрээнд Африкийн 500,000 хүмүүсийг ундны усаар хангасан аж. Ийнхүү Австралийн төр засгийн удирдагчид бүтээн байгуулалтын гэгээлэг аянаа үргэжлүүлэн явуулж, Австралийн ард иргэд болон дэлхийн бусад улс орны хүмүүсийн аж амьдралыг дээшлүүлэхэд үе үеийн туршид бие сэтгэлээрээ оролцсоор байх болно гэдэгт найдаж байна. ✨



КОСТА РИКА

Ямар ч цэргийн хүчин байхгүй Коста Рика

Лаура Чэн, Сан Жоүз (Испани хэл дээр)

1948 оны 12-р сарын 1-нд Коста Рикийн ерөнхийлөгч ноён Жос Фигүэрэс Феррэр иргэний дайнд ялсны дараагаар Коста Рикийн үндэсний армийг үгүй болгосон билээ. Ийнхүү урьд өмнө нь цэргийн ангийнхны зардалд явдаг байсан холбооны төсвийн санг аюулгүй байдал, боловсрол болон соёл урлагийн салбарт тус тус зарцуулахаар болжээ. Дараа нь 1986 онд Ерөнхийлөгч ноён Оскар Ариас Шбнчээ 12-р сарын 1-нийг Коста Рикид “Цэргийн хүчийг устгах өдөр” болгон зарласан байна. ✨



ШИНЭ ЗЕЛАНД

Эрүүл энх, амар амгалан амьдралыг хайрлагч орон

Тэрри Принс, Христчөрч (Англи хэл дээр)

Генетикээр өөрчилсөн хоол хүнсийг зохицуулах нь

Шинэ Зеланд улс генетикийн аргаар өөрчилсөн амьд бие организм (ГӨО) буюу өөрийн нутаг дэвсгэрт байдаггүй амьд бие организмууд (ГӨА-г оролцуулан)-ыг ашиглах явдалд хатуу хяналт тавьж, 1996 оны “Аюултай бодисууд ба Шинэ амьд бие организмын тухай” хуулиар давхар зохицуулж байдаг ажээ. Тус хуулинд бүхий л шинэ амьд организмуудыг Шинэ Зеланд улсад гаргаж, нээлттэй ашиглахаас өмнө, нэг бүрчлэн нарийн шалгасны эцэст зөвшөөрөл олгоно хэмээн заасан байдаг.

Тиймээс Шинэ Зеланд улсад ямар ч шинэ бүтээгдэхүүнийг генетикийн аргаар өөрчилдөггүй байна. Мөн тус улсад худалдаалагдаж буй гаднаас импортлосон зарим нэгэн боловсруулсан бүтээгдэхүүнүүд генетикийн аргаар гаргаж авсан орц байж болох авч, хуулийн дагуу шинжилгээнд оруулж, аюулгүй эсэхийг тогтоох ба ердийн тохиолдолд тухайн бүтээгдэхүүний ГӨО-н концентрац 1%-аас илүү гэдгийг заавал хаяг шошгон дээр тэмдэглэсэн байх ёстой аж. Шинэ Зеландын нийгмийн амьдралд ГӨО-н эзлэх байр суурийг тодорхойлоход шийдвэр гаргах ажиллагаатай холбогдуулан Шинэ Зеландын Засгийн Газар Той Тэ Тайао буюу

Биозтикс Зөвлөлийг байгуулсан бөгөөд энэ нь олон нийтэд яриа хийж, Засгийг газарт генетик өөрчлөлттэй холбоотой оюун санааны, соёл урлагийн болон ёс зүйн асуудлууд дээр зөвлөгөө өгч байх үүрэгтэй юм.

Энхийг сахиулах /Цөмийн зэвсэггүй/ Зэвсэг хураалт, зэвсэгт хяналт тавих тухай

Ардиргэдийнхээрүүлмэндэдонцгой анхаардаг Шинэ Зеланд улс дайн дажин, харгис үйлдлийг тууштай эсэргүүцэж, энх тайвныг дэмжих ажиллагаанд байнга идэвхтэй оролцож ирсэн билээ. Жишээ нь, Шинэ Зеланд улс НҮБ-ыг үүсгэн байгуулагч улс орнуудын тоонд зүй ёсоор ордог бөгөөд Шинэ Зеландын Цөмийн Зэвсэггүй Бүс ба Зэвсэг Хураалт, Зэвсэгт Хяналт Тавих нь хуулиараа дамжуулан дэлхийн энх тайвны төлөө тууштай тэмцэгч гэдгээ харуулж, түүгээр ч зогсохгүй Хүний Эрхийг Дэлхий Дахинд Тунхаглан Зарлах гэрээ, Иргэний болон Улс Төрийн Эрхийг Баталгаажуулах Олон Улсын гэрээ болон Цөмийн Зэвсэг Дахин Үл Үйлдвэрлэх гэрээ зэрэг олон тооны олон улсын энхийн гэрээ хэлэлцээрт гарын үсэг зуралцсан байна.



Цаашилбал, Шинэ Зеланд Улс НҮБ-ын Югослав, Кампуч, Зүүн Тимур, Сомали болон өөр бусад дэлхийн улс орнуудад ээлж дараалан гүйцэтгэсэн энхийг сахиулах ажиллагаанд оролцож, Номхон Далайн Бүсийн улс орнуудын дунд энх тайвныг дэмжих ажиллагаанд яриангүй гол үүрэг гүйцэтгэсэн улс болсон юм. Жишээ нь, Боүгэйнвиллийн арал дээр Шинэ Зеландын дипломатчид очиж, 200,000 хүний амь амьдралаар дэнчин тавьсан байсан салан тусгаарлагчидтай хэлэлцээрхийсний үрдүнд

уг явдлыг төгсгөл болгосон. Мөн 2003 онд олон улсын хэмжээнд тавигдсан хүсэлтийн дагуу олон үндэстний цагдаа нарын баг бүрэлдэхүүн Соломоны арлууд руу иргэний дунд өрнөсөн үймээн самууныг зогсоож, энхийг сахиулахаар явжээ. Энэ бүхнээс Шинэ Зеланд улс ард иргэдийнхээ эрүүл мэнд, сайн сайхан байдалд онцгой анхаарч байдаг төдийгүй олон улсын түвшинд улс орнуудын хамтын нөхөрлөлийг байнга дэмжиж байдгийг харж болох юм. ✨



СЛОВЕНИ

Словенийн Ерөнхийлөгч цагаан хоолтон болж, ариун энэрэнгүй амьдралыг сурталчлах хөдөлгөөнд идэвхтэй оролцсон нь

Дамжан Кавасис, Лжүблжана (Словень хэлээр)

Словенийн ерөнхийлөгч ноён Жанэз Дрновск энэрэнгүй нэгэн хүмүүнлэгийн ажилтан Сбөгөөд өөрийгөө эдгэршгүй хорт хавдар туссан гэдгийг дуулаад амьдралынхаа хэв маягийг өөрчилж цагаан хоолтон болох тухай бодож буй аж. Ийнхүү “Амьтдыг Чөлөөль” нэрт сэтгүүлд ярилцлага өгөхдөө тэрбээр цагаан хоолыг идэвхтэй нь аргагүй сурталчилжээ. Түүнчлэн, ноён Ерөнхийлөгч Дрновск Дарфур дахь дүрвэгсдийн өрөвдөлтэй байдлыг сонсоод санаа нь ихэд зовниж, тэр даруй тэдгээр хүмүүсийн буй хүнд нөхцлийг хөнгөвчлөх үүднээс дэлхий дахиныг хамарсан аяныг эхлүүлж, НҮБ-ын ерөнхий



нарийн бичгийн дарга, ноён Кофи Аннан, Францын Ерөнхийлөгч Жак Ширак болон бусад том улс орнуудын удирдагчдад тус тус бараалхан, хөөрхийлөлтэй дүрвэгсдэд туслахыг уриалсан байна. Харин олон олон улс төрчид, сэтгүүлчид болон бусад хүмүүс Словени мэтийн жижигхэн орон олон улсын түвшинд яаж хүмүүнлэгийн ажил хийдэг байна аа хэмээн гайхахад хүрчээ. Ийнхүү ноён Дрновск хүмүүсийн асуултанд хариу болгон доорх билэг сэцэн үгсийг хэлжээ. “Бид хүмүүсийн ухамсрыг сэрээх хэрэгтэй

юм. Улс төрчдийг ч мөн татан оролцуулах хэрэгтэй. Улс төрчид өөрийн ухамсартаа хөтлөгдөн жирийн хүн шиг сэтгэж, нэр хүнд албан тушаалаа түр боловч мартаж хэрэгтэй юм. Жирийн ард иргэд зарим тохиолдолд удирдагчаасаа хамаагүй илүү ухаантай байдаг, яагаад гэвэл дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлууд болох ядуурал, гай гамшиг болон цаг агаарын өөрчлөлт хувьсалтанд тэд байнга санаа нь зовниж суудаг юм.” ✨



ГОЛЛАНД

7 Жилийн дотор үгүй болох орон гэргүй амьдрал

Рой Маннарт, Амстердам (голланд хэлээр)

Голландын 4 том хотуудын дарга нар хоорондоо гэрээ байгуулж ирэх 7 жилд багтаан гудамжны хүмүүсийг орон гэртэй болгох тухай хэлэлцсэн бөгөөд эхний 4 жилийн дотор орон гэргүй нийт хүмүүсийн 80%-ийнх нь асуудлыг нэг тийш шийдвэрлэсэн байна гэдэгт найдаж буй аж. Тус гэрээнд орон гэргүй хүмүүст байр сууцтай болоход туслах, мөн ажилд оруулж, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах талаар оролцогч талууд харилцан үүрэг хариуцлага хүлээх тухай заасан байна. Харин төслийн хүрээнд хотуудын гудамжинд шинээр орон гэргүйчүүд төрүүлэхгүй байх талаар онцгой анхаарах ёстой ба цаашилбал, Голландын Засгийн Газраас жил бүр 170 сая еврогийн хөрөнгө оруулалт хийхээр болж, 2013 он гэхэд орон гэргүйчүүд устаж, гудамжны амьдрал үгүй болно гэдэгт итгэж буй аж. ✨



Дэлхий маань Ариун Шудрага амьдралын хэв загварыг сонгон сэрж байна

АНУ-ын Флорида муж улс дахь багийн мэдээнэс:

Европт ан амьтны эрхийг хамгаалах шинэ хууль батлагдлаа



Европын холбооны парламент Ан амьтны нийгмийн халамжийн хуулийг засварлаж 2006 оны 1-р сарын 23-нд шинэчлэн баталсан нь Европт ан амьтны эрхийг хамгаалах тухай олон нийтэд таниулах цар хүрээг дээшлүүлэхэд чухал ач тустай шийдвэр боллоо. Шинэ хуулийн хүрээнд ан амьтдыг цэнэгт тор, тогоонд хорих зэрэг фермерийн аж ахуйн бусармаг, харгис үйлдлийг ойрын 5 – 10 жилд зогсоохоор төлөвлөж буй аж. Мөн түүнчлэн, амьтдын амьдрах байр, талбайн гадаргуу ба гэрэлтүүлгийн хэмжээг стандартын дагуу тогтоох тухай уг хуульд дэлгэрэнгүй тусгажээ.



Европчуудын хүмүүнлэг сэтгэл

2005 оны эхээр амьтны гаралтай хүмүүнлэг бүтээгдэхүүнд (сүү, цагаан идээ) “Шинэ бүтээгдэхүүнд патент олгох систем”-ийн дагуу патент олгож эхлэхийн өмнө Европын 70,000 гаруй иргэдийн дунд Евробарометр судалгаа явуулжээ. Уг судалгаагаар Европчуудын дийлэнх нь амьтны гаралтай (сүү, цагаан идээ) нэрийн бүтээгдэхүүн нь

арай дориун хаяг, шошготой байх нь зүйтэй гэж үзсэн ба бараг 60 орчим хувь нь амьтны гаралтай хүмүүнлэг бүтээгдэхүүн худалдан авах дуртай гэжээ. Уг судалгааны тухай Европын холбооны комиссын гишүүн Маркос Кипрану: “Европын хэрэглэгчид амьтны эрх ашгийн төлөө тодорхой хэмжээгээр анхаарах болсон, харин тэд зохих мэдээллийн үндсэн дээр сонголтоо хийж байж тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг хүсч байна” гэж мэдэгдсэн байна. Ан амьтанд хандах олон нийтийн хандлага сүүлийн 10 гаруй жилд илэрхий өөрчлөгдөж байгаа болон амьтны эзлэх байр суурь ямар байгаа талаар дээрх судалгааны тайланд тэмдэглэжээ. Энэхүү үнэлгээнд тулгуурлан Европын холбооны иргэдийн дийлэнх нь дэлхий даяар амьтдын эрх ашгийг хамгаалах хөдөлгөөнийг урамшуулахыг Засгийн газраасаа шаардсан байна. Ийнхүү фермерийн аж ахуйн амьтдын эрх ашгийг хамгаалах тухай анхны олон улсын удирдамж гаргах талаар Дэлхийн Ан амьтдын эрүүл мэндийн байгууллагад санал дэвшүүлсэн ба 2005 оны 5-р сарын байдлаар 167 гишүүн орны бүлгэм уг саналыг хүлээн авч хэрэгжүүлэхээр болжээ. Мөн 2006 оны 2-р сард Их Британийн парламентаас тус улсад мөрдөж байсан амьтдын эрх ашгийг хамгаалах хуулийг үндсээр нь өөрчлөн баталж, мал аж ахуй эрхлэгчид болон амьтан тэжээгчдэд амьтдын төрөлх эрхийг нь хүндэтгэх, мөн тэдэнтэй зүй ёсоор харьцах тухайд хуулиар үүрэг, хариуцлага ногдуулах болсон байна. Хууль зөрчсөн тохиолдолд тухайн хүнийг 35000 хүртэл ам.доллараар торгох буюу 1 жил шоронд хорьж шийтгэх ажээ.



Хятад дахь сайхан өөрчлөлт



Бээжин 2004 оны 10-р сард мал аж ахуйн фермерийн амьтдыг аль болох бага зовоож нядлах тухай бүрэн эрхийг санал болгосон байна. Энэ хуулийн талаар Хьюстоны их сургуулийн доктор Петер Ли: “Урьд өмнө Хятадад ан амьтантай хэрхэн харьцах тухай асуудал хэзээ ч ийм их анхаарал татаж байсангүй. 90-ээд оны сүүлчээс Хятадын эрдэмтэд өөрсдийн санаачлагаар идэвхтэй хэлэлцүүлэг хийсээр ирсэн бөгөөд сүүлийн үед ан амьтантай харгис догшин харьцах явдал газар авснаар олон нийтийн анхаарлыг татаж, энэхүү харгис үйлдлийг таслан зогсоох үүднээс нийтээр хэлэлцэх сэдэв болжээ. Дэлхийн хүн амын дийлэнх хувийг бүрдүүлэгч Хятад улсад амьтны эрх ашгийг хамгаалах тухай дорвитой шинэчлэлт хийх нь тэдний зовлонг нимгэлж, тэдний аятай амьдралыг хөхүүлэн дэмжихэд чухал алхам болох юм” гэж тэмдэглэсэн байна.

Энэтхэгийн эрхэм өв



Энэтхэг улс ан амьтдыг олон зуунаар хайрлаж хамгаалж ирсэн эртний өв уламжлалт орон билээ. Тухайлбал, Энэтхэг хүмүүс амьтныг зовохоос сэрэмжилж зайлуулах ёс суртахууны үүрэг хүлээх талаар Үндсэн хуулиндаа заасан байдаг бөгөөд улмаар 2004 оны 3 сарын 11-нд Энэтхэгийн Дээд шүүхээс мөргөлчдийн хот Ришикешт өндөг худалдахгүй байх тухай хууль тогтоохоор шийдвэрлэсэн байна. Орчин цагийн ардчилсан ёсонд тэрслэхүйц хууль гэж маргалдсан орон нутгийн махны худалдаачдад шүүх энгийнээр сануулж хэлэхдээ: “Энэ нь мэдлэг соёл муугаас шалтгаантай юм. Энэтхэгийн хэд хэдэн нийгмийн бүлэглэлийн гишүүд зөвхөн цагаан хоолтон бөгөөд мах, загас, өндөг хараад айж зугтдаг” гэжээ. Одоогийн Энэтхэгийн төр засгийг Конгресс нам удирдаж буй бөгөөд Ерөнхий сайд,

Ерөнхийлөгч хоёулаа цагаан хоолтон ажээ. Түүгээр ч барахгүй 2006 оны 01 сарын 21-нд болсон Конгрессийн бүлгийн 3000 гаруй төлөөлөгч оролцсон их хурлыг цагаан хоолоор нээсэн байна. Эрт цагаас Энэтхэгт үхэр, гахайг олноор нь алж хөнөөснөөс болж шашны Хинду ба Мусульман бүлэглэлийн хооронд цуст мөргөлдөөн их болдог байв. Үүнээс улбаалан Дели дэх дээд Мусульман шашны зөвлөлөөс тусгай дүрэм гаргаснаар энх амгалан болжээ. Уг дүрэмд Энэтхэгийн мусульманчууд үндэсний баярын үеэр үхэр гаргаж болохгүй хэмээн заажээ.

Нидерланд дахь шинэ хөдөлгөөн



Нидерландад мал амьтны эрх ашгийг хамгаалах бие даасан улс төрийн нам байгуулагдаад байна. Тус нам нь олон сая Голланд хүний сэтгэлд нийцээд зогсохгүй 2004 оны Европын холбооны парламентын сонгуулиар бараг л нэг суудал авахаа дөхжээ.

Испанид болсон түүхэн үйл явдал



Барселон хот эртний бух тулалдуулах харгис спортыг хүчтэй эсэргүүцэж байгаагаа 2004 онд зарласнаар түүхэн үйл явдлын хот боллоо. Энэ спорт гээчийг 2005 онд Каталіно даяар хориглосон байна.



Ромын мэргэн хуулиуд



2005 оны 10-р сард Италийн Ром хотноо гэрийн тэжээмэл амьтдын тухай урьд хожид аль



ч улс оронд байгаагүй онцлог хууль гарлаа. Уг хуулинд тус хотын гэрийн амьтан тэжээгч иргэд нохойгоо өдөрт 1 удаа салхинд гаргаж байх заалт орсон бөгөөд хууль зөрчвөл 625 ам.долларын торгууль төлөх ажээ. Түүгээр ч зогсохгүй гэрийн тэжээвэр амьтдын эрх ашгийг хөндсөн ямарваа бодлогогүй үйлдэл хийх болон зэрлэг муур орогносон дүүргийн эргэн тойрон 800 м2 талбайд барилга барихыг хориглож, түүнчлэн Ром даяар амьтан орогнож буй байранд халдаж болохгүй гэж заасан байна. Тус хотын зөвлөх (Ромын хуулийг баримтлагч) хэлэхдээ: “Амьтад хүмүүс бидний оршихуйг утга төгөлдөр болгож байгаагийнхаа хариуд бяцхан халамж хүсэмжлэх эрхтэй” Харин бид тэдэнд энэрэнгүйн төлөөс болгож чадах бүхнээ хийх нь зөв. Манай хотын соёл иргэншлийг үүгээр хэмжиж болно” гэжээ.

Америк дахь сэрэлт



Хэдийгээр АНУ махны хэрэглээгээр дэлхийд удаах байранд ордог ч тэдний мал амьтантай харьцах харьцаанд гүнзгий өөрчлөлт орсоор байна. 2002 оны 11-р сард Флоридагийн иргэд мужийн үндсэн хуульд урьд өмнө байгаагүй засвар оруулсан ба энэ нь хээлтэй гахайны асаргаа сувилгааг сайжруулах тухай заалт ажээ. Энэхүү ухамсарт үйлдэл нь улмаар бусад ан амьтдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зарим хуулинд олны саналаар өөрчлөлт оруулахад хүргэжээ. 2006 онд Аризонад гахай, тугалын махыг худалдахыг болих болон Массачүсэтэд нохойн уралдааныг хориглох талаар санал хураалт явуулах ба ийм ажиллагаа бусад 8 мужид үргэлжлэн явагдах юм. Мөн 2006 оны 1-р сард Индиана мужийн Блүмингтон хот “мал амьтдын тухай” хуулиндаа “эзэмшигч” гэдэг үгийг “асрагч” болгон өөрчилжээ. Өөрөөр хэлбэл Блүмингтон хот урьд нь зөвхөн хүмүүсийн хүрээнд үйлчилж байсан хуулийн зарим эрхийг мал амьтанд эдлүүлэх зорилгоор амьтны хуулинд өөрчлөлт оруулж буй 14 дэх хот (Род Айланд мужийн хамт) юм.

“Тэжээвэр амьтан-Өмчлөлийн гэрээс” сан нь холбооны улсад хууль эрх зүйн шинэ

ухагдахуун болон гарч ирлээ. Энэ нь үр хүүхэддээ хөрөнгө өвлүүлж үлдээдэгтэйн адилаар эзэн нь насбарсан тохиолдолд эзэнгүй үлдэж буй амьтдыг эзнийх нь хөрөнгө мөнгөөр үргэлжлүүлэн тэжээж асрах сан юм. Энэ салбарт мэргэшсэн хуулийн профессор Жерри Бэсэр хэлэхдээ: “Урьд нь инээдтэй санагддаг байсан энэхүү санаа (Тэжээвэр амьтан-Өмчлөлийн гэрээс сан) бараг л ганц шөнийн дотор л нухацтай авч үзэх асуудал болж хувирлаа” гэжээ.

Шинжлэх ухааны бодит дэвшил




Эрдэм шинжилгээний судалгаа, туршилтаар амьтны эрхийг ноцтой хөндөж буй тухай Европ даяар халуухан хэлэлцэх болжээ. Европын холбооноос гаргасан амьтны эрхийг хамгаалах шинэ хуулиар “3R’s” (амьтдаар туршилт хийдгийг бууруулж, таслан зогсоон, өөр орлуулалт хийх) зарчимд тулгуурлан туршилтад амьтдыг ашиглах бус өөр хувилбараар солихыг улс үндэстнүүдээс шаарджээ. Мөн түүнчлэн Холбооны Конгрессоос дээрх хуультай ижил агуулгатай санал боловсруулах үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

2005 онд Нью Жерси мужийн хууль тогтоох байгууллага хэрвээ Холбооны хэмжээнд орлуулж болох өөр хувилбар байвал амьтнаар туршилт хийхийг хориглох тухайд санал нэгдэж байгаагаа илэрхийлсэн байна. Байгалийн ухааны хичээлээр задлан шинжилгээг компьютер болон видео хуурцаар орлуулан үзүүлж болох ба 2005 онд Торонтогийн их сургуулийн удирдлагын зөвлөл “Задлан шинжилгээ хийх сонголтууд” нэртэй бодлого нэвтрүүлж, түүнд оюутнууд задлан шинжилгээ гардан хийхгүй байх эрхтэй ба бусад боломжит хувилбаруудаас сонголт хийх боломжтой байх болно хэмээн заажээ.

Коллежууд ногоон болж байна



Ойрын жилүүдэд сургууль, коллежид цагаан хоолны цэсээр үйлчлэх нь элбэгшсэнээс



гадна Америк даяар эцэг эхчүүд ба оюутнууд цайны газруудаас жимс, хүнсний ногоо болон мах орлуулагчаар үйлчлэхийг шаардах болжээ. 2001 онд Флорида мужийн Маяами хотод доктор Антониа Детас насанд хүрээгүй 19 гэмт хэрэгтэн хүүхдэд хүнсний ногоогоор хэрхэн хоол хийх сургалт явуулж, бүгдийг нь цэвэр цагаан хоолны дэгээр 3 долоо хоног хооллож, өдөрт 8 шилэн аяга ус уулгасан байна. Бүх хөвгүүдийн бие бялдар, хүч чадал ба сурлагын үзүүлэлт илт сайжирч, түрэмгий ааш араншин нь зөөлрөн улмаар ирээдүйд зүрхний өвчнөөр өвдөх магадлалыг 30%-иар бууруулсан гэж үзжээ. Уг ажиллагааны үр дүнгийн талаар нийтлэгдсэний дараа доктор Детас өөр 5 мужийн сургуулиудад уригдан очиж өөрийн техник ажиллагааг заажээ.


Жонс Хопкинсийн их сургууль дахь Нийтийн эрүүл мэндийн Блүмберг сургуулийн дэд захирал, Алберт Швайзэрийн Хүмүүнлэг үйлсийн 2002 оны шагналт доктор Роберт Лоренс 2003 онд цагаан хоолтны үзэл баримтлалыг өөрийн сургууль дээрээ сурталчлах ажлын хүрээнд “Махгүй Даваа гаригууд” нэрт аяныг эхлүүлсэн бөгөөд тухайн үед уг хөдөлгөөн нь Америкийн эрүүл мэндийн сургуулиудын дунд тэргүүн байранд явж байжээ. Сүүлийн 30 гаруй жилд шинжлэх ухааны сэтгүүлүүдэд цагаан хоолтнуудын тухай нийтлэгдэх өгүүллийн хэмжээ 8 дахин өссөн ба цаашилбал, 1997 онд Америкийн Дистик (Хүнс тэжээлийн)-ийн холбооноос цагаан хоолтнуудыг дэмжсэн албан баримт бичиг гаргасан аж.

Ирээдүйн хоол хүнс



2005 оны 7-р сард Мариландын их сургуулийн лабораторид хоол тэжээлийн уургийн ширхэгийг ургуулан гаргаж авах эдийн засгийн хэмнэлттэй аргыг туршиж үзүүлсэн байна. Өмнөд Каролина дахь Анагаах ухааны

их сургуулийн эсийн инженер саяхан гал тогооны нөхцөлд ногоогоор “мах” үйлдвэрлэх талх баригчтай адилаар гэрийн цахилгаан хэрэгсэл санал болгожээ. Ер нь эсийн технологийн салбар хурдацтай хөгжиж байгаа нь хэрэглэгч ногооны мах хэрэглэж эхлэх цаг ойртсоныг илэрхийлж буй юм.



Түүнчлэн, Сансрын НАСА агентлаг сансрын цагаан хоол бүтээжээ. 2000 онд нэгэн төслийн хүрээнд био-нөхөн сэргээлтийг тэтгэх системээр (бичил биет болон ургамлаар нислэгийн багийн хоол хүнс, агаар усыг нөхөн сэргээдэг систем) ургуулсан ургацыг ашиглан 100 төрлийн цагаан хоолны жор тодорхойлсон байна. Улмаар Сансрын НАСА агентлаг уг цагаан хоолны жорыг туршин 30 өдрийн судалгаа явуулсны эцэст сансарт аялж буй хүмүүс цагаан хоолоор хооллохдоо үнэхээр баяртай байдаг гэсэн дүгнэлт хийжээ.



Дэлхийн тулгамдсан асуудлууд болох эрүүл мэнд, үхрийн галзуу болон амьтны гаралтай аймшигт өвчин эмгэг хүмүүст өөрийн эрхгүй нэгийг бодуулж, хүнсний ногоо, цагаан хоол сонгон хэрэглэх хандлага нэмэгдэж байна. 2006 оны 1-р сард явуулсан хүнсний зах зээлийн судалгааны тайланд ойрын 5 – 10 жилд амьтны гаралтай бүтээгдэхүүний 30-50% нь цагаан хоол буюу ургамлын гаралтай бүтээгдэхүүнээр солигдоно хэмээн тэмдэглэжээ. ✨



Манай гаригийн агаар ер бусын цэвэрхэн болно

Флоридагийн мэдээний багаас, АНУ (Англи хэл дээр)



Өнөөдөр дэлхий даяар нас баралтад нөлөөлж буй хоёрдогч том хүчин зүйл бол яах аргагүй тамхи бөгөөд одоогийн тамхичдын тал хувь нь эцсийн дүнд тамхиндаа хордож үхэх аюулд тулгарах болно. Эрдэмтдийн 50-иад жилийн туршид явуулсан судалгаа болон туршилтаар тамхи хүний биед маш хортой гэдгийг хэд дахин баталсан хэдий ч, хүмүүс тамхинд донтох нь хэвийн үзэгдэл болж, улс орнуудын Засгийн газрууд ч энэ бүхнийг хяналтанд байлгах хэмжээний чадамжтай хууль батлан гаргаж чадаагүй байна. Авууштай нь, сүүлийн хэдэн жилд дэлхийн хүмүүс тамхи үйлдвэрлэгч компаниудын үйл ажиллагааны эсрэг тууштай тэмцэж эхэлсэн ба тамхи татахыг хориглосон хууль эрх зүйн актууд батлагдаж гарчээ.



Ази дахь тамхины эсрэг ажиллагаа

Дэлхий бүхэлдээ тамхины эсрэг 🌟🌟🌟🌟🌟 гэнэт босч эхэлсэн тэр үед FCTC олон улсын гэрээ батлагдаж гарсан билээ. **Бутаны Хималайн Вант Улс** 2004 онд тамхи худалдаалахыг хориглосон хамгийн анхны улс болов. Бутаны энэхүү шийдвэр Энэтхэг улсад хил дамжин нөлөөлж чаджээ. Хятадын хойд зүгийн нутгуудад 1996 оноос хойш олон нийтийн газар тамхи татахыг хориглосон байна. Тус шийдвэр тийм ч үр дүнтэй болоогүй ба сүүлийн 10 жилийн туршид Хятадад тамхичдын тоо нилээд өсчээ. Хятад улс тамхины хэрэглээгээр толгой цохидог ба харин 2005 онд FCTC олон улсын гэрээнд **Хятад улс гарын үсэг зурсан нь ёстой** 🌟🌟🌟🌟🌟 **түүхэнд тэмдэглүүштэй явдал болов. 1996 онд гаргасан олон нийтийн газар тамхи татахыг хориглох тухай заалтыг Хятадын Засгийн Газар одооноос жинхэнэ ёсоор нь хэрэгжүүлэхээр зэхэж буй ажээ.**

🌟🌟🌟🌟🌟 Жишээ нь, 2005 оны 2-р сарын 27-нд, **Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхинд Хяналт Тавих Тохиролцоо (FCTC) гэрээг** батлан гаргасан ба олон улсын хэмжээнд тамхины үйлдвэрлэлийн салбарт ийнхүү хамгийн анхны удаа арга хэмжээ авч хэрэгжүүлж буй нь энэ юм. Тус гэрээг 124 улс орнууд зөвшөөрч баталсан бөгөөд түүхэнд хамгийн хурдан батлагдан гарч, хэрэгжиж эхэлсэн хууль болж мөнхөрлөө. Гарын үсэг зуралцсан улс орнууд тамхи сурталчлахыг хориглож, ирэх 5 жилийн дотор тамхи татахыг хориглосон хууль батлан гаргах ёстой юм.

Мөн, **Сингапурт Бутаны жишээг даган тамхигүй улс орон болохыг зорьж, тамхи** 🌟🌟🌟🌟🌟 **татахыг хориглох шийдвэр гарган мөрдөж эхэлсэн ба зөрчсөн тохиолдолд торгууль төлөх аж.** Хэрвээ олон нийтийн газарт тамхи татахыг оролдвол

\$600 ам.доллар, харин бага насны хүүхдэд тамхи худалдаалбал \$6000 ам.доллараар торгох юм байна.

Зүүн Азийн орнууд болох **Иран ба Сирид** ёстой цаг үеэ олсон олон сайхан өөрчлөлтүүд болж байна. Жишээ нь, тамхины  эсрэг хууль батлагдан гарлаа. Мусульман шашинтнуудын хувьд

хууль цааз гэхээсээ илүү шашныхаа удирдагч буюу мусульман хуврагийн хууль эрх зүйн талаарх үзэл бодлыг сонсох нь чухал бөгөөд энэ тохиолдолд үг дуугүй дагаж мөрддөг ажээ. Хамгийн гол нь тамхи татах эрүүл мэндэд хортой хоргүй нь сонин биш, харин Лалын шашны ёсонд хориглосон байдаг байна. Харин Мусульманчуудын ертөнцөд өсөн нэмэгдэх эрдэмтэд тамхины хор уршгийн талаар сайтар мэдээлэл тараасан нь сүүлдээ явсаар Засгийн Газрын удирдлагуудад хүрч, улмаар шинэ хуулийн төсөл боловсруулахад хүргэжээ. Ийнхүү

 Мусульман шашинтай улс орон бүр тамхи татахыг хориглох санал гаргаж байна. Мөн 2006 оны 3-р сард тамхичдын тоогоор тэргүүлэх байранд явдаг **Индонез улс нийслэл Жакарта** хотод тамхи татахыг тодорхой хэмжээгээр хоригложээ.

Европт тамхи татахыг хориглосон нь

НҮБ-ээс эхлүүлсэн тамхины эсрэг аяныг зохион байгуулагчдын цаана олонх нь Европчууд байлаа. 2005 оны 7-р сард Европын Холбооны гишүүн орнуудыг ямар нэгэн хэлбэрээр сонин, сэтгүүл, телевиз радио болон интэрнэт ашиглан тамхисурталчлахыг хориглосон шийдвэр Европын Холбооноос гаргасан байна. Харин нилээд хэдэн улс орнууд ажиллагааг эргэнээс хэрэгжүүлж эхлэн, олон нийтийн газар тамхи татахыг хориглосон байсан байна. Баарны орон Ирланд үндэсний хэмжээнд баар мэт битүү орчинд тамхи татахыг хориглосон анхны улс боллоо. Хэрвээ та тамхи татвал \$3600 ам.долларын торгууль төлөх аж.

Ирландын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, баталж гаргасан хуулийг Европын өөр бусад **Норвеги, Швед, Итали, Испани, Их Британи болон Орос** зэрэг улс орнууд ч авч хэрэгжүүлсэн ба зөрчсөн тохиолдолд өндөр торгууль төлөх ёстой аж. 1 жилийн дараа Италийн  тамхины эсрэг гаргасан хуулийн хүрээнд тамхины худалдаа эрс **(for each country)** буурч, бараг хагас сая гаруй хүн тамхинаас гарч байв. Хэдийгээр Испани маягийн амьдралыг тамхигүйгээр төсөөлөх хэцүү ч, хамгийн гайхалтай нь хүн амын 70% нь төр засгийнхаа гаргасан шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлжээ. Хамгийн сүүлд гарсан буюу шинэ тамхины эсрэг хуулийг парламентийн танхимд авч хэлэлцэхэд, хамгийн сонирхолтой нь, гишүүд байж болох хамгийн хэцүү хувилбар арга хэмжээнд саналаа өгсөн ба энэхүү явдал 2006 оны 2-р сард Их Британийн Нэгдсэн Вант Улсад болсон юм. Шинээр батлагдсан хориг арга хэмжээг дараа жилээс хэрэгжүүлж эхлэх ба баар цэнгээний газар хэмээн ялгалгүйгээр олон нийтийн газар тамхи татсан хэн боловч \$4000 ам.долларын торгууль төлөх юм байна.

 **Германд** мөн тамхитай тэмцэх нэгэн сонирхолтой аяныг эхлүүлсэн ба 4 долоо хоногийн турш тамхигүй байж чадсан тамхичдыг \$12,000 хүртэл ам.доллараар шагнасан байна. Мөнгөн шагналыг нэрээ бүртгүүлж, шалгалтанд хамрагдсан нөхдөд олгожээ. 2004 оны байдлаар нийт 90,000 орчим тамхичид нэрээ бүртгүүлсэн ба тэдний 3 хүн тутмаас 1 нь тамхигүй амьдарч сурч байгаа аж.

Америкт тамхийг үндсээр нь устгах нь

 Дэлхийн навчин тамхины эсрэг **Куба** бараг тэр чигээр нь хангадаг Куба улсад хүртэл 2005 оны 2-р сард тамхины хориг тавьжээ. Куба улсын улс төрийн удирдагч Фидель Кастро урьд нь архаг тамхичин байсан бөгөөд өвчнөөсөө болж хаясан



байна. Мөн Латин Америкийн улс орнуудын засгийн газрууд тамхины эсрэг хууль гаргаж хэрэгжүүлэхээр болсон ба 2006 оны 3-р сарын 1-нд Өмнөд

Америкаас **Уругвай** хамгийн  түрүүнд **ФСТС** олон улсын гэрээнд  гарын үсэг зурсан улс болжээ.

Харин энэ үед тамхитай тэмцэх хамгийн ширүүн тэмцэл тамхины үйлдвэрлэлийн гэр орон болсон Америкийн газар нутагт өрнөж байлаа. Өвчиндөө баригдсан тамхичид, тамхины үйлдвэрийн утаат байранд ажиллагсад болон тэдний эрүүл мэндийг хариуцагчдын өмнөөс мянга мянган шүүх танхимын өмсгөлтэй хуульчид тамхины асар том корпорацуудтай нүүр тулж байв. 1998 онд, Америкийн тамхины компаниуд шүүхийн танхимаас түүхэнд урьд хожид гарч байгаагүй их мөнгөн торгууль буюу \$200 тэрбум ам.долларын төлбөрт унаж ялагдал хүлээж байсан юм. Тэр үед мужийн засгийн газрууд тамхины компаниудыг шүүхийн танхимд ирэхийг шаардсан бол харин энэ удаад бүр ч аймаар том хэрэг мандаж Холбооны Засгийн Газар тэднийг шүүхэд өгсөн байна. Ийнхүү тамхитай холбоотой хэргүүдээр тамхи үйлдвэрлэгчдийн баширмаг маркетинг арга олны өмнө илэрч, хүмүүсийг тамхинд донтуулан, хэрхэн борлуулалтаа өсгөдөг болох, мөн дэлхий дээр хичнээн олон сая хүн тамхинаас болж нас барж байсныг тогтоов.

Хэдийгээр Америк улс үндэсний хэмжээнд тамхинд хориг тавиагүй байгаа ч, одоогийн байдлаар нийтдээ 12 муж улс болон хэдэн зуун хотууд олон нийтийн газруудад тамхи татахыг хориглоод байгаа ажээ. **Калифорнийн Сан Луис Овиспо хот** 1990 онд тамхины  эсрэг хуулийг авч хэрэгжүүлсэн дэлхий дээрх хамгийн анхны хот **(for each state)** болсон юм. Тэр цагаас хойш, 

12 муж улс уг хуулийг мөрдөж эхэлсэн ба 2006 оны 3 сард **Пүэрто Рикогийн**  газар нутагт хэрэгжүүлж эхэлжээ. **Флоридад**, нутгийн иргэд 2002 он гэхэд уг хуулийг батлуулж дөнгөсөн төдийгүй Мужийн Үндсэн хуулинд шууд нэмж оруулсан байна. Хэдийгээр шөнийн клубуудад хориг арга хэмжээг авах боломжгүй байсан ч, **Флоридагийн тамхины эсрэг аян** нийт дунд  сургуулийн тамхичин сурагчдыг 50%-иар, харин ахлах ангийн тамхичин сурагчдыг 35%-иар бууруулж чаджээ.

Хамгийн их үр нөлөө бүхий тамхины эсрэг хориг тавих арга хэмжээ 2003 онд дэлхийн санхүүгийн нийслэл хот, НҮБ-ийн төв байр байдаг **Нью Йорк Хотод**  болсон юм. Уг арга хэмжээ маш амжилттай явагдсан хэдий ч, хууль гаргагчид санхүүгийн уршигт үр дагаврын талаар халуухан маргалдаж байлаа. Хэрвээ хүмүүс зоогийн газруудад хооллохоо байчихвал яах вэ? Янжуурнаас саах татвар засгийн газраас явуулж буй бусад хөтөлбөрүүдэд сөрөг нөлөө үзүүлбэл яах вэ??? Харин 1 жилийн дараа хийсэн судалгаанаас дүгнэхэд, бизнэс эрхлэлтэнд эерэг нөлөө үзүүлсэн нь илт байсан ба зоогийн газруудын ажилчдын тоо нэмэгдэж, зоогийн газруудаас хураах татварын хэмжээ 8.7%- иар өсч, хүчин чадлын ашиглалт 100% болсон байв. Европт хийсэн ижил судалгаанаас харахад арга хэмжээ амжилттай болсныг давхар баталж байсан юм. Эцэст нь хэлэхэд хүмүүн биднийг тамхины хараалаас бүрэн чөлөөлөгдөж чадах эсэхийг зөвхөн цаг хугацаа харуулах биз ээ. 



Оюун Санааны Бясалгал, Дадал нь Гариг Ертөнцийг хайрлах дээд хэлбэр юм

Цаглашгүй Их Багш Чинхай АНУ-ын Нью Йорк хотод
ном айлдсан нь, 1999.08.04, /Англи хэлээр/ Видео бичлэг #664

А : Бид бясалгалаасаа гадна ямар тустай зүйл хийвэл эх дэлхийгээ илүү сайхан газар болгож чадах бол хэмээн бодож байлаа л даа. Эцсийн эцэст бид энд л амьдарч байгаагаас бүгдээрээ эх дэлхийгээ хайрлах нь зүйн хэрэг.

Б : Зөвлдөө. Таны сэтгэл зовж байгаа нь надад сайхан санагдаж байна. НҮБ-ийн гишүүд ч энэ талаар санаа тавих ёстой. Тэд бүгдээрээ сэтгэл зовниж явдаг эсэхийг би сайн мэдэхгүй ч, ядаж

та санаа тавьж байгаа нь сайхан хэрэг юм.

Тиймээс бид юу хийж чадах вэ? Хэдий би чадах бүхнээ хийсээр ирсэн ч хөгширч байна шүү/инээд/, бас миний дуу хоолой сулраад, олон хүн сонсохгүй байна. Гэхдээ зүгээрээ, тухайн цаг мөчид л зүйлийг хийж амжуулж байна. Магадгүй энэ гариг ертөнц дээрх хүмүүсийн оюуны цар хүрээг дээшлүүлэхийн тулд та олон удаагийн лекц уншиж болно. Таны хийж чадах зүйл бол энэ. Хэсэг зуур ч атугай хэрэг болно л доо, гэхдээ хүмүүсийн хүсэл зориг, анхаарал мөн үхэл, аюул гамшгаас айх айдас хүйдэс түргэн хугацаанд замхарснаа эргээд л эхэлдэг тул бид дахин дахин тэднийг сэнхрүүлэх хэрэгтэй болдог.

Гол нь олон улс үндэстнүүдийн удирдагчид энд нэгдэх ёстой юм. Оюун санааны бясалгал, дадлыг дэмжих хэрэгтэй. Даанч ихэнх сургууль, засгийн газрын систем нь материаллаг тав тух, хөрөнгө хуваарилалт болон тэдгээрт хэрхэн хяналт тавихад л үйлчилж байдаг. Бас болоогүй ээ, үүнийгээ ч тэд сайн хийж чаддаггүй шүү! Баян чинээлэг, юм юмтай улс орнууд маш олон байхад, үгээгүй хоосон ядуу буурай нь ч дэндүү олон байх жишээтэй. Тэгэхлээр, материаллаг зүйлс тэгш бус хуваарилагдсан байгаа биз.

Хэрэв хүмүүс арай оюунлаг байсан бол юмс өөр байж болох л байлаа. Өөрөөр хэлбэл дотоод чанартаа түшиглэж юмсыг ойлгоно гэдэг ухамсарт үйлдлийг бий болгож байдаг тул бидэнд ч мөн адил хүмүүст юу хийхийг хэлж заах хэрэггүй байх байсан. Харамсалтай нь улс төрийн ихэнх тогтолцоо - хууль тогтоол гаргах, материаллаг хэрэгцээ болон математик илэрхийлэл зэрэг юмсын физик шинж чанарыг илүүд чухалчилж үздэг учраас бидний бяцхан груш эсвэл би, та, бидний хэн нь ч хүч чармайлт гаргалаа гэсэн энэхүү гараг ертөнц дээр цөөнх хэсгийг бүрдүүлж буй мэт санагдана. Хэрвээ бүх улс үндэстний төр засгийн удирдагууд оюун санааны хүч чадлын ашиг тусыг ухаардаг, мэдэрдэг байсан бол бид бүгд арай илүү дэвшилттэйгээр амьдрахсан. Үүнийг л удирдан залах гэдэг юм шүү дээ, тиймээс нухацтай авч үзэх хэрэгтэй.

А : Тэд дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэе гэвэл оюун санааны үйл хэргийг хослуулах ёстой.

Б : Тийм ээ, учир нь оюун санаа гэдэг хамаг асуудлын үндэс юм. Засгийн газрууд ч байдгаараа хичээж байгаа. Чадах бүхнээ хийж байна гээд зөвхөн навчин дээр ургасан ургамлыг л услах юм даа. Мэдээж хэрэг бага боловч тус болно л доо гэхдээ аливаа ургамлын үндсийг усалж байх юунаас илүү чухал яагаад гэвэл илүү сайхан ургана шүү дээ. Тиймээс та бүхэн бүх ерөнхийлөгч нарт “Хүүе сэрээч, босооч, бүтээлч бай, бясалга” гэж хэлж болно.

Эрт дээр үеэс л бид иймэрхүү байдалтай зууралдсаар ирсэн. Харин та, би болон бусад номын ах эгч нар маань жаахан ч гэсэн хичээл зүтгэл гаргаж байна гэдэг тустай зүйл хийж байна гэсэн үг л дээ. Өөрөөр хэлбэл, тодорхой хэмжээгээр нэмэр болж л байгаа, хэрэв хэн ч хичээдэггүй байсан бол бүр долоон дор юм болохгүй юу. Хэрэв бид оюун санааны бясалгал, дадалдаа идэвх зүтгэл гаргадаггүй байсан бол дэлхий маань төдий чинээгээр бага адислагдах байсан. Магадгүй манай гариг хэдэн жилийн өмнө устан алга болох байсан ч юм бил үү. Аль эсвэл улс гүрнүүд утгагүй дайн дажин хийсээр бүр дэлхийн дайн гарах ч байсан юм бил үү. Хэн мэдлээ. Юу ч тохиолдож болно шүү дээ. ✨

Унгараас Ирүүлсэн Мэдээ

Хэцүүдсэн Тосгоныг Ивээсэн Их Багшийн Хайр Энэрэл

Унгарын мэдээллийн группээс /Унгар эхээр/

2006 оны 1 сарын 14-нд Унгарын Завшигтнууд Хорваттай хил залгаа орших Алсүсентмартон тосгон айхтар гачигдалд нэрвэгдсэн тухай мэдээг Будапештийн зурагт радиогоор олж үзжээ. Уг мэдээгээр жихүүн өвөл айлчлан ирснээр нутгийн ард иргэдийн амьдрал хэцүүдэж, хүйтний эрч заримдаа -20С°д хүрч чангаран, улмаар хоол хүнс болон дулааны хангамж зогсонги байдалд оржээ хэмээн мэдэгдсэн байна. Хүнд байдалд орсон тосгоны иргэдийн нөхцөл байдалд зовнисон авшигтнууд даруй маргааш өдөр нь орон нутгийн Католик буяны байгууллагын менежер Ланко Жозеф ламтантай уулзан ярилцаж, юуны түрүүнд Алсүсентмартон тосгоны 250 айл өрхөд хоол хүнс хүргүүлэх нь зүйтэй хэмээн шийдвэрлэжээ. Ийнхүү авшигтан ах эгч нар нийт 342,000 Унгар форинт буюу 1,650 ам.доллар зарцуулж 250 айлын тоогоор гурил, будаа, элсэн чихэр, гоймон, маргарин, наран цэцгийн тос, бөөрөнхий шош, вандуй, самар, үзэм ба бусад хүнсний бүтээгдэхүүн нийт 2 тонн орчим хоол хүнс, мөн тосгоны иргэдийг хооллох хүмүүнлэгийн гал тогооны багт шар буурцагны мах орлуулагч зэргийг худалдан авч өгсөн байна. Улмаар 1 сарын 21-ний хагас сайны өдөр авшигтнууд хоол дүүрэн ачсан 2 микроавтобусаар тосгоны зүг хөдөлсөн ба нутгийн Католик сүм дээр Ланко ламтантай уулзан хоол



хүнснийг уг сүмийн ариун зүйлс хадгалдаг өрөөнд буулгажээ. Удалгүй тосгоны хэдэн инээмсэглэсэн хөвгүүд ирж ачааг баяртайгаар буулгалцаж, уг сайхан мэдээг тосгоныхоо хүмүүст дуулган, мөн авшигтнууд дахин хоол хүнс худалдан авахаар явсан хойно Ланко ламтанд тусламжийн хоол хүнснийг тосгоныхонд тараахад туслажээ. Дараа нь авшигтнууд маань давс, печень, үрлэн гоймон болон хагас тонн орчим төмс зэргэлдээх Сиклос хотоос худалдан авсан байна. Ийнхүү номын ах эгч нар Алсүсентмартонд эргэн ирэхэд сүмийн өмнө дугаарлан зогссон урт цуваа болон сүмийн хашаанаас баяртайгаар ууттай хоол авч яваа хүмүүсийг харжээ. Сүмийн өмнө зогсох микроавтобусыг харсан хүмүүс тэр даруй ирж машиныг бүчин авсан бөгөөд авшигтнууд ч хоол хүнснийг яаравчлан хэдхэн минутанд аль болох олон хүмүүст тарааж дуусгасан байна. Гачигдалд орсон нутгийн оршин суугчид Их Багшийн хайр энэрлийг хүртсэндээ туйлын их баярлаж талархаж байсан бөгөөд авшигтнууд ч нутаг нэгтнүүддээ чин сэтгэлээсээ тусалсандаа үнэхээр их баяр жаргалтай байснаа мэдэрсэн юм. Тусламжийн хоол хүнснийг тарааж дууссаны дараа авшигтнууд Ланко ламтан болон нутгийн иргэдтэй салах ёс гүйцэтгэн Будапештийн зүг баяртайгаар хөдөлсөн байна. Гайхамшигт сайхан, сэтгэл хөдөлгөм үйл хэргийг бүтээхэд тусалсан Их Багш тандаа баярлалаа! ✨

МИЧИГАН

Детройтын орон гэргүй хүүхэд, эмэгтэйчүүдийг Тэнгэрлиг Зоогоор Дайлав

Мичиган, Хелен Гүо, Шерри Ванг, /Англи хэлээр/

2006 оны 1 сарын 7-12-нд Мичиганы төвийн авшигтнууд Их Багшийн тэнгэрлэг удирдамж дор Детройтын орон гэргүй эмэгтэйчүүд, хүүхдүүд байрладаг Генесис Хаус II ба III орогнох байранд зочлон, оршин суугчдыг тэжээллэг цагаан хоолоор дайлж, Их Багшийн хайр энэрлийг дамжуулжээ. Авшигтнуудын хийсэн хоолон дунд ногооны ороомог, салат, будаатай хуурга, гэрийн аргаар хийсэн өндөггүй жигнэмэг болон хангалттай хэмжээний жимс зэрэг байсан бөгөөд хүмүүст хоол их таалагдсан төдийгүй бүр нэмүүлэн идэж байсан юм. Тэр ч байтугай нэг эмэгтэй авшигтнуудад хандаж “Би хоолойнодоо тулгал идчихлээ” гэж хэлжээ. Цагаан хоолыг хоол хүнсэндээ хэрэглэх тухай үзэл санаа уг ажиллагаанд оролцсон хүмүүст таалагдсанд номын ах эгч нар үнэхээр баяртай байсан төдийгүй тус хоргодох байрны захирал хүртэл Их Багшийн зураг болон видео бичлэг лекцийг хүмүүс оройн хоол идэж байх үеэр үзүүлэхийг зөвшөөрсөнд талархаж байлаа. Улмаар Их Багшийн видео бичлэгийг үзүүлж эхлэхэд хүмүүс илт сонирхож байсан нь мэдрэгдсэн ба дараа нь нилээд хэдэн хүмүүс Дөхөм арга хэрхэн сурч болох талаар лавлахад, авшигтнууд тэдэнд Мичиганы төвийн тухай мэдээлэл болон хаягийг өгсөн ажээ. Түүнчлэн уг орогнох байранд бүхий л төрлийн шашин шүтлэгтэй хүмүүст зориулсан бясалгал/залбирлын нийтийн өрөө гэж бий бөгөөд тэр өрөөнд бясалгал хийж болно хэмээн авшигтнуудад дуулгасан байна.

Эцэст нь хэлэхэд Мичиганы төвийн номын ах эгч нар Их Багш маань тэднийг хайр энэрлийнхээ зэмсэг болгон сонгон адисласанд гүнээ талархаж байгаагаа илэрхийлж, Их Багшийн орон гэргүй хүмүүсийг хооллож ундлах ариун үйлсийг баяртайгаар үргэлжлүүлсээр байх болно хэмээж байлаа. ✨



КАЛИФОРН

“Өөрөөр Амьдарцгаая” Буурай Амьдралтай Нэгнээ Тэтгэх нь

Лос Анжелесийн мэдээллийн группээс (Англи хэлээр)

Зул сарын баярын улирлаар орон гэргүй хүмүүсийг хооллосон ариун үйлсээс санаа авч зурамшсан / уг мэдээг # 163 “хайрын илэрхийлэл”-ээс үзнэ үү/ Лос Анжелес төвийн авшигтнууд Өмнөд Калифорнийн орон гэргүйчүүд байрладаг хэд хэдэн орогнох газруудад цагаан хоолоор байнга үйлчилдэг болсон ажээ. Хамгийн эхнийх нь 2006 оны 1 дүгээр



сарын 20-ны хүйтэн орой Лос Анжелесийн өмнөд хэсэгт оршдог, испаниар голдуу ярьдаг Оранж Каунтийн оршин суугчид буюу Калифорнийн Санта Ана дахь нэгэн орогнох байранд болжээ. Авшигтнуудыг уг байранд орж ирэхэд маш олон гудамжны хүмүүс цугларсан байсан бөгөөд тэдэн дунд олон тооны эмэгтэйчүүд болон хүүхдүүд хоолны ширээний ойролцоох шалаар дэвссэн гудсан дээр хэвтэж байсан байна. Анх ядарч туйлдсан, цөхөрсөн харагдах тэдгээр хүмүүс авшигтан ах эгч нарыг харуутаа л Бурхны хайрын бэлгийг тэдэнд хүргэн ирсэн гэдгийг мэдсэн тул сэтгэл нь уярч царай нь гэрэлтэж байлаа. Дараа нь тэдний дундаас хэдэн хүн сайн дураараа хоол ундааг ширээн дээр засч тавихад авшигтнуудад тусалсан ба ойролцоогоор 170 зочид соёлтойгоор дугаарлан зогсч будаатай хуурга, ногооны өндгөн ороомог, төмсний салат, 1 ширхэг алим болон савласан цэвэр усыг Их Багшийн зурагнууд ба “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудастай хамт хүлээн авчээ. Орой бүр талх сүмсхэн мэтээр хооллож заншсан тэдгээр хүмүүс амт чанар сайтай цагаан хоолыг ихэд сайшааж, нэг мэдэхэд хүйтэн байсан орой халуун дулаан уур амьсгалаар дүүрч, Их Багшийн агуу хайраар бялхах нэгэн том айл гэрийн гишүүн болсон мэт хүн бүрт санагдаж байжээ.

Лос Анжелесийн авшигтнууд орон гэргүй хүмүүст хоол хүнс хүргэх үйл ажиллагааг 2 дахь удаагаа 2 сарын 17-нд зохион байгуулсан ба энэ удаад Санта Ана дахь Оранж Каунтийн Аврах Албаны Эрэгтэйчүүдийн орогнох байрны нийт 70 хүнд будаатай хуурга, ногоогоор хийсэн чихэрлэг, давсалсан тахиа, байцааны салат болон савласан цэвэр ус зэрэг орсон өдрийн хоолоор үйлчилжээ. Авшигтан ах эгч нарыг нөхөрсгөөр хүлээн авсан тус орогнох байрны менежер ноён Жефф Холлет хэлэхдээ: “Шөнө бүр манай байранд нийгэмд өөрийн гэсэн байр сууриа олохыг эрмэлзэж буй ажил хайсан 36 орон гэргүй эрчүүд хоноглодог. Түүнчлэн, Христийн шавь нарт зориулсан сургалт зэрэг үйл ажиллагаа явуулах болон орон гэргүй хүмүүст өглөө, өдөр, оройн хоол хийж үйлчилж байна”. Тус байгууллагын вэб

хуудсанд: ”Хүмүүсийн адилгүй хэрэгцээнд нийцүүлж Бурхан тэднийг хайрладаг гэдгийг Бурхны үгээр илэрхийлэх нь бидний зөнч хараа юм” гэжээ. Энэ нь ч тус байгууллагын хөгжилтэй, соёлтой халуун дулаан зантай ажилчид болон тэнд байрладаг орон гэргүй хүмүүсийн өөдрөг сэтгэлээс илт харагдаж байсан.

Жишээ нь, урьд нь гудамжны гэгддэг байсан Жозеф гэгч залуу одоо энэ орогнох байрны тогоочоор ажилладаг, тэрбээр өөрийн оюун санааны дэвшилтийн тухай: “Надад өгсөн энэ нандин бэлгийг би бусадтайгаа хуваалцмаар байна.” гэж хэлжээ.

Мөн авшигтнуудын дайлсан хоолны тухай Марисела гэгч эмэгтэй хэлэхдээ: “Би элэг муутай л даа. Харин шар буурцаг цус цэвэрлэж, жин барихад минь тусалж эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлдэг.”

Бусад зочид: “Цагаан хоол гэж хэлэхэд хэцүү юм. “Бидүүпүүнд дургүй л дээ, гэхдээ үнэхээр амттай байсан шүү. Жинхэнэ тахиа болон энэ хоолны хоорондын ялгааг би лав хэлж чадахгүй юм байна” гэжээ.

Зочдыг хоолоор дайлж дууссаны дараа авшигтнууд үлдсэн хоолыг авч явахаар савлан тараахад хүмүүс талархан хүлээн авсан байна. Түүнчлэн нэгэн номын ах байгууллагын нэгэн ажилтанд Их Багшийн “Өөрөөр Амьдарцгаая” зурагт хуудсын багцыг өгөхөд тэрбээр: “Маш их баярлалаа. Би үүнийг заавал хүмүүстээ тарааж өгнө өө гэсэн байна.”

Номын ах маань гэртээ харих замдаа уг ажиллагаанд оролцож чадаагүй нэгэн гэр оронгүй эмэгтэйтэй тааралдсан бөгөөд харин савласан хоол гарт нь байхыг харжээ. Эмэгтэй: “Би хоолонд орж чадаагүй л дээ. Гэхдээ харж байна уу. Бурхан намайг үргэлж харж байдаг. Энэ хоол үнэхээр амттай юм.” гэж хэлжээ.

Дээрх орогнох байруудад зохион байгуулсан буянт үйл хэргээс авшигтнууд Их Багшийн хайр энэрлийг Христийн дүрээр хуваалцан, үнэтэй хичээл сурсан төдийгүй Аврах байгууллагын ажилчдаас урилга хүлээн авсан бөгөөд ирээдүйд тус байранд үе үе зочлон цагаан хоолоор үйлчилж байхаар төлөвлөж буй ажээ. ✨

Пакистанаас Ирсэн Мэдээ

CNN-ээр мэдээ үзсэний дараа Их Багш Кашмирын газар хөдөлсөн цэг рүү тусламж илгээв.

Гамшигт өртөгсдөд Илгээсэн хайр

АНУ, Сингапур, Формосын мэдээний багууд, Эмхэтгэсэн мэдээ, /Англи, Хятад хэл дээр/

2006 оны 1-р сарын 29-нөөс 2-р сарын 2-ны хооронд эмнэлгийн анхны тусламжийн багийнхан Пакистаны газар хөдлөлтөнд нэрвэгдсэн газар нутгийн иргэдэд үнэгүй эмнэлгийн үйлчилгээ үзүүлж тусламжийн хүнс тараасны дараа /энэ талаар дэлгэрэнгүй сурвалжлагыг 163-р дугаараас үзнэ үү/ Формос, Хятад, Тайланд, Герман, АНУ болон Сингапур дахь Төгс Гэгээрсэн Их Багш Сума Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн гишүүд уг ажиллагааг үргэлжлүүлэх хүрээнд дахин баг бүрдүүлжээ.

2-р сарын 4-нд эмнэлгийн тусламжийн баг Пакистаны нийслэл Исламабадаас хойшоо 3 цаг гаруй явж хүрэх Мансехрад очиж нутгийн нэгэн зочид буудалд харилцах төвөө байрлуулжээ. Сингапурын авшигтнууд нэрвэгдэгсдэд зориулан шинээр худалдан авсан хувцас хунарыг баглаж янзлах хооронд эмнэлгийн тусламжийн ажлыг үргэжлүүлэхээр өмнөх багаас хоёр номын ах үлдсэн ба сүүлд нь нэгэн Герман номын ах ирж нэгдсэн байна. /Багшийн тусгай хүсэлтийн дагуу!/
2-р сарын 5-нд Кашмирын хөндлөн гулд орших нэгэн уулын арын жижигхэн тосгонд авшигтнууд аялалын хөтөчийн хамт очиж, харилцаа холбооны станц дээр түр зуурын эмнэлгийн пост гаргажээ. Эмнэлгийн тусламж хүссэн зуу гаруй хүн байснаас, зарим нь тусламжийн цэгт хүрэх гэж цаг гаруй, арайхийж явжирж байв. Шөнөдөө температур унаж хүйтрэх, цэвэр ус хүрэлцэхгүй гачигдах зэргээс болж ихэнх өвчтөн ханиад томуу тусч, ходоод гэдэс нь хямарч байсан байна. Үдийн алдад нэгэн авшигтан ах байшингийн хажууд чимээгүйхэн явган суух хэсэг гивлүүр унжуулсан эмэгтэйчүүдийг анзаарчээ. Өглөө эртээ ирсэн хэдий ч уламжлалт Мусульман зан заншлын дагуу постын өмнө бөөгнөрөх

эрчүүдээ хүндэтгэн оочерлон зогссонгүй, гагцхүү ээлжээ тэвчээртэйгээр хүлээж байсныг номын ах тэр үед мэджээ. Тиймээс эмнэлгийн тусламжийн багийнхан тосгоны зөвлөлийн даргаас үдээс хойш хүүхэд, хөгшид болон эмэгтэйчүүдэд хамгийн түрүүнд үйлчлэх болно гэдгийг зарлаж өгөхийг хүссэн байна. Ихэнх өвчтөнгүүд ижил шинж тэмдэгтэй байсан ба харин цөөн хэд нь даралт ихтэй ба чихрийн шижинтэй хүмүүс байв. Газар хөдлөлтийн дараа энэхүү алс бөглүү тосгонд авшигтан ах эгч нараас бүрдсэн эхний ээлжийн эмнэлгийн тусламжийн баг ирэх хүртэл нутгийн хүмүүс ханиад томуу тусч, ходоод гэдэс нь хямарсан ч, эмчилгээ хийлгэлгүй удсан тул өвчин нь ужгирсан байсан ба зарим хүүхдүүдийн хэвлий усжсан зэрэг яаралтай эмчилгээнд орох шаардлагатай болохыг тогтоожээ.

2-р сарын 6-нд Афганы хилийн орчим баруун хойд зүгт газар хөдлөлтөнд нэрвэгдсэн нутгаас дөнгөж долоо хоногийн өмнө Пакистаны Баруун Хойд Хил дээрх Гантианы ойролцоо голын хөндийд дүрвэн ирсэн нэгэн жижиг овгийн хүмүүсийн буудалласан газар тусламжийн багийнхан хүрчээ. Адилгүй аялгаар ярьдаг учир 4 өөр хэлээр орчуулга хийгдэж ойлголцож байсан нь эмнэлгийн

**As per Master's reminding extra detailed request!*



үзлэгийг нилээд хүндрүүлсэн байна. Хүмүүс нь ямар ч мөнгөгүй, үнэнхүү зовж зүдэрсэн улс байв.



Авшигтнуудын орчуулагчаар ажилласан эмэгтэй мөнхөтөчийн үүргийг гүйцэтгэж байсан ба нэг майхнаас нөгөө майхан руу явж

эмнэлгийн тусламжийн талаар эмэгтэйчүүдэд мэдээлж байлаа.

Эмнэлгийн тусламжийн багийн хоёр номын ах нэрвэгдэгсдийн бэлдсэн майхныг тохиромжгүй гэж үзсэн тул эмэгтэйчүүдийн байрласан хэсгийн баруун талд байсан арай том майхнаар сольсон нь эмэгтэй өвчтөнүүдэд илүү ая тухтай болов. Хэлний бэрхшээлийг эс тооцвол эмнэлгийн үйлчилгээг нягт нямбай гүйцэтгэснээр, нийтдээ 116 өвчтөнг эмчлэн, эм бэлдмэлээр хангаж улмаар “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг өвчтөнүүдэд тарааж түргэн эдгэрэхийг срөөжээ. Мөн ширээн дээр Багшийн жижиг зургуудыг дэлгэн тавихад олон хүмүүс авахыг хүссэн байна.

Ажлын баг гамшигт нэрвэгдсэн газруудад тусламж хангалтгүй байгаагаас гадна халуун сав, цахилгаан зуух, хивс, майхны чийдэн болон хоол хүнс хамгийн их хэрэгцээтэй байгааг орчуулагчаар дамжуулан мэджээ. Хоолоо ихэвчлэн гал түлж болгодог учир санамсаргүй гал алдсанаас болж, газар хөдлөлтөөс амиа авч үлдсэн зарим нэг нь галд өртөж байв. Орчуулагчийн хэлснээр, гал түймрийн аюулын хажуугаар удахгүй эхлэх борооны улирлаас үүдэн хуурай түлээгүй болох асуудал гарч, улмаар хоол хүнс, түлшний дутагдлаас болж хүмүүс өлсгөлөнгийн ирмэгт тулах нь хэмээжээ. Нилээд хэдэн удаа хэлэлцсэний эцэст авшигтнууд нэрвэгдэгсдэд хамгийн их хэрэг болох зүйлсийг тодорхойлох судалгаа явуулахын хамтаар бусад газар хөдлөлтөнд өртсөн газруудад эмнэлгийн тусламж үзүүлэхээр шийджээ. Дараа нь

номын ах, эгч нар гамшигт өртсөн бүс бүрт тараах халуун сав, усны сав, цахилгаан зуух, хивс, майхны чийдэн, хоол хүнсийг худалдан авч өгсөн байна.

2-р сарын 7-нд тусламжийн багийнхан Аттершэш дахь Мангал Манчид хүрэлцэн ирж ойролцоогоор 50 майхан босгож, 90-ээд хүнд эмнэлгийн тусламж үзүүлжээ. Тэдэн дунд нэгэн жаал хүү хэвлийдээ идээ, устайгаас болж хоолоо залгиж чадахгүй 2 сар шахам уйлж шаналсан гэх ба ээж нь маш их сэтгэлээр унасан байв. Орчуулагчийн өгүүлснээр, Пакистан ээжүүд хэд хэдэн хүүхдийг зэрэг өсгөдөг ба балчир нэг нь ийнхүү зэрэг өвдөж, эмчилгээ авахгүй удвал маш их дарамтанд ордог гэв. Харин тусламжийн багийнхан тэр эмэгтэйд эмнэлгийн тусламж авах боломжгүй тохиолдолд хэрэглээрэй хэмээн илүү хэмжээгээр эм бэлдмэл өгсөн юм.

2-р сарын 8-нд Аттершэш дахь Батангийн тусламжийн багийнхан дээр АНУ-аас эмч мэргэжилтэй номын ах эгч 2 авшигтан нэмэгдэн иржээ. Багийн гишүүд Их Багшдаа эмэгтэй эмч-Вьетнам номын эгчийг илгээсэнд гүнээ талархаж байсан ба учир нь эмэгтэй өвчтөнүүдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх зохимжит хүн их хэрэгтэй байсан юм.

2-р сарын 9-нд эмнэлгийн тусламжийн баг 2005 оны 10-р сарын 8-ны өдрийн томоохон газар хөдлөлтөөс хойш удаа дараалан газар хөдөлсөн Итчринд ирсэн байна. (нэг удаа бүр 10 секунд үргэлжилсэн хүчтэй газар хөдлөлт болсон байв).

10-р сарын газар хөдлөлтөөр 10 гэр бүлийн эрчүүдийг авч одсон золгүй явдлаас болж хөөрхий эхнэрүүд нь үр хүүхдүүдээ ганцаараа асарч тойлох хүндхэн үүргийг хүлээхэд хүрчээ. Тэр өдөр 160 орчим



хүнд эмнэлгийн тусламж үзүүлж, эм бэлдмэлийн хамтаар Багшийн гэрэл зурагтай наадаг цаас тараан өгөхөд хүүхэд багачуул баяр хөөртэйгөөр энгэртээ зүүсэн байна.



Кунхарын хөгжлийн байгууллага-Лагерын эмнэлгээс илгээсэн талархлын захидал.

Нийт 117 өвчтөнөөс ихэнх нь арьсны нэгэн төрлийн халдварт өвчин болох маажууртай байсныг нутгийн заншил ёсоор эрэгтэйг нь эрэгтэй эмч, эмэгтэйг нь эмэгтэй эмч үзэж эмчлэв. Эмэгтэйчүүдийг онцлон анхаарснаар олон эмэгтэйчүүд нарийн мэргэжлийн үзлэг, эмчилгээнд орох боломжтой болов. Эмч нарын хийсэн үзлэгээр нэрвэгдэгсдийн байдлыг тодорхойлоход чихний халдвар, ханиад томуу, хамар хоолойн халдварт өвчин, маажуур, бөөс, хоол боловсруулах ба шээсний замын өвчин, газар хөдлөлтөөс болсон өнгөн талын гэмтэл мөн булчин баясны янгинасан өвдөлт зэрэг нийтлэг шинж тэмдэг илэрсэн байна. Дараа нь авшигтнууд 2-р сарын 11-нд Аттершэшэд эхний удаа эргэж ирсний дараа тусламжийн барааг тарааж эхлэв. Нутгийн иргэд уутан хөнжлөөс илүү ердийн хөнжил хэрэглэх дуртайг авшигтнууд орчуулагчийн тусламжтайгаар мэдэж авсан ба удалгүй дулаан хөнжлийн хамтаар будаа, гурил, аяны чийдэн зэрэг нийт 220 хэсэг хоол хүнс, эд зүйлсийг авчирсан байна.

Дараа өдөр нь багийнхан Югийн уулархаг нутаг руу явжээ. Тэнд Мансехрагийн сонин сэтгүүл, телевизийн сурвалжлагч нар авшигтнуудаас сурвалжлага авч энэ тухай мэдээг орон нутгийн хэвлэл, телевизээр дамжуулсан байна. Мөн 115 хэсэг будаа, гурил, тосон цахилгаан зуух, хивс тараан

2-р сарын 10-нд тусламжийн багийнхан Тандейн Бажна ялагерт ирэхэд 60 майхан байсан бас сүүлийн удаа эмнэлгийн тусламж ирээд явснаас хойш 3 сар өнгөрсөн байсан тул хүмүүс багийнхныг хараад маш их баярлаж байв.

өгчээ.

2-р сарын 13-нд бясалгагч нар Мансехрагийн хөдөө нутагт 130 хэсэг тусламжийн бараа тарааж, үд дунд үлдсэн эмнэлгийн тусламжийн хэрэгслийг Кави Инчажийн лагерь дахь эмнэлэгт бэлэглэв. Үдээс хойш Лобер Кот болон Мангулдурад 234 шуудай будаа, гурил, 117 усны сав, цахилгаан зуухын хамт тараан өгчээ. Харин уг хоёр лагерьт үзүүлсэн тусламж дутагдалтай байсныг олж мэдсэний дараа лагерийн хүмүүст нэг бүрчлэн гурил будаа нэмж өгчээ.

Борооны улирал дөнгөж эхэлсэн 2-р сарын 14-ны өдөр багийнхан аян замдаа мордохдоо, нэрвэгдэгсдийг тосон цахилгаан зуухтай болгосон нь цаг үеэ олсон хэрэг болжээ хэмээн баяртай байв. Тэр өдөр авшигтнуудын орчуулагч эмэгтэй Багшийн үлгэр дэвтрийг хичээнгүйлэн гуйж, Багшийг Пакистанд хэзээ ирэхийг лавлан, улмаар Гуань Инь бүлгийг бусадтай адилгүй юм, хамгийн гол нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн бодит хэрэгцээг тодорхойлж үнэ өртөг, худалдан авах хүндрэлийг төдийлөн хайхраагүй ба зоог идээний урилгаас эелдгээр татгалзаж байсан зэрэг нь үнэхээр үнэлүүштэй байсан хэмээсэн юм.

Хэдийгээр нутгийн заншлыг хүндэтгэн нутгийнхны барьсан багахан идээ ундаанаас үе үе хүлээн авч байсан боловч өгсөн идээнээс илүү үнэтэй эд зүйлсээр хариу барьж байв. Ард түмэнд нь туслахаар алс холоос зорин ирсэн авшигтан ах эгч нарт орчуулагч маш их талархаж, газар хөдлөлтөнд өртсөн хүмүүсийн ихэнх нь бичиг үсэггүй тул боловсрол тэдний хувьд хамгийн хэрэгцээтэй зүйл мөнөөс мөн, харин газар хөдлөлтөөс хойш сургууль завсардах явдал ихэссэн нь харамсалтай хэмээн өгүүлжээ. Түүнчлэн, гамшиг болсон газруудад анги танхим хүрэлцээгүйгээс гадна сургуулийн ширээ сандал, бичгийн хэрэгсэл байхгүй зэрэг хүнд байдалд орсон байлаа. Тэрбээр цааш үргэлжүүлэхдээ, “Гамшиг болсон газруудад 4 сургууль сэргээн засах сан бүрдүүлэхийн төлөө би маш их явсан” гэжээ. Орон нутгийн 4 сургуулийн зохицуулагч байсан энэхүү орчуулагч эмэгтэй шиг сайн

дурын ажилтнууд Пакистанд цөөн байдаг бөгөөд түүний ачаар гамшигт нэрвэгдэгсдийн хамгийн их тулгамдсан хэрэгцээг хангах болон гамшигт өртсөн алс бөглүү газар нутгийн гачигдсан иргэдэд туслалцаа үзүүлэх ажиллагааг амжилттай явуулж чаджээ. Түүний удирдамжийн дагуу самбар, ширээ, сандал, бичгийн хэрэгсэл, үзэг, дэвтрийг 2 сургуульд нь зориулан худалдан авч өгчээ. Газар хөдлөлтөнд өртсөн газар нутагт сурах орчинг сайжруулах гэсэн энэхүү оролдлого оюутан сурагчдыг сургуульдаа эргэн ирэхэд урам зориг өгнө гэж найдаж байна. Пакистаны газар хөдлөлтийн хор хохирлыг багасгах ажиллагааны явцад авшигтнууд Пакистан хүмүүс хичнээн элгэмсэг, дотно болохыг мэдэрчээ.

2-р сарын 11-ний орой тусламжийн зүйлс тарааж байх зуур гэнэт бороо асгаж эхлэхэд, нутгийн иргэд өөрсдийн майхны чийдэнгээр гэрэлтүүлж, авшигтнуудыг борооноос хамгаалан хөнжил дэлгэж, зарим нь толгойн ороолтоо өгөөд өөрсдөө бороонд нэвт норсон байна. Мөн тусламжийн барааг хадгалахад тань туслая хэмээх чин сэтгэлтэй үйлдвэрлэгчид олон байсан бөгөөд улмаар 741 усны сав олж өгсөн нь шатам халуун наранд халсан халуун ус уух бэрх асуудлыг шийдэж өгсөн юм.

Тусламжийн багийг авч явсан жолооч ах эм бэлдмэлийг нунтаглах, хүмүүст эм бэлдмэлийг хэрэглэх заавар өгөх, дэг журмыг сахиулах болон бараа материал зөөх зэрэгт сайн дураараа даруухан гэгч нь тусалж байлаа. Тэрбээр Багшийн гэрэл зургийг маш их нандингаж, газар унасан наадаг гэрэл зураг бүрийг алдалгүй дээш нь авч байв. Мөн багийнхан шинэ газар руу хөдлөх бүрт, машиндаа Багшийн шар туузыг бөхлөөд өдрийн төгсгөлд авдаг байв. Аялалын турш Багшийн гэрэл зургийг сайтар харж хандан,

түүний зүрх сэтгэл аль хэдийнэ Багштай нэгдсэн гэдгийг авшигтнуудад ойлгуулжээ.

Энэхүү аяллын орчуулагчид дундаас 60 настай нэгэн ах, эмнэлгийн үзлэг бүрийн өмнө өвчтөнүүдээс нас, өвчний шинж тэмдэг, өвчин эхэлсэн цагийг асуун лавлаж байв. Тэрбээр тусламжийн багийнхантай салах ёс хийхдээ бүх хүмүүсийг гурвантаа чанга гэгчээр тэвэрч нүдэндээ доголон нулимстай үлдсэн юм. Түүний нутаг нэгтнээ хайрлах хайр, тэсвэр тэвчээр, ажилдаа хариуцлагатай хандах байдал зэрэг нь үнэхээр бахдам байв.



Пакистанд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэлийн ихээхэн хэсгийг авшигтан эмч нар бөөний үнээр нийлүүлсэн билээ.

Мөн эмнэлгийн эм бэлдмэлийн борлуулагч байсан зарим бясалгагч нар зарим нэг эмийг үнээр нь, мөн үнэгүйгээр өгч тусалсан. Гамшигт нэрвэгдсэн газарт биечлэн очиж чадахгүй байсан Формоса, Хонг Конгийн эмч авшигтнууд үнэгүй эм явуулах замаар өөрсдийн тусламжийн гараа сунгав. Ийнхүү энэ бүх тусламжийн үйл ажиллагаа гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах олон хүний хамтын хайрын хүч чармайлт боллоо.

Багшийн адислаливээлээр Пакистаны газар хөдлөлтөнд нэрвэгдсэн хүмүүст туслах үйл ажиллагаа ийнхүү хамгийн ахархан хугацаанд гүйцэтгэгдэж, хамтран бясалгагч ахан дүүс өөрсдийн оролцоогоор энэрэл нигүүлслээ хөгжүүлэх боломжтой болсондоо жаргалтай байлаа. Энэхүү явдлаас тэдний өөрсдийн амьдрал хичнээн адислалтай, элбэг дэлбэг болохыг ухаарч, өөрсдийн үйл хэргээр дамжуулан Багшийн хайрыг дэлгэрүүлэхийн гайхамшгийг амсав. ✨



Багшаас CNN-ийн Захирал, Сурвалжлагч Нарт Илгээсэн Захидал

Саяхан Багш CNN-ээр Пакистанд эмгэнэлт байдал үргэлжилсээр байгаа тухай дахин мэдээлэхийг олж үзжээ. Төдөлгүй Багш авшигтнуудад тусламжийн ажлыг үргэлжлүүлэхийг даалгасан бөгөөд улмаар энэхүү сурвалжлагыг бэлтгэсэн CNN-ийн хамт олонд талархлын захиа бичжээ.

2006. 03 12

CNN-ийн захирал болоод сурвалжлагч нарт.

Эрхэмсэг ноёд, хатагтай нараа,

Пакистан, Энэтхэг улсад болсон газар хөдлөлтийн дараа ард иргэд хэрхэн зовж зүдэрч буй тухай 2006 оны 1-р сард та бүхний бэлтгэн явуулсан сурвалжлагад талархлаа илэрхийлье. Юуны түрүүнд, олон улсын болон дотоодын тусламжийн байгууллагууд үнэхээр буянтай үйл ажиллагаа явуулжээ гэж бодсон хэдий ч тэдгээр золгүй хүмүүсийн зовлон шаналал миний анхаарлыг өөрийн эрхгүй татсан юм.

Тийм ч учраас миний өөрийн баг эхний ээлжийн тусламж хүргэсний дараа тэндээс явсан. Та бүхний байнгын сурвалжлага мэдээ болон ухамсарт сэтгүүл зүйн ачаар эргэн тойрон болж буй үйл явдлын талаар дэлхий нийтээрээ илүү ихийг мэдэж авдаг билээ. Тиймээс эмнэлгийн тусламж яаралтай шаардлагатай байгаа бүс нутаг руу миний бие эмч, сувилагч нараас бүрдсэн олон улсын эмнэлгийн багаа илгээсэн юм.

Та бүхний нэвтрүүлсэн мэдээ үнэн байв. Бүхий л насны зуу зуун хүмүүст эмнэлгийн тусламж маш их хэрэгтэй байжээ. Тусламжийн багийнхан маань алс бөглүү нутаг руу явж гамшигт нэрвэгдсэн хүмүүст наад захын хэрэгцээт тусламж хүргэхээс огтхон ч халшраагүй юм шүү.

Та болон танай телевизийн хамт олон хичнээн сайхан үйлс бүтээснээ мэдээсэй гэсэндээ энэхүү захиаг би бичиж байна. Кашмирын ард иргэдийн өмнөөс талархлаа илэрхийлье.

Улс үндэстнийг нэгэн том гэр бүл болгон холбож байдаг та бүхний уйгагүй хүч чармайлт, нөр их хөдөлмөр адислагдах болтугай.


Сайн сайхныг хүсье,



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Пакистаны газар хөдлөлтөнд өртсөн хүмүүст үзүүлсэн тусламж / Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай/

Тайлбар	Дүн (Пакистан Рупигээр)	Тооцооны хуудасны дугаар No.
Хоол хүнс (Хуурай сүү, овъёосон талх, будаа, гурил)		A1~A9
Хөнжил		B1~B3
Дулаан хувцас (хүүхдийн хүрэм, гутал, оймс)	348,845	C1~C7
Аяны хэрэгсэл (цахилгаан зуух, хувин, чийдэн, тос, бялт, хивс, ор)	626,008	D1~D8
Эмнэлгийн хангамж	105,424	
Тээвэр холбооны зардал	281,202	F1~F17
2 сургуульд сургалтын хэрэгсэл (сэнс, албан өрөөний сандал, бичгийн хэрэгсэл, зарлалын самбар, цагаан самбар ба дэвтэр)	46,080	G1~G4
Бусад (орчуулга, агуулах, виза, баннер)	178,167	
Бүгд:		Rupees 4,327,086 (US\$72,578)



Хэвлэл Мэдээлэл

Пакистаны Өдрийн Мэдээ Сониноос

(Урду хэл дээр)

2 сарын 15, 2006

Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг Газар хөдлөлтөнд нэрвэгдэгсдэд тусламж хүргэх ажиллагаа

[[Staff reporter] Саяхан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн гишүүд Их Багшийн зааварчилгааны дагуу хэдэн тэрбум рупитэй тэнцэх тусламжийн барааг Пакистаны газар хөдлөлтөнд нэрвэгдэгсдэд хүргэсэн байна. Багш маань олон жилийн туршид дэлхийн гамшигт өртсөн газар нутгуудад ийнхүү тусламжийн гараа сунгасаар ирсэн юм. Тэрбээр хүмүүнлэг оюун санааны дадал сургаалаа, түүний үйл хэргийн жишгээр бусдын сайн сайхны төлөө хичээнгүйлэн зүтгэж ирсэн бүлэг хүмүүст тусгайлан заан, тэднийг ариун ёсонд хөтлөн залж байдаг оюуны өндөр чадамжтай онцгой эмэгтэй билээ.

Гулназ Шах /Мансерха дүүргийн зөвлөлийн гишүүн/ “Ут нийгэмлэгийн гишүүд гамшигт өртсөн халуун цэг бүр лүү гэмтэж бэртсэн хүүхэд эмэгтэйчүүдийг эмчлэхээр эмч нар болон эмнэлгийн ажилтнуудын хамт хүрч очсон. Тусламжийн барааг (4 том усны сав, керосин плитка, пүүгээ, будаа, бусад хэрэгцээт зүйлс) тосгодоод хүргэхийн тулд өндөр ууланд аюулыг хайхралгүй мацаж явсан юм.”



Филиппинээс ирсэн мэдээ

Хөрсний Гулсалтын Гамшигт Өртсөн Хүмүүст Тусламж Хүргэхээр Аюулыг Сөрөн Явсан нь

Таююан мэдээллийн баг, Формоса, /Хятад хэл дээр/

2006 оны 2-р сарын 17нд Филиппиний төв хэсэгт олон хоног үргэлжилсэн ус ихтэй борооны уршгаар Өмнөд Лейтед хөрсний томоохон гулгалт явагдаж, хэдхэн минутын дотор хэд хэдэн тосгон үхэр чулуунд дарагдсан мэт шавар шавхайд живэв. Зарим газар лаг шавар 30 фут хүрч байжээ.

Энэхүү аймшигт явдал ариун Бернардын тосгон болон түүний зэргэлдээх суурингуудыг сүйрүүлж, нийт 3000 хүний амийг авч одов. Өнөөдрийн байдлаар ердөө 60 хүрэхгүй тооны хүмүүс амьд үлдэж, бусад нь одоо болтол олдоогүй байна. Гамшгийн талаар сонссон Багшийн сэтгэл зовж тэр даруй аврах ажиллагааг явуулахаар тогтов.

2-р сарын 20-нд Багшийн зааварчилгааг хүлээн авсан даруй Формосын авшигтнууд тусламжийн баг байгуулж, маргааш өглөө нь Филиппин руу илгээжээ. Авшигтнууд Манила дахь төвд ирэнгүүтээ эртний танил сенатор агсан ноён Мануэль Л. Морато, орон нутгийн сурвалжлагч ноён Жой Лад Сантос хоёртой уулзсан байна.

Тэр орой Ноён Сантос нөхцөл байдлыг хэлэлцэхээр төв дээр хүрэлцэн ирсэн ба тэрбээр Багшийг маш их үгүйлж санасан нь илт байв. Түүнчлэн, тусламжийн баг ноён Моратотой уулзахаар ирсэн зорилгоо тайлбарлахад, тэрбээр Филиппиний Буяны Свипетайкс Алба (PC SO)-ны Таклобан дахь салбар руу тэр даруй утасдсан бөгөөд

тус албаны гүйцэтгэх захирал, хатагтай Зэнни Делантарт өөрийн гараар захиа бичжээ.

Уг захидлаас тусламжийн багт гүн туслалцаа үзүүлсэн ноён Морато гуай урьд нь тус албаны(PCSO) захирал байсныг олж мэдсэн юм. Тэр шөнөдөө аврах багийнхан нэгэн зэрэг хоёр газарт тусламж хүргэхээр болсон ба 2 хуваагдан, нэг хэсэг нь Филиппиний төв хэсгийн Өмнөд Лейт руу хөдөлж, нөгөө хэсэг нь өмнө зүгт орших



Замбоанга хот руу хөдлөв.

Өмнөд Лейте

2-р сарын 22-нд хатагтай Делантар гамшигт нэрвэгдсэн нутаг дэвсгэр рүү тусламжийн багийг авч явжээ. Тэднийг хотын захиргааны газрын нарийн бичгийн дарга дагалдан явсан бөгөөд багийн гишүүд гамшиг болсон газар нутгийн байдалтай танилцаж, оромж бүрээр хохирогчийн тоог гаргаж, хэрэгцээтэй байгаа зүйлсийг



тэмдэглэж авав. Гамшгаас болж орон гэргүй болсон тэдгээр хүмүүст өдөр тутмын хэрэглээний эд

зүйлс нэн даруй шаардлагатай байгаа нь илт байлаа.

Ийнхүү дараагийн хэдэн өдрүүдэд PCSO -ны сайн дурын ажилтнууд авшигтнуудад тусламжийн барааг худалдан авахад туслан, нэрвэгдэгсдэд халуун сэтгэлээр хандсан нь олон хүний зүрх сэтгэлд хүрсэн юм. Улмаар бодит үнийн дүнг судлах, тохиролцож бууруулан, хямд үнээр барааг худалдан авах зэргээр Их Багшийн хувь оруулсан цент бүрийг үр ашигтайгаар зарцуулахад ихээхэн чармайлт гаргаж ажилласан.

Авшигтнууд тусламжийн барааг худалданавсандаруйдбоожбаглан, хоёртом ачааны тэргийг дүүртэл нь ачиж, маргааш өглөө нь гамшигт өртсөн цэг рүү хүргэж өгөхөд бэлэн болгосон юм. Маргааш өглөө нь гамшигт эцэг, эхээ алдсан хүүхдүүдийн байрлах Ариун Бернардийн Христийн ахлах сургууль, Нэгдсэн Христийн Сүм

болон Хүүхдийн Найрамдлын сургуулиуд дээр байгуулсан түр орогнох байруудад тусламжийн барааг тус тус хүргүүлэв.

Сан Жуан хотын захирагч тусламжийн багийнхантай хамт явж, шаварт булагдсан Ариун Бернардийн Сан Жуаны ахлах сургуулийн захирал, хадагтай Расел Р.Кювартай уулзав. Тусламжийн багийнхны үйл ажиллагаанд сэтгэл нь уярсан тэрбээр, нүд дүүрэн нулимстайгаар “Их Багш Чин Хай хүүхдүүдэд ийнхүү тусалсанд би маш их баярлаж байна” гэж хэллээ. Дараа нь тусламжийн баг эмнэлэгт буй гэмтэж бэртсэн 16 хүнд тусламжийн барааг хүргэхээр очсон юм.

Тусламжийн барааг тарааждууссаны дараачийн өдөр буюу 2-р сарын 25-нд багийн гишүүд Манилад эргэн ирсэн бөгөөд тэр даруй Ноён Моратогийн ажил руу гүн талархлаа илэрхийлэхээр явсан билээ. Их Багшийн буянт үйлсийг өндрөөр үнэлсэн Ноён Морато хэлэхдээ: “Би Багшийгаа их санаж байна... Багш маань нэгэн нартай өдөр Филиппинд ирнэ гэдэгт найдаж байна” гэжээ.

Замбуанга

Филиппиний өмнөх хэсэгт орших Замбуанга нутгийн ядуу буурай оршин суугчид ихтэй, уурхайчид олноор амьдардаг уулархаг Байяог орчим газар нуралт дэндүү ноцтой явагджээ. 2-р сарын 19-нд орсон ширүүн борооноос болж газар нуран, маш олон байшинг дарж сүйтгэсэн бөгөөд орон гэргүй болсон хүмүүст гадны тусламж нэн даруй хэрэгтэй болсон байна.

Тусламжийн багийнхан 2-р сарын 22-нд Замбуангад хүрч ирсэн ба азаар орон нутгийн ТВ-ийн суваг ABS-CBN-ны мэдээний албаны дарга, хатагтай Лорайтай уулзсанаар



Байогын захиргааны газрын зөвлөх ноён Мартиастай шууд холбоо барьж чаджээ. Ноён Мартиас утсаар хэлэхдээ: Гамшигт өртсөн газар майхан, эмнэлгийн хэрэгсэл маш их хэрэгтэй байгаа болон юуны түрүүнд 15 төрлийн эм бэлдмэл ба 4 ширхэг 50 метрийн урттай майхан барих сунадаг брезент худалдаж авч өгвөл туйлын хэрэгтэй байгааг дуулгажээ.

Хатагтай Лорайда сэтгэл гаргаж майхан үйлдвэрлэгчид болон эмийн үйлдвэрүүдтэй тусламжийн багийн өмнөөс сайн дураараа холбоо барьсан нь шинэлэг зүйл байлаа. Түүнчлэн, алс холоос нутаг нэгт ах дүүс нарт нь туслахаар зорин ирсэн авшигтан ах эгч нарын хүнлэг сэтгэлд уярсан хатагтай Лорайдагийн таньдаг бизнесменүүд, худалдан авсан тусламжийн бараа бүтээгдэхүүнд хямдрал үзүүлжээ.

Маргааш өглөө нь тусламжийн багийнханд гамшигт өртсөн цэг рүү хөдлөхийн өмнөхөн зам жип машин явахааргүйгээр эвдэрч муудсан тухай мэдэгдсэн байна. Харин авшигтнууд бараа материалаа уулын мотоциклд ачиж эрсдэлтэй аялал хийхээс өөр аргагүй байдалд оржээ. Зам зарим хэсгээрээ дэндүү нарийхан байсан тул хүмүүс урагшлахын тулд хажуу талаараа мөлхөх хэрэгтэй болж байлаа. Тусламжийн бараан дотор эм тариа яваа гэдгийг Филиппиний засгийн газар мэдээд эмнэлгийн ажилтнуудыг тусламжийн багийнхантай хамт явуулсан юм.

Маш их хүнд бэрхшээлтэй зам туулж зорьсон газартаа хүрсэн хэдий ч түр эмнэлгийн постыг тэр даруй байгуулж эмнэлгийн үзлэг хийж эхэлсэн байна. Харин үзлэгт хамрагдсан хүмүүсийн ихэнх нь ханиад томуу туссан болон ходоод гэдэсний хямралд орсон байжээ. Байгалийн гамшигт үзэгдэл байнга шахуу тохиолдож байдаг тус нутгийн оршин суугчид, тэдэнд хүмүүнлэг тусламж хүргэхээр зорин ирсэн хамгийн анхны олон улсын тусламжийн баг болох Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн багийнхныг хараад маш

их гайхаж, баярлаж талархан, улмаар хүндэтгэлтэйгээр хүлээн авсан юм.

Филиппинд тусламжийн үйл ажиллагаа явуулах үеэр авшигтнууд “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг онгоцны буудалд болон аяллын явцад тааралдсан хүмүүст тарааж байлаа. Ерөнхийдөө хүмүүс нааштай хандаж байсан.

Аяллын турш хэцүү бэрхшээлтэй тулгарч, аюул осолд орж болох байсан хэдий ч тусламжийн багийнхан үйл ажиллагаагаа 5 өдрийн дотор амжиж дуусгасан юм. Ийнхүү Их Багшийн маань хайр, адислалын хүчинд ажиллагаа амжилттай явагдаж чадсан. Авшигтнууд гамшигт өртсөн хүмүүст тусламж хүргэж байхдаа, Багш тэдний хажууд чимээгүйхэн бүгдийг зохицуулж байсан гэдэгт итгэлтэй байсан юм. ✨



Тодорхойлолт захидал

(Англи хэлээр)

Хатагтай Делантр Зени
ПДО Таклобан хот


Фатама тосгон, Барангай-77
Марас Банас, Таклобан хот, Филиппин

Хүндэт Зени,

Ноён Ло болон Юу нартай хамт явж ажилд нь тусална уу. Тэдний удирдагч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхийн олон улс орны зовж зүдэрсэн ард иргэдэд тусалсаар ирсэн, миний эрхэм дотны анд нөхөр бөгөөд түүний буяны үйл хэрэг олон улсын хэмжээнд маш их нэр хүндтэй билээ.


Талархан хүндэтгэсэн,

M. Muramoto



Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай болон түүний Олон Улсын Нийгэмлэгээс Филиппиний гамшигт өртсөн ард түмэнд хүргэсэн тусламжинд зарцуулсан нийт зардал

Нар төрөл	Үнийн дүн(Филиппин песо-гоор)	Тооцооны хуудас
Брезент	33,582.77	A1
Хоол хүнс (хуурай сүү, жигнэмэг, чихэр, элсэн чихэр)	174,265.00	B1~B2
Өдөр тутмын хэрэглээ (цахилгаан зуух, хувин, шаазан аяга, ариун цэврийн иж бүрдэл, хутга, дотуур хувцас, шаахай)	903,463.50	B2,B3
Эм тариа	34,620.90	C1~C2
Тээвэр шатахуун	72,900.00	D1~D5
Бүгд	Песо 1,218,832.17 (US\$23,620.78)	



Их Багш Чин Хайн “Мэдээ” сэтгүүлийн 164-дэхь дугаараас орчуулан
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгээс
эрхлэн гаргав.

Зөвшөөрөлгүй олшруулан хэвлэхийг хориглоно.

2006 оны 9 сар

Багшийн Хошигнол

Санаанд Оромгүй Төлбөр

Их Багш Чин Хай, Флорида, АНУ. 2003. 04. 02
/Англи хэлээр/ DVD# 754

Нэг хөөрхөн охин худалдааны төвд даавууны худалдагч дээр очоод “Би шинэ даапинз оёх материал авах гэсэн юм. Энэ материал ямар үнэтэй вэ?” гэж асуув.

Сахилгагүй худалдагч: “Нэг ярд нь нэг үнсэлт!” гэж хариулаад инээмсэглэв. “Болж байна. 10 ярдыг авъя” гэж охин хэлэв. Үнсүүлнэ хэмээн горьдсон худалдагч эр тэр даруй даавууг хэмжиж хуйлан, хурдхан бэлэн болгоод жуумалзаж зогсов. Охин боодлоо авангаа хажуудаа зогсож байсан жижигхэн өвгөнд:

“Өвөө та төлбөрөө хийчих” гэжээ. ✨



Нохойтой Хамт Одсон Номлол

Их Багш Чин Хай, Флорида, АНУ. 2003. 04. 02
/Англи хэлээр/ DVD# 754



Ламтан номлолоо ердийнхөөсөө 2 дахин бага хугацаанд буюу 10-хан минутанд тавьж дуусгав. Тэрбээр уучлалт гуйгаад хэлсэн нь: “Цаас идэх дуртай нохой маань номлолын талыг нь идчихсэн гэдгийг хэлэхэд тун харамсалтай байна. Тиймээс би номлолоо бүтнээр нь тавьж чадсангүй. Та бүхнээс хүшлэл өчье!” гэв.

Номлолын дараа өөр сүмээс ирсэн нэгэн хүн Номлогчтой гар барингаа хэлсэн нь: “Ламтан, хэрэв танай нохой чинь гөлөгтэй бол би нэгийг авмаар байна. Тэгвэл өөрийнхөө сүмийн номлогчид өгөх гэсэн юм!” гэжээ. ✨

Please visit the following websites to enjoy the original sound tracks of these jokes and you may share the joy of Master's humor with those around you: <http://www.Godsdirectcontact.net/eng/news/164/jk1.htm> (USA)
<http://www.Godsdirectcontact.org.tw/eng/news/164/jk1.htm> (Formosa)


Хуучин Цаг Үе (Вьетнам хэлээр)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, олонд танил яруу найрагчийн хувьд, өөрийн авьяас билгээрээ дэлхийн олон улс орны урлаг соёлын тавцанд шагшигдаж ирсэн билээ. Их Багшийн маань “Эрвээхэйн зүүд”, “Мартагдсан ой санамж” зэрэг шүлгүүд орсон өмнөх түүврүүдэд нь Америкийн нэр хүндтэй шагналт хөгжмийн зохиолчид болон Вьетнамын алдартай хөгжимчид гайхалтай сайхан ая хийсэн юм. Энэ удаад Их Багш Чин Хай хүмүүний амьдралын сайн сайхныг шүлгийн хорхойтнууд болон амьдралд хайртай хүмүүстэй өөрийнхөө туурвисан бүтээлийг “Хуучин цаг үе” цомгоороо харамгүй хуваалцаж буй нь энэ билээ. Багшийн шүлгүүд зүрх сэтгэлд ямагт гүнзгий сэтгэгдэл төрүүлж, уншигчдад энэ ертөнц дэлхий дээрх хүмүүний амьдралын зовлон гуниг, уйтгар харууслыг гүн гүнзгий мэдрүүлж байдаг юм. Энэхүү шүлгийн цомогтоо өдөр тутмын амьдралд тохиолдож байдаг ярвигт байдлаас хэрхэн тэсч үлдэх болон хүмүүн бид сэтгэлийн зовлон-гунигаасаа хэрхэн салж болох тухай шүлгүүдээрээ илэрхийлжээ. Их Багш Чин Хай шүлгүүдээ тайлбар зургуудтай гоёмсог хослуулснаар сэтгэл зүрхэнд маань итгэлийн галыг бадрааж Үнэн Ёсонд хүрэх бидний замд урам зориг нэмж өгчээ.

Багш Бид Хоёр

Амьдралын минь замнал төгсгөл болоход,
Тосоод авах нь ганцхан Багш л юм.
Ээлжит амьдралаа сонгоход минь замчилж,
Төрсөн гэрт минь хүргэж өгөх болно.
Түүнийг бүү гүтгээч, бүгдийг ухаарах тэрхэн агшинд
Түүнтэй чи нүүр тулан учрах болно,..
Хэрвээ Есүс загалмайд хадагдаж үхсэн гэж бодож байгаа бол,
Чи эндүүрч.
Тэр мөнхөд амьдарсаар ирсэн.
Бурхны хүү бусадтай л адил махан бисийн зовлонг амсдаг
Гэвч бүх Ертөнц түүний Хаант Улс
Багш бол хаадын Хаан юм.

~ Хуучин Цаг Үе Цомогоос



To order Master's publications, please contact:
The Supreme Master Ching Hai International Association Publishing Co., Ltd.,
Taipei, Formosa
Tel: (886) 2-87873935 / Fax: (886) 2-87870873
E-mail: smchbooks@godsdirectcontact.org
ROC Postal Remittance Account No.: 19259438 (for Formosa orders only)
Postal Account: The Supreme Master Ching Hai Publishing Co., Ltd.